



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН

МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2024 №1 (107)

Тус сэтгүүлийг ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн
санхүүжилтээр хэвлүүлэв.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал

ГИШҮҮД

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

Г.БАНЗРАГЧ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Н.БАЯРМАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ГАНГАБААТАР

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн

Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн ухааны доктор /Dr.jur./, дэд профессор, Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн захирал

Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор

РУДОЛЬФ ХЭЛМХАГЕН

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын
Бавари мужийн Пассау хот дахь Мужийн шүүхийн Ерөнхий шүүгч

ТАКАХАШИ АКИО

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДӨЛГӨӨН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Шүүхийн Судалгааны төвийн дарга

АГУУЛГА

I ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, СУДАЛГААНЫ ТОЙМ

Булган аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Азжаргал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд анхаарах зарим асуудал 5

Нагояа Их Сургуулийн Хууль зүйн их сургуулийн магистрант Э.Эрхбилгүүн

Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй дэх бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Япон улстай харьцуулах нь 14

Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Түвшинтулга
Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Г.Цэрэндэжид

Засаг даргыг огцруулсантай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ 29

Шүүхийн сахилгын хорооны гишүүн Б.Сугар

Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны түүхэн хөгжил 49

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

Улс төрийн намын бүртгэл хөтлөх талаарх Монгол Улсын зохицуулалтын өнөөгийн байдал болон гадаадын зарим улсын туршлага: Харьцуулсан судалгаа 77

II МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ /ЭХ СУРВАЛЖ, ОРЧУУЛГА/

З.Гэрэлмаа

Хятадын цахим шүүхийн хувьсгал 111

III ДУРДГАТАЛ

Өдөр болгон од харвадаггүй (Ц.Амарсайхан андаа дурсахуй) 128

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНД НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛЖ, БЭХЖҮҮЛЭХЭД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

**SOME ISSUES TO CONSIDER IN GATHERING AND STRENGTHENING
EVIDENCE IN CRIMINAL PROCEEDINGS**

Д.Азжаргал¹

- I. Удиртгал
- II. Үндсэн хэсэг
 - 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх тухай
 - 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг
 - 3. Шүүхийн практикт хийсэн судалгаа
- III. Дүгнэлт
- IV. Ном зүй

¹ Булган аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн магистр /LL.M./



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛЖ, БЭХЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.АЗЖАРГАЛ, Булган аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн магистр /И.М./

Түлхүүр үг

Олон улсын гэрээ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх, нотлох баримт, хүний эрх

Хураангуй

Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн гэм буруутай эсэхийг тогтооход нотлох баримтад үндэслэн тогтоох нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим билээ. Хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж цуглуулж, бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх талаар эрүүгийн хууль тогтоомжид заасан хэдий ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан тухайн баримтыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь нотлох баримтаар тооцож болохоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зохицуулсан нь Олон улсын гэрээ, нотлох баримтын зарчимтай зөрчилдсөн эсэхэд дүгнэлт өгсөн болно.

I. Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар

шүүхэд гомдол гаргах ... нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй” гэж заасан бол Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 69 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг зөрчиж авсан нотлох баримтыг хүлээн авахгүй байх талаар зохицуулжээ. Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын гэрээний зүйл заалтад формаль хуулиудыг¹ нийцүүлэх үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй² зарчмыг хуульчилсан боловч хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нотлох баримтаар тооцож болох эрхийг шүүхэд олгосон нь Олон улсын гэрээний заалт болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нотлох баримтын зарчимтай зөрчилдсөн эсэхийг тодорхойлохын тулд энэхүү сэдвийг сонгон судаллаа. Энэхүү

¹ Формаль хууль гэдэг нь хууль тогтоох байгууллагаас батлан гаргадаг хуулийг ойлгоно. /Д.А/

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 16.1 дүгээр зүйлийн 16.1.7 “Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй.”



өгүүллийг бичихэд хууль зүйн судалгааны үндсэн аргууд болох баримт бичиг судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан судлах аргуудыг ашигласан болно.

Сэдвийн судлагдсан байдал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох ажиллагаа явагдах үе шат талаас нь Хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбаа³, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Ж.Эрхэсхулан нарын хамтын бүтээл⁴, Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан⁵ нарын бүтээлүүдийг дурдаж болно. Мөн дээрх эрдэмтэд өөрсдийн бүтээлээрээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх нь нотолгооны үе шат болох талаас нь судалсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ эрдэм шинжилгээний өгүүлэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд олон улсын гэрээ, нотлох баримтын зарчмыг удирдлага болгоход тулгамдаж буй асуудлын талаар хөндсөн нь бусад судалгааны ажлаас шинэлэг болсон.

II. Үндсэн хэсэг

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх тухай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтнаас гарах аливаа шийдвэр, түүний дотор шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн тогтоох ажиллагаа зөвхөн нотлох баримтад үндэслэсэн байх ёстой

ба нотлох баримтын тухай асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол тулгуур ойлголт ямагт болж байдаг⁶. Нотлох баримт нь *нэгдүгээрт*, хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх; *хоёрдугаарт*, хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан байх, *гуравдугаарт*, баримтат мэдээлэл байх гэсэн үндсэн шинжийг агуулдаг онцлогтой. Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг тогтоохын тулд нотлох ажиллагааны тодорхой үе шатыг дамждаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтад үндэслэн эрүүгийн хэргийг үнэн зөв шийдвэрлэх, бодит байдлыг бататган буулгахын тулд болж өнгөрсөн үйл баримтыг нотлох баримтын тусламжтайгаар тогтоох, танин мэдэх, баримтжуулах үйл ажиллагааг⁷ нотолгоо гэж ойлгодог. Нотлох ажиллагаа нь нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх үе шатыг дамжин явагддаг⁸.

Нотолгооны үе шат нь баримт цуглуулах, бэхжүүлэх үе шатыг дамжих ба энэ үе шатанд зөвхөн ямар нэг хэрэг учрал болсон гэх анхан шатны мэдээлэл байгаа учир шууд сэжүүр дэвшүүлэх боломжгүй⁹. Учир нь сэжүүр, таамаглал дэвшүүлэн түүндээ хөтлөгдвөл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой алдаа гаргах магадлалтай. Цуглуулсан бүх баримтаа бичгээр эсхүл техник хэрэгслийн тусламжтайгаар буулган

³ Ж.Бямбаа, Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд, 2008.

⁴ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, 2018.

⁵ Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, 2020.

⁶ Ж.Бямбаа, Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. 2008, 125 дахь тал.

⁷ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, 2018, 152 дахь тал.

⁸ Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, 2020, 145 дахь тал.

⁹ Хууль зүйн яам, "Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах" төсөл, Нотолгооны онол /гарын авлага/. 2013, 28 дахь тал.



бэхжүүлж, бэхжигдээгүй баримт нотлох чадваргүй байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлэх¹⁰ ба энэ ажиллагааг нэг талаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын аргаар болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад аргаар гэсэн хоёр аргаар явуулдаг. Бусад аргаар гэдэг нь гэмт хэргийн талаар иргэн, аж ахуй нэгж байгууллагаас сайн дураараа мэдээлэл ирүүлэх, баримт сэлт гаргаж өгөх замаар нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэхийг ойлгох юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг тогтооход нотлох баримт ихээхэн үүрэг гүйцэтгэдэг боловч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүх нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөггүй¹¹. Учир нь хүний эрхийг зөрчсөн болон хууль бус аргаар цуглуулсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцдоггүй нь нотлох баримтын зарчимтай холбоотой.

Яллагдагч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах эд зүйл, баримт бичиг, үзлэг хийсэн тэмдэглэл гэх мэт хэргийг илрүүлэхэд шаардлагатай зүйлийг нотлох баримт

гэж үздэг. Хууль бус арга, албадлагын хэрэгслээр цуглуулсан нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар тооцож болохгүй¹² ерөнхий зарчим үйлчилнэ. Нотлох баримтад тавигдах шаардлагын талаар харьцуулсан судалгаанаас үзэхэд БНСУ-ын эрүүгийн процессын тухай хуульд нотлох баримтын зарчимд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл үндэслэлтэй, эргэлзээгүй нотлох баримтаар нотлогдох¹³, нотлох баримтыг шүүгч өөрийн үзэмжээр үнэлэх¹⁴, хууль бусаар олж авсан нотлох баримтыг хасах¹⁵, шүүгдэгчийн эсрэг нотлох баримт¹⁶ буюу шүүгдэгчийн мэдүүлэг нь түүний эсрэг цорын ганц нотлох баримт болвол нотлох баримтаар тооцохгүй гэх мэт нотлох баримтын зарчмыг тусгасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглох¹⁷, хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй¹⁸ байх зарчим үйлчилж байна. Мөн хуулийн 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцэж байгаа эсэхийг харгалзан бүхэлд

¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) 16.14 дүгээр зүйлийн 16.14.1 "Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ."

¹¹ M.Nahashon and P.Ng'ang'a, "Inadmissible evidence in Criminal Proceedings," academia.edu, 2021, 1. https://www.academia.edu/49152833/INADMISSIBLE_EVIDENCE_IN_CRIMINAL_PROCEEDINGS (Last visited 30 Dec 2023)

¹² Code of criminal of the Czech Republic 141/1961 Coll. (1961), Sect. 89.3.

¹³ Criminal procedure act of the Korea (1954), art. 307.

¹⁴ Criminal procedure act of the Korea (1954), art. 308.

¹⁵ Criminal procedure act of the Korea (1954), art. 308.2.

¹⁶ Criminal procedure act of the Korea (1954), art. 310.

¹⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 16.1 дүгээр зүйлийн 16.1.6

¹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 16.1 дүгээр зүйлийн 16.1.7



нь, эсхүл зарим хэсгийг нь, тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж 1) санал, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах; 2) бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нотлох баримтаар тооцохгүй байх; 3) тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нь нотлох баримтаар тооцохгүй байх шийдвэр гаргахаар зохицуулжээ.

Шүүхийн практикт Гүйцэтгэх ажлын тухай хуулийн дагуу олж авсан нотлох баримтыг хэргийн оролцогчоос нууцлах тохиолдол өмнөх эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг дагаж мөрдөх үед цөөнгүй гарч байсан бол 2017 оны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байхаар¹⁹ заасан. Өөрөөр хэлбэл, хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх, хэргийн оролцогчоос нууцлахгүй²⁰, харин хэргийн бусад оролцогчид, хөндлөнгийн этгээдээс нууцлах агуулгатай юм.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг

Хүний эрхийн биллийн²¹ үндсэн

¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 16.8 дугаар зүйлийн 16.8.1

²⁰ Монгол Улсын дээд шүүхийн 2019.11.18-ны өдрийн 588 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэг

²¹ Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгч механизмыг тогтоосон олон улсын хүний эрхийн баримт

баримт бичгийн нэг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлд зааснаар хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

Монгол Улс 1998 оны Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм /цаашид "Ромын дүрэм" гэх/-д нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх²² Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Ромын дүрмийн зүйл, заалтыг хэрэгжүүлэх олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй. Ромын дүрмийн 69 дүгээр зүйлийн 7-д дүрмийн заалт буюу олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг зөрчиж авсан нотлох баримтыг хүлээн авахгүй²³ гэж заасан байдаг²⁴.

3. Шүүхийн практикт хийсэн судалгаа

Шүүгдэгч О нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа бусдаас хахууль авах, Ц, Э нар нь хахууль өгөх гэмт хэрэгт тус тус холбогджээ. Анхан шатны шүүхээс О-г нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ

бичиг буюу Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын олон улсын пактыг хүний эрхийн билл гэж нэрлэдэг. /Д.А/

²² Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг

²³ Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1998)-ийн 69 дүгээр зүйлийн 69.7 дахь хэсэг

²⁴ Wojciech Jasiński, "Admissibility of Illegally Obtained Evidence in Proceedings before International Criminal Courts," Koninklijke Brill NV, Leiden, 2016, 201.



хэрэгжүүлээгүйн хариуд хахууль авсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, Ц, Э нарыг 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулан хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн²⁵ байна.

Шүүгдэгч нарын зүгээс анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан ба сэжигтнээр мэдүүлэг авахдаа 16 цагийн турш тасралтгүй байцаасан, сэжигтнээс мэдүүлэг авахдаа айлган сүрдүүлж, хууран мэхэлж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцсон, эрүү шүүлт тулгасан гэж маргажээ.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэрэгт нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр прокурорт буцааж шийдвэрлэсэн байна. Учир нь эрүү, шүүлт хүнлэг бус харьцаанаас ангид байх зарчмууд болон хуулийн заалтуудыг зөрчсөн эсэх талаар шалгаж, шүүхээс дүгнэлт хийх боломжоор хангах нь зүйтэй²⁶ гэж үзжээ. Дээд шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн бөгөөд ингэхдээ холбогдогч нараас мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд нь хохирол учруулах арга хэрэгсэл хэрэглэсэн, айлган

сүрдүүлсэн, дарамталж мэдүүлэг авсан гэх буюу Үндсэн хуулийн суурь зарчим, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим зөрчигдсөн байж болзошгүй талаарх оролцогч нарын удаа дараагийн гомдолд дурдсан зүйлсийг хянан шалгах, холбогдох шалгалт явуулах шаардлагатай²⁷ гэжээ.

Мөн шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын нотолгооны ач холбогдол, хамаарал, хууль ёсны байдлыг хянан үзэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тодорхой үндэслэл, журмын заалтыг хангагдсан эсэхэд дүгнэлт хийхийн зэрэгцээ нийтлэг зарчмуудын агуулгад нийцсэн эсэхийг хянан үзэх үүрэгтэй байдаг тул хэрэгт авагдсан нотлох баримтыг нэг бүрчлэн, түүний дотор мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцоход хуулийн шаардлага нэгэн адил тавигдах талаар дурдсан байна.

Үүнээс дүгнэж үзвэл, шүүх хэргийг шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан нотлох баримтыг үнэлснээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргах, хэргийн бодит байдалд нийцээгүй дүгнэлт гаргах эрсдэл үүсдэг байна. Хуульд заасан журмыг зөрчиж авсан нотлох баримт нь хүний эрхийг зөрчиж байдаг тул нотлох баримтын чанараа алддаг гэдгийг ойлгох нь зүйтэй.

IV. ДҮГНЭЛТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах үүргийг тухайн хэргийг мөрдөж буй

²⁵ Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 211 шийдвэр

²⁶ Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 691 магадлал

²⁷ Улсын дээд шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 588 тогтоол



мөрдөгч хэрэгжүүлдэг онцлогтой. Нотлох баримт хууль ёсны байх шаардлагыг хангахын тулд нотлох баримтын зарчмыг удирдлага болгох, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн байх нь хүний эрхийг хангах, хэрэг үнэн зөв шийдэгдэх чухал алхам болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нотлох баримт хуулийн шаардлага хангах суурь зарчмыг тусгасан байна. Тухайлбал, нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглох, хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй байхаар зохицуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотой. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр хүний эрхийг зөрчиж цуглуулсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхаар тусгасан ба олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх үүрэгтэй.

ЭХХШТХ-ийн 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан нотлох баримтаар тооцож болох талаар практик хэрэглээнд ойлгож хэрэглэж байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогчоос нотлох баримтаар тооцохгүй байх тухай хүсэлт нь хууль зөрчин цуглуулж, бэхжүүлсэн тохиолдолд шүүх нотлох баримтаар тооцохгүй байх, хууль зөрчөөгүй гэж үзвэл хүсэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргах юм. Хуулийг зөв ойлгож хэрэглэх нь хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдах, шүүхийн практик тогтооход чухал ач

холбогдолтой. Харин хүний эрхийг зөрчиж авсан нотлох баримтыг шүүх нотлох баримтаар тооцсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил болдог онцлогтой.

V. НОМ ЗҮЙ

A. Монгол эх сурвалж

1. Ж.Бямбаа, *Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд*, 2008.
2. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, *Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал*, 2018.
3. Д.Баярсайхан, *Эрүүгийн процессын эрх зүй*, 2020.
4. Хууль зүйн яам, "Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах" төсөл, *Нотолгооны онол /гарын авлага/*, 2013.

Б. Гадаад эх сурвалж

1. M.Nahashon and P.Ng'ang'a, "Inadmissible evidence in criminal proceedings," University of Embu School of Law, 2021.
2. Benedikt Jugl, "Fair trial als grundlage der beweiserhebung und Beweisverwertung im Strafverfahren," Schriftenreihe Deutsche Strafverteidiger e.V., 2016.
3. Wojciech Jasiński, "Admissibility of Illegally Obtained Evidence in Proceedings before International Criminal Courts," Koninklijke Brill NV, Leiden, 2016.



В. Эрх зүйн эх сурвалж

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948).
2. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1998).
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017).
4. Бүгд найрамдах Чех улсын эрүүгийн процессын тухай хууль (1961).
5. Бүгд найрамдах Солонгос улсын эрүүгийн процессын тухай хууль (1954).

**Abstract****SOME ISSUES TO CONSIDER IN GATHERING AND STRENGTHENING EVIDENCE IN CRIMINAL PROCEEDINGS****D.AZJARGAL***Master of Laws (LL.M.)**Chief Judge of the criminal and civil appeal court of Bulgan province*

Evidence plays a significant role in establishing the guilt of a criminal, but not all evidence gathered and strengthened during criminal proceedings is admissible. Because the evidence collected and strengthened in violation of the grounds and procedures provided by the law is a violation of human rights, so it is regulated by the Law on International Agreements and Criminal Procedure that it should not be considered as evidence. However,

taking into account whether the collected and strengthened evidence in violation of the grounds and procedures specified in the law is in line with the objectives of the criminal proceedings, the whole or some part of it can be considered as evidence.

Keywords

International agreement, criminal proceedings, the court, evidence, human right.

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ЭРХ ЗҮЙ ДЭХ БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА: ЯПОН УЛСТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ**

**SMALL CLAIMS ACTION IN MONGOLIAN CIVIL PROCEDURE LAW: A
COMPARISON WITH JAPANESE LAW**

Э.Эрхбилгүүн¹

- I. Оршил
- II. Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт
- III. Япон Улс дахь эрх зүйн зохицуулалт
- IV. Харьцуулалт
- V. Дүгнэлт, санал
- VI. Ном зүй

¹ Нагояа Их Сургуулийн Хууль зүйн их сургуулийн магистрант



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙ ДЭХ БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: ЯПОН УЛСТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

Э.ЭРХБИЛГҮҮН, Нагояа Их Сургуулийн Хууль зүйн их сургуулийн магистрант

Хураангуй

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл 2024 оны 10 сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэхээр байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралыг багасгах иргэдэд хурдан шуурхай, хялбар байдлаар, үр дүнтэй үйлчлэх шүүхийн хүртээмжийг дээшлүүлэхийн тулд тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульчлахаар болсон. Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү судалгаанд хуульд оруулсан нэмэлт дахь зарим зохицуулалтыг боловсронгуй болгох талаар харьцуулсан судалгааны хүрээнд судалсан болно.

Түлхүүр үг

Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хэргийг нэг шүүх хурлаар хянан шийдвэрлэх, сөрөг нэхэмжлэл, ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

I. ОРШИЛ

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 91-д “бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх” зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдөр Улсын Их Хуралд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (цаашид “ИХШХШТХ” гэж товчлов.) нэмэлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн үзэл баримтлал хэсгээс үзэхэд “...Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралтай байдалд хэргийн оролцогчийн хаяг тодорхой бус, шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг буюу нэг шүүгч, туслахад ногдож буй хэргийн тоо хэт их, үүнээс шалтгаалан нэг хэргийн шийдвэрлэх зардлаар 3 хэргийг шийдвэрлэдэг, шүүх хуралдааны танхим, иргэдэд үйлчлэх нөхцөл бололцоо, орчин шаардлага хангахгүй зэрэг төрөөс шалтгаалах хүчин зүйлс нөлөөлж байгаа ч **нөгөө талаас бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд тохирсон хянан шийдвэрлэх ажиллагаа, хэргийн удирдлагын эрх зүйн орчин бий болоогүйгээс үүдэлтэй байна...**” Өөрөөр хэлбэл бага үнийн дүнтэй



хэргийг хянан шийдвэрлэхэд тохирсон хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан тохиолдолд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал тодорхой хэмжээнд багасаж, иргэдэд хурдан шуурхай, хялбар байдлаар, үр дүнтэй үйлчлэх шүүхийн хүртээмж дээшилнэ гэж хуулийн төсөл боловсруулагч нар үзсэн байна.

2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Хууль зүйн байнгын хорооны (цаашид “Байнгын хороо” гэж товчлов.) хуралдаанаар тус хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явагдаж, шүүх хугацаагүйгээр удааширдаг, хойшилдог асуудлуудыг аль болох хязгаарлаж, шүүхийн үйл явцыг хялбаршуулан, шийдвэрийг хурдан гаргадаг байх тал дээр илүү анхаарсан бөгөөд хэд хэдэн өөрчлөлт оруулахаар нэмж тусгасан байна¹. Эдгээрт, тусгайлсан журмаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах нэхэмжлэлийн төрөл, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах, тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд хүсэлт гарган ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих нөхцөлийг тодорхой болгох зэрэг асуудлуудыг боловсронгуй болгохоор нэмж тусгасан байна². 2024 оны 01 дүгээр

сарын 16-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх эцсийн хэлэлцүүлгийн төслийг бэлтгэсэн байна³. Анхны төслөөс өөрчлөлт орсон хуулийн зохицуулалт 2024 оны 10 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон байна⁴. Иймд дээрх өөрчлөлт нь хуулийн төслийн үзэл баримтлал хэсэгтэй нийцэж байгаа эсэх, хангаж чадахуйц эсэх талаар өгүүлэл бичихээр зорилоо.

Энэхүү сэдвийн монгол хэл дээр судлагдсан судалгааны эх сурвалж гэвэл нээлттэй нийгэм форумаас хийгдсэн “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практик” болон Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор Н.Баярмаа “Иргэний хэргийн онцлогт тулгуурлан хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлэх шаардлага” гэх судалгаанууд хийгдсэн байна. Үүнээс гадна хуулийн төслийн үр нөлөөний судалгаа, шүүхийн статистик мэдээлэл зэрэг багтана. Эдгээр судалгааны эх сурвалжуудад үндэслэн өгүүллэгийн хоёрдугаар хэсгийг авч үзэх болно.

Үүний дараагаар Япон Улс дахь бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судлах болно. Япон Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний

¹ Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгээс үзнэ үү.

“ХЗБХ: Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, Байнгын хорооны тогтоолын төслүүдийг баталлаа,” 2024, <https://www.parliament.mn/nn/51713/>, (Сүүлд үзсэн: 2024.01.23).

“Хууль зүйн байнгын хороо 9 хууль, Улсын Их Хурлын 11 тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулжээ,” 2024, <https://www.parliament.mn/nn/51794/>, (Сүүлд үзсэн: 2024.01.23).

² Хууль зүйн байнгын хороо, “Иргэний хэрэг

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт,” 2024, (Сүүлд үзсэн: 2024.01.23)

³ Хууль зүйн байнгын хороо, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх хууль зүйн байнгын хорооны танилцуулга,” 2024, (Сүүлд үзсэн: 2024.01.23)

⁴ Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)



хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь 1996 онд батлагдсан бөгөөд тус хууль шинэчлэгдэн батлагдах болсон шалтгаан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал байсан. Үүнээс болж иргэдийн шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээс зайлсхийх үр дагавар бий болсон. Энэ асуудлыг шийдэхийн тулд хэд хэдэн чухал шинэчлэл хийсэн бөгөөд эдгээрийн дотор хялбаршуулсан шүүхэд (Summary Court, 簡易裁判所)⁵ тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар хуульчилсан түүхтэй.

Манай улс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралаас шалтгаалж тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульчлахаар болж байгаа тул Япон Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах нь ач холбогдолтой гэж бодож байна. Энэхүү өгүүлэгээр тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотойгоор хувь судлаачийн саналаа дэвшүүлж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хөгжилд бага ч гэсэн хувь нэмэр оруулах зорилготой болно.

II. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэ хэсэгт бага үнийн дүнтэй хэрэг

⁵ Энэ шүүх нь нэхэмжлэлийн үнийн дүн 1400000 иен доторх иргэний хэрэг болон хөнгөн гэмт хэрэгт холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Мөн шүүгч дангаар хэргийг хянан шийдвэрлэдэг онцлогтой. Хялбаршуулсан шүүхийн тухай монгол хэл дээрх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгээс үзнэ үү.

Б.Хонгорзул, Б.Доржпагам “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практик,” Шүүхийн шийдвэрийн судалгаа 7, Нээлттэй нийгэм форум, 2022, 42-53 дахь тал.

хянан шийдвэрлэх ажиллагааны ойлголт болон хуулийн анхны төсөл болон хуульд орсон нэмэлт дахь бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх урьдчилсан нөхцөл, бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хэргийг нэг шүүх хуралдаанаар хянах зарчим болон үүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн зохицуулалт, ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих зохицуулалтуудыг авч үзэх болно.

1. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ойлголт

Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь бага дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах тухай эрх зүйн маргааныг зардал багатай, шуурхай хянан шийдвэрлэх механизм буюу шүүхийн процесс ажиллагааны албархаг хэв шинжийг багасгасан, нотлох баримтын энгийн дүрэм үйлчлэх, хэргийн оролцогчид өөрийгөө төлөөлөх өргөн боломж олгосон энгийн, боловсронгуй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа юм⁶. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдлэг, туршлага хомс иргэд өөрт учирсан бага үнийн дүнтэй маргаанаа шийдвэрлүүлэхээр шүүхэд хандаж, нэхэмжлэлийн үнийн дүнд тохирсон зардал болон хугацаанд хялбаршуулсан журмаар шүүхээр шуурхай шийдвэрлүүлэх эсхүл талууд хоорондоо эвлэрэх нөхцөлийг хангахад оршино гэж тодорхойлжээ.⁷ Түүнчлэн иргэд өмгөөлөгчгүйгээр өөрөө бага үнийн

⁶ Н.Баярмаа, “Иргэний хэргийн онцлогт тулгуурлан хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлэх шаардлага,” Монголын төр, эрх зүйн сэтгүүл 105(3), 2023, 24 дахь тал.

⁷ 最高裁判所事務総局民事局監修『解釈民事訴訟規則』459頁(司法協会、1997)。



дүнтэй нэхэмжлэлийн шаардлагаа гаргаж тус ажиллагаагаар хэрэг маргаанаа хянан шийдвэрлүүлэх нь үндсэн хуульд заасан шударгаар шүүлгэх эрхийг бодитоор хангах баталгаа болдог⁸. Нөгөө талаас ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хянан шийдвэрлэх боломжгүй болох нь хариуцагч талын шударгаар шүүлгэх эрхийг зөрчих эрсдэлтэй гэж үзэх шүүмжлэл байдаг⁹.

2. Хуулийн анхны төсөл болон хуульд орсон нэмэлт дахь зарим эрх зүйн зохицуулалт

а) Тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл

Хуулийн анхны төсөлд дараах байдлаар тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх урьдчилсан нөхцөлийг зохицуулсан байна. Нэгдүгээрт, бага үнийн дүнтэй гэдэг нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс доошгүй үнийн дүнтэй маргааныг ойлгоно. Хоёрдугаарт, хуулийн төслийн 75¹.1.1-с 75¹.1.6-т заасан нэхэмжлэлийн шаардлага хамаарна гэж тусгажээ¹⁰. Харин хуульд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй гэж өөрчилж мөн нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн. Үүнд, хүний эрүүл мэндэд учруулсан гэм хорын мөнгөн хөрөнгө гаргуулах, мөн шүүх тусгайлсан журмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор

эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаа явуулахтай холбоотой зохицуулалт, гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухай нэмж тусгажээ¹¹. Эндээс үзэхэд нэхэмжлэгчийн шаардлагын агуулга дээрх хоёр урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд тухайн хэргийг шүүх тусгайлсан журмаар шийдвэрлүүлэхээр захирамж гаргах эрх зүйн үр дагавар үүсэхээр байна.

б) Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

Хуулийн анхны төсөлд тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хугацааны талаар зохицуулалт оруулаагүй боловч нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлд *"...тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, энэ хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хоногоор сунгах, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэх..."*¹² гэж нэмж тусгасан бөгөөд энэ нь хуульд нэмэлтээр орсон.

ИХШХШТХ-д зааснаар ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг 60 хоногийн дотор, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бөгөөд шүүхийн шүүгчдийн зөвлөлөөс нэг удаа 30 хонгоор хойшлуулах боломжтой талаар зохицуулсан байдаг. Гэхдээ шүүгч

⁸ 竹下守夫ほか『新民事訴訟法』11頁（弘文堂、1998）。

⁹ 加藤新太郎「簡易裁判所の少額訴訟手続（上）」月報司法書士第542号、57頁（2017）。

¹⁰ Эдгээр зохицуулалтуудыг хуулийн анхны төслөөс дэлгэрэнгүй үзэх боломжтой. <https://lawforum.parliament.mn/project/486/>

¹¹ ИХШХШТХ-ийн 751.1.1-751.2.3.

¹² Мөн тэнд.



нарын зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуулиар зохицуулах нь зохимжгүй бөгөөд хэргийн онцлогт тохируулан хугацааг тогтоох, сунгах нь зүйтэй гэжээ¹³. Иргэний хэргийг шийдвэрлэж байгаа дундаж хугацааг “...хүний нөөц болон техникийн нөхцөл байдлаас хамаарч нарийвчилсан судалгаа гаргахад хүндрэлтэй боловч анхан шатны шүүх дунджаар нэг хэргийг 30-120 хоног, зарим төрлийн хэргүүд түүнээс дээш 1-3 жилийн хугацаанд тус тус хянан шийдвэрлэгдэж байгаа...” гэж онцолсон¹⁴ бол нээлттэй нийгэм форумаас хийсэн судалгаанд мөн адил бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг баримжаалж судалгаанд объектоор сонгосон бага үнийн дүнтэй гурван төрлийн хэргийн 27 хувь нь 30 хүртэлх хоног, 48 хувь нь 31-60 хүртэлх хоног, 27 хувь нь 61 ба түүнээс хугацаа гэж үзсэн байна¹⁵. Эндээс үзэхэд тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног тохиромжтой хугацаа мөн гэж дүгнэх нь учир дутагдалтай юм.

с) Хэргийг нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчим болон түүний хэрэгжилтийг хангах

Хуулийн төсөлд бага үнийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ гэж

¹³ Судалгаа мэдээ, сургалтын төв “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгохтой холбоотой анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн санал” Шүүх эрх мэдэл сэтгүүл (4), 2021, 107 дахь тал.

¹⁴ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга,” 2023, <https://lawforum.parliament.mn/project/486/> (Сүүлд үзсэн: 2024.1.23).

¹⁵ Б.Хонгорзул, Б.Доржпагам “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практик,” Нээлттэй нийгэм форум, 2022, 26-27 дахь тал.

заасан байна (75^{2.1}-р зүйл). Мөн зохигч хэргийг шийдвэрлэх шүүх хуралдаанаас өмнө шаардлага, хариу тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримтыг шүүхэд ирүүлэх үүрэгтэй гэжээ(75^{2.2}-р зүйл).

Хуулийн анхны төсөлд сөрөг нэхэмжлэл гаргахгүй байхаар зохицуулсан (75^{1.3}-р зүйл). Тус төсөлд хийсэн үнэлгээний тайланд бага үнийн дүнтэй хэрэг маргааныг түргэн шуурхай зардал багатай шийдвэрлэхийн тулд сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглох нь нийцэж байна гэжээ¹⁶. Харин эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийн үр дүнд хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш зарчмыг баримтлах зорилгоор хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах боломжтой байхаар хуульд нэмэлт оруулсан байна. Түүнчлэн зохигч үндсэн болон сөрөг нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй гэж зохицуулжээ (ИХШХШТХ-ийн 75^{5.4}).

д) Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих

Хуулийн анхны төсөлд зохигч шүүх хуралдаан эхлэхээс өмнө хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлнэ (75^{6.1}-р зүйл). Түүнчлэн дараах нөхцөлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд шүүх хэргийг ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлнэ (75^{6.2}-р зүйл).

¹⁶ Хууль зүйн дотоод хэргийн яам, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлан, 2023, 13 дахь тал.



- Нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үнийн дүн хуульд заасан шаардлагыг зөрчсөн;
- Хариуцагч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирээгүй бөгөөд цаасан болон цахим нотлох баримтад тулгуурлан хэргийг шийдвэрлэх боломжгүй гэж шүүх үзсэн;
- Шүүх тухайн хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөлд 75⁶.1-р зүйлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах хийдэл үүсгэх магадлалтай, тусгайлсан журмаар хянан шийдвэрлэгдэх ач холбогдлыг бууруулах, хэргийг хурдан шуурхай, хялбар шийдвэрлэх үндсэн зорилгод нийцэхгүй байх тул хассан байна.¹⁷ Мөн шүүхийн эрх хэмжээг хумьж дараах байдлаар өөрчилжээ(ИХШХШТХ-ийн 75⁷.1.1-75⁷.1.2).

- Нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн
- Тухайн хэрэг нь эрх зүйн, шинэ ойлголт, хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй.

III. ЯПОН УЛС ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэ хэсэгт өгүүллэгийн хоёрдугаар хэсэгт авч үзсэн зохицуулалтуудыг Япон Улсад хэрхэн зохицуулсан талаар авч үзэх болно.

¹⁷ “ХЗБХ: Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, Байнгын хорооны тогтоолын төслүүдийг баталлаа,” 2024, <https://www.parliament.mn/nn/51713/> (Сүүлд үзсэн: 2024.01.23).

а) Тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл

Япон Улсын хувьд оршил хэсэгт дурдсанчлан хялбаршуулсан шүүх хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэдэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дараах урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд эхэлдэг. Нэгдүгээрт, нэхэмжлэлийн үнийн дүн 60,000 иен хүртэлх байх. Анх нэхэмжлэлийн үнийн дүн 300000 иен хүртэлх нэхэмжлэлийн шаардлагад хамаарч байгаад тус тогтолцооны хэрэгжилтийг өндрөөр үнэлж 2004 оны нэмэлт өөрчлөлтөөр нэхэмжлэлийн үнийн дүнг 600000 иен хүртэлх болгож нэмэгдүүлсэн¹⁸. Хоёрдугаарт нэхэмжлэлийн шаардлага нь зөвхөн мөнгөн хөрөнгө гаргуулахад хамаарна¹⁹. Гуравдугаарт, нэхэмжлэгч тал нэхэмжлэл гаргах үедээ хялбаршуулсан шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлүүлэх үү, эсхүл бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэх эсэхээ шийдэх эрхтэй байдаг (Япон Улсын ИХШХШТХ-н 368.1, 2). Хэрвээ бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгох тухай нэхэмжлэлд дурдаагүй бол ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ.²⁰ Нэхэмжлэгч тал нэхэмжлэлд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэх тухай дурдсан тохиолдолд хариуцагч тал бага үнийн дүнтэй хэрэг хянан

¹⁸ 三木浩一ほか『民事訴訟法（第4版）』665頁（有斐閣、2023）。

¹⁹ 斎藤秀夫『新民事訴訟法解説』421頁（第一法規出版、1997）。

²⁰ 法務省民事局参事官室『一問一答え新民事訴訟法』396頁（商事法務研究会、1996）。



шийдвэрлэх ажиллагаа руу шилжих тухай хүсэлт гаргах боломжгүй²¹. Ийнхүү нэхэмжлэгч талд хэрэг хянан шийдвэрлэх журмыг сонгох эрх олгосон нь дараах шалтгаантай²².

- Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг хязгаартай шинжлэн судлах;
- Шүүхийн шийдвэрийн биелэлтийг хуваарь гарган хойшлуулах боломжтой;
- Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхгүй байхаар хязгаарласан зэргээс нэхэмжлэгч талыг маргаанаа бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгохыг албадах учиргүй гэжээ.

Дөрөвдүгээрт, нэхэмжлэгч тухайн жилд тухайн бүс нутагт харьяалагдах хялбаршуулсан шүүхэд дээд талдаа 10 удаа бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгох эрхтэй (Япон Улсын ИХШХШТХ-н 368.3, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 223). Ийнхүү жилд дээд талдаа 10 удаа гэж хязгаарласан нь бизнесийн байгууллага өр зээлээ барагдуулах хэрэгсэл болгон хэт ихээр ашиглахаас урьдчилан сэргийлж, ердийн иргэд ч адил тэнцүү үйлчлүүлэх боломж бий болгох үүднээс нэхэмжлэл гаргах тоонд хязгаар тогтоосон байдаг²³. Түүнчлэн хуулийн хэлэлцүүлгийн явцад жилд дээд талдаа 10 удаа байхаар тогтож, хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш муж болгон дахь хялбаршуулсан

шүүхийн нөхцөл байдал, практик дахь хэрэгжилт зэргийг харгалзан үзэж Дээд шүүх дээрх хязгаарыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар өөрчлөх боломжтой байдлаар уян хатан зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзжээ²⁴.

b) Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

Япон Улсын хувьд хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацааг хуулиар тогтоож өгөөгүй байдаг²⁵. Хуульд хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацааг тогтоох нь зохимжгүй тул хэрэг хянан шийдвэрлэх тохиромжтой хугацаа нь тухайн хэргийн маргааны шинж чанараас хамаарна²⁶. Зохигч нарт тайлбар гаргах, шүүхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах хугацааг хангалттай олгох ёстой бөгөөд эдгээр хугацааг хангалттай олгоогүйгээс шалтгаалж иргэдийн шүүхэд итгэх итгэл алдагддаг²⁷.

Хялбаршуулсан шүүх дэх иргэний хэргийг хянан шийдвэрлэж буй дундаж хугацаа нь доорх хүснэгтээс үзэх боломжтой.

²⁴ 最高裁判所事務総局民事局監修, supra note 7. 459.

²⁵ 2022 оны нэмэлт өөрчлөлт оруулах хуулиар нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш шүүхээс хэргийг 6 сарын хугацаанд хянан шийдвэрлэх (法定審理期間訴訟手続, Requirements of Statutory Trial Period Litigation Proceedings) тогтолцоог шинээр нэвтрүүлэхээр болсон. Талууд санал нэгдэж шүүхэд хүсэлт гаргасан, эсхүл хэргийн аль нэг тал шүүхэд энэ тухай хүсэлт гаргахад хэргийн нөгөө тал хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэ ажиллагаанд шилжих боломжтой. Энэ зохицуулалт нь 2026 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

²⁶ Ibid.

²⁷ Такэүчи Юкиноби (Нагояа их сургуулийн хууль зүйн сургуулийн багш, Нагояа хотод байрлах мужийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн шүүгч), "Япон Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн практик," 2023, ярилцлагын хэсгээс.

²¹ Ibid.

²² Ibid 398.

²³ Б.Хонгорзул, Б.Доржпагам, supra note 15. 51.



Хүснэгт 1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа²⁸

	Анхан шатны орон нутгийн шүүх	Анхан шатны хялбаршуулсан шүүх	
	Ердийн журмаар	Ердийн журмаар	Бага үнийн журмаар
2019	9.5 сар	2.8 сар	2.1 сар
2020	9.9 сар	3.7 сар	2.8 сар
2021	10.5 сар	3.7 сар	2.5 сар
2022	10.5 сар	3.4 сар	2.5 сар

Дээрхээс үзэхэд хялбаршуулсан шүүх дахь хэргийн онцлогоос шалтгаалан ялгаатай шийдвэрлэх хоёр ажиллагааны шүүн таслах дундаж хугацаа сүүлийн үед ихэссэн байна. Ойролцоогоор бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа 64-85 хоног хүртэл, ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа 85-112 хоног хүртэл гэж дүгнэж болох юм.

с) Хэргийг нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчим болон түүний хэрэгжилтийг хангах

Хүндэтгэн үзэх нөхцөл байдал байхаас бусад тохиолдолд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэг удаагийн шүүх хурлаар явагдаж дуусна (Япон Улсын ИХШХШТХ-н 370-р зүйл). Нэг удаа шүүх хуралдаан явуулах зарчмыг америкийн эрх зүйн тогтолцооноос

²⁸ 最高裁判所「裁判の迅速化に係る検証に関する報告書(第9回)(令和3年7月30日公表)」

[https://www.courts.go.jp/toukei_siryou/siryou/hokoku_09/index.html] [https://www.courts.go.jp/vc-files/courts/2023/databook2023/db2023_221.pdf] も参照。(Сүүлд үзсэн: 2024.01.24).

нутагшуулсан онцлогтой²⁹. Энэ зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд сөрөг нэхэмжлэлийг хориглох, шүүх хуралдааны өмнө холбогдох тайлбар болон нотлох баримтаа гаргасан байх шаардлагуудыг тусгасан байдаг. Япон Улсад сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглодог (Япон Улсын ИХШХШТХ-н 369-р зүйл). Учир нь тус хэрэг хянан ажиллагаанд хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд нэхэмжлэгч үүнд хариу тайлбар бэлдэх шаардлагатай болох бөгөөд шүүх нэхэмжлэгчийн хариу тайлбарыг хүлээн авсны үндсэн дээр шүүн таслах ажиллагааг явуулах болсноор хэргийг нэг удаагийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчимтай зөрчилдөх болно³⁰.

д) Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих

Хуульд заасны дагуу дараах хоёр тохиолдолд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилждэг. Нэгдүгээрт, хариуцагч хүсэлт гаргасан тохиолдолд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилждэг. Нэхэмжлэгч талд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сонгох эрхийг олгосон учраас хэргийн оролцогч нарын тэгш байдлыг хангахын тулд хариуцагч талд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжих хүсэлт гаргах боломжийг олгох нь зүйтэй гэж үзжээ³¹. Гэхдээ хуулиар шүүх хуралдаан эхлэхээс өмнө бичгээр хүсэлт гаргах эсхүл шүүх хуралдааны өдөр амаар хүсэлт гаргах боломжтой. (Япон Улсын ИХШХШТХ-н 373.1-р

²⁹ 斎藤秀夫, supra note 19. 422.

³⁰ 法務省民事局参事官室, supra note 20. 405.

³¹ Ibid 399.



зүйл, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 228.1).

Хоёрдугаарт, шүүх хуульд заасны дагуу эрх хэмжээний хүрээнд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх боломжтой. Үүнд:

- Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл хангагдаагүй байх (Япон Улсын ИХШХШТХ-н 373.3.1, 3.2-р зүйл);
- Шүүхийн олон нийттэй харилцах самбарт шүүхийн мэдэгдэх хуудсыг тавихгүйгээр хариуцагчийг дуудах боломжгүй тохиолдолд (Япон Улсын ИХШХШТХ-н 373.3.3-р зүйл);
- Тухайн төрлийн иргэний хэргийг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзвэл (Япон Улсын ИХШХШТХ-н 373.3.4 -р зүйл). Жишээ нь гэрчийг шүүх хуралдааны танхимд заавал дуудаж мэдүүлэг авах шаардлагатай, эсхүл олон тооны гэрчээс мэдүүлэг авах шаардлагатай, эд мөрийн баримтад үзлэг хийх шаардлагатай, тухайн хэргийг нэг удаа эсхүл хоёр удаагийн шүүх хурлаар хянан шийдвэрлэх боломжгүй зэрэг тохиолдол хамаарна³². Өөрөөр хэлбэл маргааны зүйлийг тогтооход ээдрээ төвөгтэй байх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар

хэргийг ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх боломжтой.

Шүүгч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэх тухай захирамж гаргах бөгөөд захирамжийн эсрэг гомдол гаргах эрхгүй (Япон Улсын ИХШХШТХ-н 373.4-р зүйл). Хэрвээ гомдол гаргах тохиолдолд цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардагдах бөгөөд маргааныг хурдан шуурхай шийдэх зорилттой бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцэхгүй тул гомдол гаргах эрхгүй байхаар зохицуулсан³³.

IV. ХАРЬЦУУЛАЛ

Энэ хэсэгт хоёрдугаар болон гуравдугаар хэсэгт авч үзсэн хоёр улсын эрх зүйн зохицуулалтуудыг харьцуулан авч үзэх болно.

а) Тусгайлсан журмаар бага үнийн дүнтэй хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл

Хоёр улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулж үзэхэд Монгол Улсын хувьд нэхэмжлэлийн шаардлагын хувьд мөнгөн хөрөнгө гаргуулах болон хуульд заасан барьцааны шаардлага, шийдвэр гүйцэтгэлийн шаардлага гаргуулах хүрээнд зохицуулсан. Энэхүү зохицуулсан нь манай улсын онцлог гэж дүгнэж болох юм. Харин Япон Улсын хувьд зөвхөн мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарласан байна. Нэхэмжлэгч тал нэхэмжлэл гаргах үедээ ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эсхүл бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

³² Ibid.

³³ Ibid.



аль нэгийг сонгох эрхтэй. Түүнчлэн жилд дээд талдаа 10 удаа бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгох боломжтой. Монгол Улсын хувьд эдгээр хоёр нөхцөлийг хуулийн төсөлд тусгаагүй байна.

б) Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

Хоёр улсын зохицуулалтыг харьцуулж үзэхэд хэргийн хөдөлгөөний арга барилын ялгаатай байдал харагдаж байна. Монгол Улсын хувьд хуулиар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа тогтоож үүнд амжиж хэргийг хянан шийдвэрлэж чадвал хурдан шуурхай гэж үздэг эрх зүйн тогтолцооны онцлогтой гэж үзэж болохоор байна. Харин Япон Улсын хувьд хэргийн оролцогч талуудад хэргийн онцлогоос шалтгаалж тайлбар болон нотлох баримт гаргах хангалттай хугацааг олгох буюу мэтгэлцэх зарчмын баталгааг хангахыг чухалчилдаг онцлогтой гэж үзэж болохоор байна. Хүснэгт 1-с үзэхэд хэргийг хурдан шуурхай шийдэхийн тулд заавал хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацааг тогтоох шаардлагатай гэж үзэх нь учир дутагдалтай гэж бодож байна.

с) Хэргийг нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчим болон түүний хэрэгжилтийг хангах

Хоёр улсын зохицуулалтыг харьцуулж үзэхэд ижил зохицуулалтуудыг тусгасан байна. Гэхдээ Байнгын хорооноос бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш зарчмыг хангахын тулд хариуцагчид сөрөг нэхэмжлэл олгох нь шаардлагатай гэж үзсэн. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд

сөрөг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх болсон үндэслэлийг дараах байдлаар тайлбарладаг. Нэгдүгээрт, иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, өөрчлөхийг зөвшөөрсөн байдаг учраас тэгш байдлыг хангахын тулд хариуцагчид ч мөн адил маргааны зүйлийг өргөжүүлэх эрхийг зөвшөөрөх нь зүйтэй гэж үздэг. Хоёрдугаарт, сөрөг нэхэмжлэлийг зөвшөөрсөн тохиолдолд хариуцагч дахин шүүхэд хандаж хэрэг үүсгэхгүй учраас эдийн засагт ач холбогдолтой гэж үздэг³⁴.

Хэргийн оролцогч буюу зохигч нарын тэгш байдлыг хангах зарчмын талаас үзэхэд, нэхэмжлэлийн шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргах (75¹.3) зэргийг хориглосон мөртлөө хариуцагчид сөрөг нэхэмжлэл гаргах эрх хуулиар олгох нь эсрэгээрээ тэгш байдлын зарчимтай нийцэхгүй юм. Түүнчлэн, сөрөг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд нэхэмжлэгч хариу тайлбар болон нотлох баримт гаргах шаардлагатай болно. Хуульд энэ талаар 5 хоногийн дотор гэж заасан боловч мэтгэлцэх зарчмын баталгааг хангах үүднээс хэтэрхий богино хугацаа тогтоосон гэж дүгнэхээр байна. Нэг шүүх хурлаар хэргийг хянан шийдвэрлэх зарчмын үүднээс үзэхэд сөрөг нэхэмжлэлийг зөвшөөрөх нь энэ зарчмыг хэлбэрийн төдий болгох эрсдэлтэй байна

д) Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих

Хоёр улсын зохицуулалтыг харьцуулж үзэхэд Япон Улсын хувьд хариуцагчийн хүсэлтээр ердийн журмаар хэрэг хянан

³⁴ 安西 明子ほか『民事訴訟法（第3版）』214頁（有斐閣、2023）。

шийдвэрлэх ажиллагаа руу шилжих боломжтой. Шүүх хуульд заасны дагуу ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх боломжтой байдлаар зохицуулсан байна.

Монгол Улсын хувьд, Байнгын хорооноос бэлтгэсэн эцсийн төсөлд зохигч нар ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжих тухай хүсэлт гаргах боломжгүй байхаар зохицуулсан нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй дахь талуудын зүгээс процессыг чиглүүлэх зарчмыг зөрчсөн байна³⁵. Энэ зарчмын үүднээс үзвэл зохигч нар бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжих боломжийг олгох зүйтэй юм. Түүнчлэн зохигч нар энэ эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн баталгааг төр бүрдүүлэх үүрэгтэй (Монгол Улсын Үндсэн хууль 18.1).

Үүнээс гадна шүүхийн эрх хэмжээг хумьж зохицуулсан нь тус ажиллагааны мөн чанартай нийцэхгүй байна. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нь хууль зүйн мэдлэг, туршлага хомс иргэдийн бага үнийн

дүнтэй маргаан буюу маргааны зүйлийг тогтооход хялбар хэргийг хянан шийдвэрлэхэд оршдог. Ийм ч учраас маргааныг зүйлийг тогтооход ээдрээ төвөгтэй, цаг хугацаа шаардагдах хэргийг шүүх хуульд заасны дагуу ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх хэрэгтэй. Хуульд оруулсан тус нэмэлт хэргийг хууль ёсны, үндэслэл бүхий шийдэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэ хүрээнд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ойлголт болон хуулийн анхны төсөл дахь зохицуулалт болон анхны төсөлд оруулсан нэмэлт өөрчлөлтийг авч үзлээ. Тухайлбал ажиллагааны урьдчилсан нөхцөл, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэх, хэргийг нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчим. Гуравдугаар бүлэгт өмнөх бүлэгт авч үзсэн зохицуулалтыг Япон Улсад хэрхэн зохицуулдаг талаар авч үзсэн. Өгүүллэгийн дөрөвдүгээр хэсгийн харьцуулалтад үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

- Хуульд нэмэлт оруулсан бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах нэхэмжлэлийн шаардлага нь манай улсын эрх зүйн зохицуулалтын онцлогоос хамаарч зохицуулсан гэж үзэж байна.
- Хуульд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа 45 хоног гэж тогтоосон нь тохиромжтой хугацаа гэж

³⁵ Монгол Улсад талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг шийдэх нь диспозитив зарчимд хамаарна гэж тайлбарладаг. Гэхдээ Герман болон Япон Улсад диспозитив зарчмын агуулгыг 1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх бөгөөд нэхэмжлэл гаргах, 2) Нэхэмжлэлийн зүйлийг тодорхойлох, 3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн шийдвэргүйгээр дуусгавар болгох буюу талууд эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх гэх мэт хамаарна. Харин процессыг чиглүүлэх буюу удирдах (ProzeYrecht、訴訟進行主義) гэх ойлголт нь шүүхийн зүгээс процессыг чиглүүлэх (Amtsbetrieb、職權進行主義) болон талуудын зүгээс процессыг чиглүүлэх (Partiebetrieb、當事者進行主義) гэсэн агуулгаас бүрддэг. Судлаач нь диспозитив зарчим болон процессыг чиглүүлэх зарчмыг тусад нь авч үзсэн болно.



үзэх нь учир дутагдалтай. Түүнчлэн хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацааг тогтоосноор хурдан шуурхай шийдвэрлэнэ гэж үзэх нь өрөөсгөл. Иймд зөвхөн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж хязгаарлахгүй хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацаа тогтоох шаардлагатай эсэх талаар тусдаа судалгаа хийх нь шаардлагатай юм.

- Хуульд хэргийг нэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх зарчмыг тусгаж өгсөн боловч хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн явдал нь энэ зарчмыг хэрэгжүүлэх нөхцөлийг алдагдуулж байна. Түүнчлэн хуульд нэхэмжлэгч талын эрхийг хязгаарласан зохицуулалтууд агуулсан байгаа тул талуудын тэгш байдлын үүнээс хариуцагчид сөрөг нэхэмжлэл гаргахыг зөвшөөрөх нь учир дутагдалтай. Иймд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглох шаардлагатай.
- Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам руу шилжүүлэх зохицуулалтыг хумьсан нь талуудын зүгээс процессыг чиглүүлэх зарчим болон бага үнийн дүнтэй боловч маргааны зүйлийг тогтооход ээдрээ төвөгтэй хэргийг хууль

ёсны болон үндэслэл бүхий шийдвэрлэхэд хүндрэлтэй болгож байна. Иймд хуулийн анхны төсөлд заасны дагуу зохигч нар ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам руу шилжүүлэх хүсэлт гаргах, мөн шүүх тухайн хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн тохиолдолд шилжүүлэх гэж өөрчлөх шаардлагатай.

VI. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. Судалгаа мэдээ, сургалтын төв, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгохтой холбоотой анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн санал,” *Шүүх эрх мэдэл сэтгүүл (4)*, 2021.
2. Б.Хонгорзул, Б.Доржпагам, “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практик,” *Шүүхийн шийдвэрийн судалгаа 7*, Нээлттэй нийгэм форум, 2022.
3. Н.Баярмаа, “Иргэний хэргийн онцлогт тулгуурлан хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлэх шаардлага,” *Монголын төр,эрх зүйн сэтгүүл 105(3)*, 2023.
4. Хууль зүйн дотоод хэргийн яам, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлан*, 2023.



5. Хууль зүйн дотоод хэргийн яам, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга”, 2023.

Гадаад эх сурвалж:

1. 法務省民事局参事官室『一問一答え新民事訴訟法』（商事法務研究会、1996）。
2. 斎藤秀夫『新民事訴訟法解説』（第一法規出版、1997）。
3. 最高裁判所事務総局民事局監修『解釈民事訴訟規則』（司法協会、1997）。
4. 竹下守夫ほか『新民事訴訟法』（弘文堂、1998）。
5. 加藤新太郎「簡易裁判所の少額訴訟手続（上）」月報司法書士第542号（2017）。
6. 三木浩一ほか『民事訴訟法（第4版）』（有斐閣、2023）。
7. 安西 明子ほか『民事訴訟法（第3版）』（有斐閣、2023）。

Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992).
2. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002).
3. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл (2023).
4. Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (1996).
5. Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журам (1996).

Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын Их Хурлын цахим хуудас: <https://www.parliament.mn/>
2. Япон Улсын шүүхийн цахим хуудас: <https://www.courts.go.jp/index.html>



Abstract

SMALL CLAIMS ACTION IN MONGOLIAN CIVIL PROCEDURE LAW: A COMPARISON WITH JAPANESE LAW

E.ERKHBILGUUN

*Nagoya University Graduate
School of Law (LL.M Candidate)*

The Act Partially Amending the Civil Procedure Code has been submitted to parliament and will come into force on October 1, 2024. To reduce delays in civil litigation and enhance summary and efficiency of court services, small claims action has been established. Several amendments were made to the civil procedural draft law during the meeting of

the Standing Committee on Legal Affairs. Therefore, this research article examines some of this legal amendment's regulations using a comparative law approach.

Keywords

Small claims action, counterclaim, one-day trial procedure, transfer to ordinary proceedings, proceedings period

**ЗАСАГ ДАРГЫГ ОГЦРУУЛСАНТАЙ ХОЛБОГДОХ МАРГААНЫГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ХҮРЭЭ**

**THE ADMINISTRATIVE COURT'S FRAMEWORK OF CONTROL TO
DISPUTE RESOLUTION RELATED TO DISMISSAL OF THE GOVERNOR**

А.Түвшинтулга¹

Г.Цэрэндэжид²

- I. Удиртгал
- II. Захиргааны ерөнхий хууль ба шийдвэр гаргах ажиллагаа (Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тухайлсан зохицуулалттай хууль болох нь)
- III. Энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ
- IV. Дүгнэлт, санал
- V. Ном зүй

¹ Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч.

² Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах.



ЗАСАГ ДАРГЫГ ОГЦРУУЛСАНТАЙ ХОЛБОГДОХ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ХҮРЭЭ

А. ТҮВШИНТУЛГА, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Г. ЦЭРЭНДЭЖИД, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах

Түлхүүр үгс

Шүүхийн хяналт, Засаг дарга, Засаг даргыг огцруулах санал, Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ, тусгай зохицуулалт, ерөнхий зохицуулалт, хуульд заасан журам, огцруулах үндэслэл, журам, эрх зүйн дүгнэлт

Хураангуй

Энэхүү илтгэлээр Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан зохицуулалтын дагуу бүх шатны Засаг даргыг огцруулах, огцруулах санал уламжлах, шийдвэрлэх процессын хуульд нийцсэн байдал ба үүнтэй холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянах хяналтын цар хүрээ, онцлогтой холбоотойгоор шүүхийн практикт тулгамдаж буй зарим асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зарим санал, дүгнэлт хийхийг зорив.

I. Удиртгал

Захиргааны хэргийн шүүх нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар мөн нийтийн

ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу маргааныг харьяалан хянан шийдвэрлэдэг.

Монгол Улсын шүүхийн хянан шийдвэрлэж буй маргаан, ялангуяа захиргааны хэргийн шүүхүүдийн хянан шийдвэрлэх маргаан, хяналтын цар хүрээ жил ирэх бүр нэмэгдэх хандлагатай байна.¹ Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо нэмэгдэхэд нийгмийн хөгжил, хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн байдлаас гадна улс төрийн шийдвэр, үйл явдал ч шууд бусаар нөлөөлдөг талаар зарим судалгаанд² дурджээ. Үүний нэг жишээ бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг огцруулах талаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан санал буюу тогтоол, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик асуудал байна.

“Засаг дарга” гэсэн нэр томъёог толь бичгүүдэд аймаг, нийслэл, сум дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэрт

¹ Дэлгэрэнгүйг Монгол Улсын Шүүхүүдийн тайлан мэдээнээс үзнэ үү. <https://www.judcouncil.mn/site/news/7>, (Сүүлд үзсэн: 2023.11.24).

² https://www.judcouncil.mn/site/news_full/11535 (Сүүлд үзсэн: 2023.11.24).



төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг албан тушаалтан гэсэн бол хуульч, эрдэмтэн Б.Чимид багш Засаг дарга бол “байгууллага”, “албан тушаалтан” гэсэн хоёр утгатай, хуульч, судлаач Д.Ганзориг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч, засаг төрийн төлөөлөгч, нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэгч гэж тус тус тодорхойлсон байна.³ Үндсэн хуульд заасны дагуу бүх шатны Засаг дарга бол засаг төрийн төлөөлөгч бөгөөд Үндсэн хуульд заасан нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчмын хэрэгжүүлэгч гол субъект болдог⁴ байна.

Захиргааны ерөнхий хуульд зааснаар бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь захиргааны байгууллага, албан тушаалтан болохын хувьд тэдгээрийн гадагш чиглэсэн захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг Захиргааны хэргийн шүүх хэрэгжүүлдэг билээ. Тухайлбал, 2020 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн 5.8 хувь нь буюу 99 хариуцагч нь нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь гомдол гаргахаар хуульд заасан байгууллага байсан бол 2023 оны эхний хагас жилд онд захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн нийт хэргийн 57 хариуцагч буюу 4.4 хувь нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай

³ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2022, 925 дахь тал

⁴ Д.Ганзориг, Н.Лувсанжав, Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, А.Бямбажаргал, С.Сүхбаатар, З.Сүхбаатар, Г.Сувд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022, 182 дахь тал

холбоотой маргааныг шийдвэрлэжээ.⁵

Дээрх хариуцагчид хамаарах маргааны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийн Засаг даргыг огцруулах тухай санал уламжилсан шийдвэр, түүнд холбогдох маргааныг хянан шийдвэрлэсэн тохиолдол мөн хамаарч байна.

Иймд судлаачийн зүгээс энэхүү өгүүлээр “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийн Засаг даргыг огцруулах тухай” санал гаргах буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргах, уг тогтоолыг шүүх хянах хяналтын цар хүрээг шүүхийн практик, хууль хэрэглээнд тулгуурлан тодорхойлохыг зорив.

II. Захиргааны ерөнхий хууль ба шийдвэр гаргах ажиллагаа

(Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тухайлсан зохицуулалттай хууль болох нь)

Онолын хувьд, нийтийн захиргааг формаль болон материаллаг аспектыг хослуулан тодорхойлохдоо төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг дотор нь губернатив болон административ гэж хоёр ангилж, губернатив үйл ажиллагаа гэдэгт төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог, тодорхойлсон чиглэлийнхээ хүрээнд үйл ажиллагааг уялдуулан зохицуулдаг, ингэхдээ төрийн үйл ажиллагааг улс төрийн удирдлагаар хангах замаар улс төрийн хувьд удирддаг Засгийн газрын улс төрийн шинжтэй үйл ажиллагааг ойлгохоор, харин административ буюу захиргааны үйл ажиллагаа гэдэгт хууль

⁵ https://www.judcouncil.mn/site/news_full/13252, (Сүүлд үзсэн: 2023.11.24)



тогтоогчийн баталсан хууль болон Засгийн газраас гаргасан шийдвэрийн хүрээнд тодорхойлогдсон буюу зохицуулагдсан, хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйтэй холбогдсон үйл ажиллагааг ойлгохоор тодорхойлжээ.⁶

Улмаар Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) тэрхүү зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой.⁷

Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны суурь зохицуулалтыг агуулсан Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэг Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно: 5.1.5.-д “нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага.” гэж зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь захиргааны байгууллагад хамаарч байна.

Нэгэнт иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь захиргааны байгууллага болохын хувьд захиргааны шийдвэр гаргах ажиллагааны ерөнхий зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдаж, захиргааны акт, гэрээ, хэм хэмжээний акттай холбоотой маргаан нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарна.

⁶ Т.Мөнх-Эрдэнэ, “Захиргааны байгууллагын губернaтив ба административ үйл ажиллагаа” өгүүлэл. <https://legaldata.mn/index.php/b/378>, 2023, 4 дэх тал.

⁷ Мөн тэнд 14 дэх тал.

Үүнээс үзэхэд нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн харилцааг Захиргааны ерөнхий хуулиар зохицуулжээ.

Захиргааны хэргийн шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан эсэхийг хянахад өөрт нь бас хязгаарлалт байдаг. Хуулиар тухайн захиргааны байгууллага, албан тушаалтнаас бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломж олгосон тохиолдолд захиргааны байгууллага, албан тушаалтнаас уг хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулсан эсэхийг шүүхээс хянахдаа агуулга гэхээсээ илүү журам, зарчмыг зөрчсөн эсэхийг хянадаг байна.⁸

Энэ талаар ч судлаачид захиргааны шийдвэр, үйл ажиллагаа бодлогын хувьд зөв, бурууг (энэ нь улс төрийн хяналтад хамаарах асуудал) хянадаг субъект нь захиргааны хэргийн шүүх биш.⁹ гэж үзсэн нь буй.

Захиргааны хэргийн шүүхийн магадлах ажиллагааны ерөнхий цар хүрээ нь захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны “хууль зүйн хяналтаар” хязгаарлагдана хэмээн дүгнэжээ.¹⁰

⁸ Д.Сүнжид, “Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхийн хяналтын үзэл баримтлал”, Засгийн газар хууль дээдлэх: шүүхэд гомдол гаргах эрхийн баталгаа эмхэтгэл, 2019, 46 дахь тал.

⁹ Ц.Цогт, “Захиргааны шийдвэрийг шүүхээс магадлан шийдвэрлэх ажиллагааны стандарт,” legaldata.mn, 2019. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

¹⁰ Мөн тэнд



Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтын хүрээ хязгаар нь захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь хуульд нийцсэн эсэх болон процедурын хувьд хуульд нийцсэн эсэхэд эрх зүйн дүгнэлт өгөхөөр хязгаарлагдана.¹¹

Энэхүү өгүүлэлд дурдсан асуудлын хүрээнд өөр нэг асуудал тухайлсан зохицуулалттай хуулийг шүүхээс хэрэглэх тухай юм.

Тухайлбал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35, 64 дүгээр зүйлд зааснаар тухайн шатны Засаг даргыг огцруулах хуулийн зохицуулалтыг тусгайлан заасан. Тодруулбал,

Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 1.-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.”, 2.-т “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.” хэмээн заасан.

Улмаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1. дэх хэсэг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.7.-д “хуульд

заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих”, 64 дүгээр зүйлийн 64.2. дахь хэсэг Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд дараах үндэслэлээр доод шатны Засаг даргыг огцруулна: 64.2.3.-т “энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасан үндэслэлээр Хурал түүнийг огцруулах санал гаргасан”, 65 дугаар зүйлийн 65.1.Засаг даргад дараах үндэслэлээр хариуцлага тооцно: 65.1.1.-д “Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн”, 65.1.2.-т “нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн”, 64.4. дэх хэсэгт “Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 64.2.3-т заасныг баримтлан гаргасан тухайн Хурлын саналын дагуу Засаг даргыг огцруулах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана. Хэрэв тухайн саналыг хүлээж аваагүй бол Хурал Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн хугацаанд дахин тавихгүй.” гэж тус тус зохицуулжээ.

Хууль хэрэглэх дарааллын зарчмын үүднээс тухайлсан харилцаанд хамааралтай хэм хэмжээг ерөнхий зохицуулалттай хуулиас түрүүлж хэрэглэнэ, тусгайлан хуульд маргаантай харилцааг зохицуулсан хэм хэмжээ агуулагдаагүй бол ерөнхий зохицуулалттай хуулийн хэм хэмжээг хэрэглэж шүүх хэргийг шийдвэрлэх зарчимтай.

Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн

¹¹ Т.Мөнх-Эрдэнэ, “Захиргааны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ,” legaldata.mn, 2019. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө гэж заасан нь төрийн улс төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, тодруулбал түүнийг томилох, чөлөөлөх асуудлыг тухайлсан хуульд өөрөөр заагаагүй бол уг харилцаанд Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг, харин өөрөөр заасан бол тухайн хуулийг дагаж мөрдөхгүй байхаар хуульчилжээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь аймгийн Засаг даргыг огцруулах асуудлаар санал тавих эрх хэмжээтэй байх бөгөөд Засаг даргыг огцруулах эсэхийг шийдвэрлэх эрх хэмжээ Монгол Улсын Ерөнхий сайдад олгожээ.

Хуулийн эдгээр заалтын дагуу Засаг даргыг огцруулах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг Ерөнхий сайд хүлээн авах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, огцруулах эсэх асуудлыг Ерөнхий сайд шийдвэрлэх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал бус Ерөнхий сайдын шийдвэр нь эрх зүйн шууд үр дагавар үүсгэхээр байна.

Онолын хувьд, нэг нь нөгөөтэйгөө уялдсан байдаг ба эцэстээ асуудлыг цогцолбороор шийдвэрлэхэд чиглэдэг¹² хуулиар тусгайлан зохицуулагдсан шийдвэр гаргах ажиллагааны нэг төрөл Захиргааны цуврал шийдвэр гаргах ажиллагаа юм. Энэ ажиллагааны явцад дараалсан шинжтэй, хэд хэдэн шийдвэр гаргах ажиллагааг зохицуулсан байна.

¹² П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016, 116 дахь тал.

Энэ ажиллагааны онцлог нь эцэстээ нэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэгээрээ нэг нь нөгөөтэйгөө уялдсан, захиргааны дотоод актууд гардаг ч зарим тохиолдолд цуврал шийдвэр нь гадагш чиглэсэн захиргааны акт байж болно. Тодруулбал, эцсийн шийдвэрийн (жишээ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эсэх нь) эрх зүйн үр дагавар нь өмнөх шийдвэрээс шууд хамаарч байвал түүнийг бие даасан эрх зүйн зохицуулалттай захиргааны акт гэж үзнэ. Харин эцсийн шийдвэр нь өмнөх шийдвэрээс шууд хамааралгүй буюу шийдвэр гаргах ажиллагааны явцад гарах бусад захиргааны байгууллагын санал, дүгнэлт зэргийг эцсийн шийдвэр гаргагч нь шийдвэртээ заавал тусгах үүрэг хүлээхгүй (гэхдээ харгалзаж үзэх эрхтэй) бол түүнийг дотоод акт гэнэ¹³ хэмээн тайлбарладаг байна.

Энэхүү өгүүлэлд дурдан буй асуудлын хувьд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2. дахь хэсэг Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд дараах үндэслэлээр доод шатны Засаг даргыг огцруулна: 64.2.3.-т “энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасан үндэслэлээр Хурал түүнийг огцруулах санал гаргасан”, 64.3. дахь хэсэгт “Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 64.2-т заасан тохиолдолд зохих шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачилгаар огцруулах шийдвэр гаргана. Энэ шийдвэрээ тухайн

¹³ УДШ-ийн Шүүхийн практик судлалын хэлтэс, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2018 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм, 2019, 25 дахь тал.



Хуралд нэн даруй мэдэгдэх бөгөөд Хурал 15 хоногийн дотор Засаг даргад шинээр нэр дэвшүүлнэ.”, 64.4. дэх хэсэгт “Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 64.2.3-т заасныг баримтлан гаргасан тухайн Хурлын саналын дагуу Засаг даргыг огцруулах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана. Хэрэв тухайн саналыг хүлээж аваагүй бол Хурал Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн хугацаанд дахин тавихгүй.” гэж тус тус зохицуулсан.

Хуулийн дээрх зохицуулалтын агуулгаас үзэхэд энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасан үндэслэлээр Хурал түүнийг огцруулах санал гаргасан тохиолдолд тухайн Хурлын саналын дагуу Засаг даргыг огцруулах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана. Хэрэв тухайн саналыг хүлээж аваагүй бол Хурал Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн хугацаанд дахин тавихгүй байхаар тухайлан зохицуулжээ.

Үүнээс үзэхэд тухайн шатны Засаг даргыг мөн хуулийн 64.2.3-т заасан үндэслэлээр огцруулах тухай тухайн шатны Хурлын саналыг Дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд хүлээн авах эсэх талаар эрх хэмжээтэй буюу Засаг даргыг огцруулах шийдвэр нь Хурлын санал /тогтоол/-аас шууд хамааралтай гэж үзэх боломжгүй байна.

Засаг даргын албан тушаалын тухайн этгээдийн эрх зүйн байдлын хувьд Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.-т “төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа

этгээдийг, 10 дугаар зүйлийн 10.1. дэх хэсэг Төрийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна: 10.1.1.-д “төрийн улс төрийн албан тушаал”, 11 дүгээр зүйлийн 11.1. дэх хэсэг Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараах албан тушаал хамаарна: 11.1.9.-д “бүх шатны Засаг дарга болон аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын орлогч” гэж зааснаар төрийн улс төрийн албан тушаалд хамаарах боловч албан тушаалын бүрэн эрх, эрх хэмжээ, хэрэгжүүлэх чиг үүрэг, албан тушаалаас чөлөөлөх буюу огцруулахтай холбогдсон харилцаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тусгайлан зохицуулагдаж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр захирамжилсан шинж агуулдаг утгаараа захиргааны хэм хэмжээний акт тогтоосон эсхүл захиргааны акт байна. Иймд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргах процесст Захиргааны ерөнхий хуулийн журамлал давхар үйлчилнэ.¹⁴

Засаг даргыг томилох журам, түүнд оролцогчдын оролцоо нь нэг талаас хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, нөгөө талаас тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Үндсэн хуулиар тогтоосон “хоёрдмол” чиг үүргээс шууд хамааралтай.

¹⁴ Д.Ганзориг бусад, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022, 166 дахь тал.



Шүүх энэ тохиолдолд тухайлсан шийдвэрийг гаргахдаа хуулиар тогтоосон журмыг энэ маргааны хувьд хангасан эсэхийг хянана. Ингээд хуульд заасан процессыг хангаагүй, тэр нь шүүхийн шийдвэрт нөлөөлөхүйц байх тохиолдолд тухайн шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгож болно.¹⁵

Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн шүүхээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ тухайлсан зохицуулалттай хуулийг хэрэглэх, нөгөөтээгүүр захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь процедурын хувьд хуульд нийцсэн эсэхэд эрх зүйн дүгнэлт өгөхөөр хязгаарлагдах учиртайг анхаарах нь зүйтэй болов уу.

III. Энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх Захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ

Энэ хэсэгт 2018 оноос хойших энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн зарим шүүхийн шийдвэрээс дурдвал:

Тохиолдол 1.

Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 120/ШШ2022/0011 дүгээр шийдвэрээр¹⁶ " ... 5. Хурлын хуралдаанаар сумын Засаг дарга Ц-ээг "чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй" гэх үндэслэлээр огцруулсан бөгөөд нэхэмжлэгчийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9-д зааснаар улс төрийн албан тушаалд

¹⁵ Ц.Цогт, "Захиргааны шийдвэрийг шүүхээс магадлан шийдвэрлэх ажиллагааны стандарт," legaldata.mn, 2019. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

¹⁶ Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 0011 шийдвэр https://shuukh.mn/single_case/9318?daterange=2022-04-26%20-%202022-04-26&id=1&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

хамаарч буй учир захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ нь хурлын үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх буюу "огцруулсан" шийдвэрийг хууль бус гэж үзэх үндэслэлийг "хэлбэр"-ийн талаас шалгах учиртай.

Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлснийг хянахдаа гагцхүү шийдвэр гаргах ажиллагаа хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянах бөгөөд төрийн "ардчилсан зарчим"-ийн дагуу олонхоор шийдвэрлэсэн, ялангуяа Засаг даргыг огцруулах асуудлын хүрээнд "чиг үүргээ биелүүлсэн эсэх" зэрэг бодлого (улс төр)-ын шийдвэрт шүүх эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй, энэ нь захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарахгүй ..." гэх үндэслэлээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээрх шүүхийн шийдвэрийг хянасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 464 дүгээр магадлал¹⁷ " ... 2.2. Анхан шатны шүүх маргаан бүхий актын хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгөлгүйгээр "...захиргааны хэргийн шүүх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлснийг хянахдаа гагцхүү шийдвэр гаргах ажиллагаа хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянах бөгөөд төрийн "ардчилсан зарчим"-ийн

¹⁷ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 0464 магадлал, https://shuukh.mn/single_case/5155?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



дагуу олонхоор шийдвэрлэсэн, ялангуяа Засаг даргыг огцруулах асуудлын хүрээнд “чиг үүргээ биелүүлсэн эсэх” зэрэг бодлого (улс төр)-ын шийдвэрт шүүх эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй, энэ нь захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарахгүй” хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь буруу болжээ.

Гэтэл анхан шатны шүүхээс нэхэмжлэгч Ц-ийг ямар чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлээгүй, ямар хуулийг хэрхэн зөрчсөн талаар хариуцагч нараас тодруулаагүй, маргаан бүхий актыг “улс төрийн шийдвэрт шүүх эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй” гэж дүгнэн үйл баримтын талаар бүрэн дүгнэлгүй хэргийг шийдвэрлэсэн нь буруу байх тул маргаан бүхий актын хууль зүйн үндэслэл тус бүрд бүрэн дүгнэлт өгч хэргийг шийдвэрлэх шаардлагатай байна...” гэх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Дээрх тохиолдлыг Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хянаад 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 001/ХТ2022/0073 дугаар тогтоолд¹⁸ “14. Учир нь, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан “Засаг даргыг огцруулах тухай” санал нь Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах улс төрийн шийдвэр, энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх эрхийг дээд шатны Засаг даргад ямар нэгэн шалгуургүйгээр олгосон байх тул шүүх

Засаг даргыг огцруулсан шийдвэрүүдэд эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй, захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ нь Хурлын үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэхээр хязгаарлагдах тул энэ талаар дүгнэн, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байна.

Тодруулбал, Захиргааны хэргийн шүүх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлснийг хянахдаа гагцхүү шийдвэр гаргах ажиллагаа хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянах бөгөөд олонхын саналаар шийдвэрлэсэн буюу Засаг даргыг огцруулах асуудлын хүрээнд “чиг үүргээ хэрэгжүүлсэн (эсхүл биелүүлсэн) эсэх”-тэй холбогдон гарсан улс төрийн шийдвэрт шүүх эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй, энэ нь захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарахгүй...” гэж тайлбарлан давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Тохиолдол 2.

Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 4 дүгээр шийдвэрээр¹⁹ “5. Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн

¹⁸ Улсын дээд шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 0073 тогтоол, https://shuukh.mn/single_case/2877?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

¹⁹ Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 0004 шийдвэр, https://shuukh.mn/single_case/8747?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө”, 11 дүгээр зүйлийн 11.1.9-д зааснаар бүх шатны Засаг даргын албан тушаал нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах улс төрийн албан тушаалд хамаардаг бөгөөд түүнийг томилж, чөлөөлж, огцруулах санал гаргах онцгой бүрэн эрхийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хуулиар олгосон байгаа энэ тохиолдолд захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ нь хурлын үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх буюу огцруулсан шийдвэрийг хууль бус гэж үзэх үндэслэлийг хэлбэрийн талаас шалгах учиртай. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлснийг хянахдаа гагцхүү шийдвэр гаргах ажиллагаа хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянах бөгөөд Засаг даргыг огцруулах асуудлын хүрээнд чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн, биелүүлсэн эсэх бодлогын шийдвэрт шүүх эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй, энэ нь захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарахгүй ..” гэж үзэж маргаан бүхий 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгох үндэслэлгүй хэмээн дүгнэн, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээрх шүүхийн шийдвэрийг хянасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 464 дүгээр магадлал²⁰ “ ...

²⁰ Захиргааны хэргийн давж заалдах шатны

2.2. Анхан шатны шүүх Ц ямар чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлээгүй, ямар хуулийг хэрхэн зөрчсөн талаар хариуцагч нараас тодруулаагүй, маргаан бүхий актыг “улс төрийн шийдвэрт шүүх эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй” гэж дүгнэн үйл баримтын талаар бүрэн дүгнэлгүй хэргийг шийдвэрлэсэн нь буруу байх тул маргаан бүхий актын хууль зүйн үндэслэл тус бүрд бүрэн дүгнэлт өгч хэргийг шийдвэрлэх шаардлагатай байна ...” гэх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Тохиолдол 3.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 06 дугаар шийдвэрээр²¹ “ ... Хурлын төлөөлөгч С.А-ыг огцруулах хуульд заасан үндэслэл үүссэн байгаа боловч С.А-ын бүрэн эрхийн асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 18 дугаар зүйлийн 18.1.1.а-д зааснаар хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай асуудал нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалагдахаар зохицуулагдсан зохицуулалттай нийцсэн гэж үзнэ.

шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 0464 магадлал, https://shuukh.mn/single_case/5155?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн 2023.11.24)

²¹ Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 06 шийдвэр, https://shuukh.mn/single_case/5669?daterange=2019-08-12%20-%202019-08-12&id=1&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



Түүнчлэн нэхэмжлэгч Ч.Ч өмнөх орон нутгийн сонгуульд гуравдагч этгээд С.А-тай Увс аймгийн сонгуулийн 26 дугаар тойрогт өрсөлдөж байсан байх ба С.А-ыг огцруулсан тохиолдолд Ч.Ч нь дараагийн төлөөлөгчөөр сонгогдох боломжтой гэх таамаглалд үндэслэж нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөгдөнө гэж үзэх боломжгүй болно.” гэх үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээрх шийдвэрийг хянасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 10 сарын 31 өдрийн 221/МА2019/0564 дугаар магадлал²² “1. Анхан шатны шүүх “хурлын төлөөлөгч С.А-ыг огцруулах хуульд заасан үндэслэл үүссэн байгаа боловч С.А-ын бүрэн эрхийн асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 18 дугаар зүйлийн 18.1.1.а-д зааснаар хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай асуудал нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалагдахаар зохицуулагдсан зохицуулалттай нийцсэн гэж үзнэ” гэж дүгнэжээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1-д “... дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэж заасан хурлын онцгой бүрэн эрх гэдэг нь зөвхөн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь

хуульд заасан бүрэн эрхийг (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид биш) хэрэгжүүлэх эрх байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.1.а-д “Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн асуудал” гэж заасан нь хурлын төлөөлөгчийн бүрэн эрх үүсэх, дуусгавар болох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх талаарх ерөнхий зохицуулалт байна. Харин тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасан “гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан” тохиолдолд хурлын төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болгох хуулийн заалт нь төлөөлөгчийн бүрэн эрхийн асуудлаарх тусгай зохицуулалт байна.

Хэрэв Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд гагцхүү огцруулах тогтоол гаргахаар тусгайлан хуульчилсан байгаа тул хурал огцруулах тогтоол гаргах үүрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.1.а-д зааснаар хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн асуудлыг хурал хэлэлцэж шийдэхээр ерөнхий байдлаар зохицуулсан боловч мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т хурлын төлөөлөгч “гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан” тохиолдолд хурлын төлөөлөгчийг огцруулах тогтоол гаргахаар тусгайлан хурлаас гаргах шийдвэрийг хуульчлан заажээ.

²² Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 10 сарын 31-ний өдрийн 0564 магадлал, https://shuukh.mn/single_case/3112?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



Энэ тохиолдолд хуулиар тодорхой шийдвэр гаргахыг үүрэг болгосон уг шийдвэрийг ямар үед гаргах талаарх хуульд заасан нөхцөл бий болсон нь тогтоогдсон байхад уг шийдвэрийг гаргахгүй байгаа хариуцагчийн үйлдэл нь хууль бус байна гэж дүгнэжээ.

Тохиолдол 4.

Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 111/ШШ2023/0001 дүгээр шийдвэрээр²³ “... Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн /2006 оны/ 24 дүгээр зүйлийн 24.3-т “Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.” гэж заасан.

Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар дээрх хуулийн шаардлагыг хангаагүй асуудлыг хэлэлцэж, тогтоол гаргасан нь хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Т-н 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлд төлөөлөгч нарт урилга хүргүүлээгүй, хэлэлцэх асуудалтай холбоотой судалгаа, гарах шийдвэрийн талаар баримтжуулаагүй гэх мэдүүлгээр нотлогдоно. Мөн Архангай аймгийн

иргэдийн төлөөлөгчдийн хурал нийт 39 төлөөлөгчтэй. Тэдгээр төлөөлөгчдийн 14 нь Засаг дарга Д.З-г огцруулах саналыг хуралд гаргасан, маргаан бүхий захиргааны актыг гаргасан 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хуралдааны товыг нийт төлөөлөгчдөд мэдэгдсэн эсэх, хэлэлцэх асуудлын талаарх тооцоо судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийг хуралдаан болохоос нэг хоногийн өмнө хүргэгдсэн эсэх нь баримтаар тогтоогдохгүй байна.

Түүнчлэн Архангай аймгийн Засаг дарга Д.З-г огцруулах саналыг Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн /2006 оны/ 32 дугаар зүйлийн 32.6-д “Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь Засаг даргыг огцруулах саналд гарын үсэг зурж Хурлын даргад өргөн мэдүүлсэн бол Хурал 15 хоногийн дотор уг саналыг хуралдаанаараа хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу 15 хоногт багтаан хэлэлцэх хуулийн зохицуулалттай.

Архангай аймгийн Засаг даргыг огцруулах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэр бүхий 14 төлөөлөгчийн санал 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөр огноологдсон боловч аймгийн хурал 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр бүртгэн авсан нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдож байна. Ийнхүү саналыг бүртгэн авсан 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн уг асуудлыг хэлэлцэх хугацаа тоологдож эхэлнэ. Өөрөөр хэлбэл, дээрх хуулийн зүйл, заалтаар Засаг даргыг огцруулах

²³ Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 0001 шийдвэр, https://shuukh.mn/single_case/12421?daterange=2023-01-11%20-%202023-01-13&id=1&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

саналыг хэлэлцэх хугацаа Хурлын даргад өргөн мэдүүлснээс хойш хуанлийн 15 хоног юм. Энэ 15 хоногийн хугацаанд Засаг даргыг огцруулах тухай хүсэлтийг хүлээж авах эсэх саналыг Хуралд оруулах нийтлэг бүрэн эрхээ Хурлын дарга хэрэгжүүлэх, уг эрхээ хэрэгжүүлсэн бол хурлын Тэргүүлэгчид Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний биелэлтийг хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх” ажиллагааг хийх шаардлагатай байжээ.

Саналыг хэлэлцэн шийдвэрлэх хуулийн хугацаа 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр дуусгавар болсон атал Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцэж, маргаан бүхий захиргааны актыг гаргасан нь хууль бус байна.

Дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлэлгүйгээр Засаг дарга Д.З-г албан тушаалаас нь огцруулсан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь...хууль дээдлэх зарчим баримтална.” гэж заасантай нийцэхгүй, нэхэмжлэгчийн хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн гэж дүгнэлээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Засаг дарга...хууль тогтоомж зөрчсөн

буюу чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй бол...” эсэх асуудлыг дүгнэх эрх хэмжээ тухайн хуралд хадгалагдах бөгөөд шүүх асуудлыг хянах эрхгүй, харин маргаан бүхий захиргааны актыг гаргахдаа Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэсэн эсэхэд дүгнэлт өгсөн болно. ...” гэж дүгнэжээ.

Тохиолдол 5.

Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 109/ШШ2023/0015 дугаар шийдвэрээр²⁴ “... ээлжит наймдугаар хуралдаанаар Архангай аймгийн Засаг даргыг огцруулах тухай саналыг хэлэлцэж, Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн аймгийн Засаг даргыг огцруулах тухай 05 дугаартай тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар 35.1.7., 48 дугаар зүйлийн 48.1., 65 дугаар зүйлийн 65.1.2. дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанаар М-ийн Б-г Архангай аймгийн Засаг даргын албан тушаалаас огцруулах тухай саналыг хүлээн авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанаар хэлэлцээд нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнээд

²⁴ Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 0015 шийдвэр, https://shuukh.mn/single_case/13381?daterange=2023-07-21%20-%202023-07-21&id=1&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 53.8 хувийн саналаар дэмжигдсэн тул аймгийн Засаг даргын албан тушаалаас огцруулах саналыг Монгол Улсын Ерөнхий сайдад уламжлахаар шийдвэрлэсэн болох нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байх тул хариуцагч Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд нэхэмжлэгчийг аймгийн Засаг даргын албан тушаалаас огцруулах саналыг Монгол Улсын Ерөнхий сайдад уламжилсныг буруутгах хууль зүйн үндэслэлгүй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1. дэх хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 35.1.7.-д “хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих;”, 48 дугаар зүйлийн 48.1. дэх хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн, баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар батална.” гэж зааснаар аймгийн Засаг даргыг огцруулах саналыг Монгол Улсын Ерөнхий сайдад тавих эрх хэмжээ нь тухайн шатны хурлын онцгой бүрэн эрхэд хамаарч байна.

Маргаан бүхий актаар “Нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн” гэх үндэслэлээр огцруулсан бөгөөд нэхэмжлэгчийн

хувьд Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9-д зааснаар улс төрийн албан тушаалд хамаарч буй учир дээрх үйл баримтын үндэслэлийг хянах захиргааны хэргийн шүүхийн хяналт нь тухайн хурлын үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх буюу “огцруулах санал тавьсан” шийдвэрийг хууль бус гэж үзэх үндэслэлийг “хэлбэр”-ийн талаас нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэсэн эсэхэд дүгнэлт өгсөн болно.

“..,хууль хэрэглэх дарааллын зарчмын үүднээс тухайлсан харилцаанд хамааралтай хэм хэмжээг ерөнхий зохицуулалттай хуулиас түрүүлж хэрэглэнэ, тусгайлсан хуульд маргаантай харилцааг зохицуулсан хэм хэмжээ агуулагдаагүй бол ерөнхий зохицуулалттай хуулийн хэм хэмжээг хэрэглэж шүүх хэргийг шийдвэрлэх зарчимтай.”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Засаг даргыг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө “огцруулах” үндэслэл, журам, шийдвэрлэх процессыг хууль тогтоогч тухайлан зохицуулжээ.

Тиймээс маргаан бүхий эл тохиолдолд сонсох ажиллагаа хийх боломжгүй бөгөөд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаартай тогтоолыг гаргасныг хууль зөрчсөн гэж үзэхгүй, шүүхээс эл тохиолдолд сонсох



ажиллагаа хийх ёстой гэж тухайлан дүгнэх боломжгүй ..." хэмээн тайлбарлажээ.

Өгүүллийн өмнөх хэсэгт дурдсан хуулийн зохицуулалт болон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын агуулгаас үзэхэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь аймгийн Засаг даргыг огцруулах асуудлаар санал тавих эрх хэмжээтэй бөгөөд Засаг даргыг огцруулах эсэхийг шийдвэрлэх эрх хэмжээ Монгол Улсын Ерөнхий сайдад олгогдсон байна. Улмаар Засаг даргыг огцруулах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг Ерөнхий сайд хүлээн авах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй ба иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал бус Ерөнхий сайдын шийдвэр нь тухайн этгээдэд эрх зүйн шууд үр дагавар үүсгэх үр дагавартай юм.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн маргааны хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал /тогтоол/ бус уг саналыг үндэслэн гарч буй дээд шатны Засаг даргын шийдвэр нь маргаж буй этгээдэд эрх зүйн шууд үр дагавар бий болгохоор байна.

Тохиолдол 6.

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн шүүгчийн тусгай санал 2-т " ... Төрийн албаны тухай хууль нь хэдийгээр төрийн албан хаагчийн нийтлэг эрх зүйн байдлыг тодорхойлдог боловч сумын Засаг даргын орлогч нь улс төрийн албан тушаал эрхэлдэг учир түүнийг "чөлөөлөх" харилцаанд Төрийн албаны тухай хуулийг бус, тусгайлсан зохицуулалттай Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дээрх заалтыг

хэрэглэх нь Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т заасан "...бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн ... заалтыг хэрэглэнэ" гэсэн зарчимд мөн нийцнэ ... Анхан шатны шүүх "... хэзээ ямар үүрэг даалгаврыг өгсөн, түүнийг хэрхэн биелүүлээгүй, түүнийг шалгаж дүгнэсэн байдал, ямар ажил үүргийг хэрхэн хангалтгүй биелүүлсэн зэрэг нь захирамжаас тодорхой харагдахгүй байна", "...Төрийн албаны тухай болон бусад хуульд заасны дагуу албан тушаалаас чөлөөлөх үндэслэл бий болсон тохиолдолд ... чөлөөлөх ... эрхээ хэрэгжүүлнэ" хэмээн үндэслэлгүй дүгнэлт хийж, хэрэглэвэл зохих Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсгийг маргааны үйл баримтад холбогдуулан тайлбарлаагүй ..." хэмээн дурджээ.²⁵

Үүнээс үзэхэд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:, 31.1.2-т сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх гэж заасан нь Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон хэм хэмжээ бөгөөд төрийн улс төрийн албан хаагчийн хувьд Засаг даргын орлогчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг Төрийн албаны тухай хуульд зааснаас

²⁵ Улсын дээд шүүхийн 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчийн тусгай санал 2, <https://www.supremecourt.mn/printa?id=36553&tp=2&s=51>. (Сүүлд үзсэн: 2023.11.24)



өөрөөр тусгайлан заасан, нарийвчилсан зохицуулалт байна.

Улсын дээд шүүхээс “аймгийн Засаг даргыг огцруулах тухай асуудлыг хэлэлцсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны шийдвэрийг хянах захиргааны хэргийн шүүхийн хяналт нь тухайн хурлын үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх буюу “огцруулах санал тавьсан” шийдвэрийг хууль бус гэж үзэх үндэслэлийг “хэлбэр”-ийн талаас нь өөрөөр хэлбэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэсэн эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй” гэх тайлбарыг хийсэн байна. Иймд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд Улсын дээд шүүхийн дээрх, тайлбар тогтоолыг шүүхээс цаашид энэ төрлийн маргааныг шийдвэрлэх хууль хэрэглээнд анхаарч, харгалзан үзэх нь зүйтэй юм.

IV. Дүгнэлт, санал

Засаг даргыг огцруулсантай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхэд дараах анхаарах асуудал байна. Тухайлбал,

1. Засаг даргыг огцруулахаар санал уламжилж буй тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал буюу тогтоол нь захиргааны актын эрх зүйн шууд үр дагавар үүсгэх шинжийг агуулж буй эсэх;
2. Засаг даргыг огцруулахаар санал уламжилж буй тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал буюу тогтоолыг шүүх хянах хяналтын хүрээг тодорхойлох юм.

Эхний асуудлын тухайд, Захиргааны хэргийн шүүх нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1., 3 дугаар зүйлийн 3.1.3. Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д зааснаар захиргааны акт хуульд нийцсэн эсэх, захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар зохицуулсан.

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1. дэх хэсэгт Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар ... эрх зүйн шууд үр дагавар бий болгосон ... захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно гэж зааснаар шүүхэд захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргах урьдчилсан нөхцөл нь тухайн нэхэмжлэлээр маргаж буй захиргааны үйл ажиллагааны хэлбэр нь захиргааны акт байх ёстой.

Өгүүлэлд дурдаж буй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан Засаг даргыг огцруулах тухай саналыг Ерөнхий сайд хүлээн авах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхтэй ба иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал бус Ерөнхий сайдын шийдвэр нь тухайн этгээдэд эрх зүйн шууд үр дагавар үүсгэх үр дагаварт ай гэж үзэж болохоор байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Засаг даргыг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө “огцруулах” үндэслэл, журам,



шийдвэрлэх процессыг хууль тогтоогч тухайлан зохицуулсан.

Өөрөөр хэлбэл, олонхоор шийдвэрлэсэн, ялангуяа Засаг даргыг огцруулах асуудлын хүрээнд “чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн эсэх” зэрэг бодлого (улс төр)-ын шийдвэрт шүүх эрх зүйн үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй, энэ нь захиргааны хэргийн шүүхийн хяналтад хамаарахгүй, шүүхийн магадлах, эрх зүйн дүгнэлт өгөх хүрээ хязгаарт хамаарахгүй гэж үзэх боломжтой.

Тодруулбал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан “Засаг даргыг огцруулах тухай” санал нь Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах улс төрийн шийдвэр, энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх эрхийг дээд шатны Засаг даргад ямар нэгэн шалгуургүйгээр олгосон байх тул шүүх Засаг даргыг огцруулсан шийдвэрүүдэд эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй, захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ нь Хурлын үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэхээр хязгаарлагдана²⁶ гэж үзжээ.

Иймд Засаг даргыг огцруулахтай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянах хяналтын хүрээ нь процедурын шинжтэй үйлдэлд нь хэлбэрийн талаас нь эрх зүйн дүгнэлт өгөхөөр хязгаарлагдах нь зүйн хэрэг болохыг дурдах нь зүйтэй байна.

V. Ном зүй

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Монгол Улсын Засаг захиргаа,

²⁶ Шүүхийн шийдвэрийн хураангуй, “Захиргааны байгууллагаас гаргасан улс төрийн шийдвэрийг шүүх хянахгүй,” <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/119>. (Сүүлд үзсэн: 2023.11.24)

- нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020 он
3. Захиргааны ерөнхий хууль (2015)
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
5. Төрийн албаны тухай хууль (2017)

Ном, судалгааны бүтээл

1. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2022.
2. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016.
3. Д.Ганзориг бусад, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022.
4. Т.Мөнх-Эрдэнэ, “Захиргааны байгууллагын губернатив ба административ үйл ажиллагаа” эрдэм шинжилгээний legaldata.mn, 2023.
5. Ц.Цогт, “Захиргааны шийдвэрийг шүүхээс магадлан шийдвэрлэх ажиллагааны стандарт” legaldata.mn, 2023.
6. Монголын хуульчдын холбоо, Засгийн газар хууль дээдлэх: шүүхэд гомдол гаргах эрхийн баталгаа эмхэтгэл, 2019.
7. УДШ-ийн Шүүхийн практик судлалын хэлтэс, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2018 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм, 2019.



Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn
2. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: www.Shuukh.mn
3. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл: www.judcouncil.mn
4. Монгол Улсын хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: www.legaldata.mn

**Abstract****THE ADMINISTRATIVE COURT'S FRAMEWORK OF CONTROL TO DISPUTE
RESOLUTION RELATED TO DISMISSAL OF THE GOVERNOR****A.TUVSHINTULGA***Judge on the Administrative Court of First Instance
in Arkhangai aimag (province) of Mongolia***G.TSERENDEJID***Judicial Assistant on the Administrative Court of First Instance
in Arkhangai aimag (province) of Mongolia*

This article aims to bring to light the compliance with the laws of dismissing the Governors at all levels, and to make a proposal for dismissal, and its decision-making process, in accordance with the regulations specified in the Law of Mongolia on Administrative and Territorial Units and Their Governance. Moreover, it aims to bring up some issues that are challenging in judicial practice, which relates to the framework of control and its features for considering such cases by

the Administrative Court, as well as provide some recommendations that are important to solving these issues.

Keywords

Court control, the Governor, a proposal to dismiss the Governor, a framework for control of the Administrative Court, specific regulation, general regulation, rules specified in the law, legal grounds to dismiss, rules, legal opinion.

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН САХИЛГЫН
ХОРООНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ**

**HISTORICAL DEVELOPMENT OF THE JUDICIAL DISCIPLINARY
COMMITTEE OF MONGOLIA**

Б.СУГАР¹

- I. Олноо өргөгдсөн Монгол Улсын үе (1911-1921 он)
- II. Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үе (1921-1940 он)
- III. БНМАУ-д социализмын үндсийг байгуулах үе (1940-1960 он)
- IV. БНМАУ-д социализм байгуулах үе (1960-1990 он)
- V. Монгол Улсын ардчилсан шинэ үндсэн хуулийн эрх зүйн орчин дахь шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлага
- VI. Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүхийн тогтолцоог нийцүүлэх үе (1993-2002 он)
- VII. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх үе (2002-2013 он)
- VIII. Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг эрчимжүүлэх үе (2013-2021 он)
- IX. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн үе (2021-)
- X. Дүгнэлтийн оронд
- XI. Ном зүй

¹ Шүүхийн сахилгын хорооны гишүүн



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Б.СУГАР, Шүүхийн сахилгын хорооны гишүүн

Түлхүүр үг

Шүүх, шүүгч, шүүгчийн ёс зүй, шүүгчийн сахилга, шүүгчийн хариуцлага, Шүүхийн сахилгын хороо, шүүгчийн хариуцлагын тогтолцоо

Хураангуй

Энэхүү нийтлэлд Олноо өргөгдсөн Монгол Улсын үеэс эхлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт хүртэлх буюу өнөө үе хүртэлх түүхийг хураангуйлан авч үзлээ. Шүүгчийн ёс зүй, сахилгын асуудлыг анх 1954 онд тусгайлан дүрмээр тогтоож, 1970 онд тус дүрмийг шинэчлэн баталж, энэ уламжлал үргэлжилжээ. Үүнээс хойш Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн эрх зүйн орчин дахь шүүхийн тогтолцооны хөгжилд гарсан гол өөрчлөлт, хууль тогтоомжийн шинэтгэлтэй уялдаатайгаар шүүгчийн ёс зүй, сахилгын зохицуулалт, хэрэгжилтийг дотор нь Олноо өргөгдсөн Монгол Улсын үе (1911-1921 он), Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үе (1921-1940 он), БНМАУ-д социализмын үндсийг байгуулах үе (1940-1960 он), БНМАУ-д социализм байгуулах үе (1960-1990 он), 1993-2002 он, 2002-2013 он, 2013-2021 он, 2021 оноос өнөөг хүртэлх

хугацааг хамруулан авч үзэж, үечлэн түүхэн хөгжлийг бичихийг зорилоо.

I. Олноо өргөгдсөн Монгол Улсын үе (1911-1921 он)

Монгол Улс 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, хаант төрийн анхны таван яам байгуулсны нэг нь Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яам байжээ.

Богд хаант Монгол Улсын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яам нь орчин цагийн Монгол Улсын шүүхийн эхлэл байв. Тэнд шүүн таслах, эрх зүйн баримт бичгийн төсөл зохиох үндсэн үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ захиргааны чиг үүргийг давхар гүйцэтгэж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Энэ үед буюу 1912 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Богд хаан дээд зарлиг буулгаснаар Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны болон төрийн албан хаагчид Автай сайн хааны өргөөний өмнө “Ум сайн амгалан болтугай. Манай улсын шашин, төрийг түг түмэн онд бат болгох учир бурхан номын сахиусны өмнө батад тангараглах нь: Манай халхын хан, ван, гүн засаг, Эрдэнэ шанзудба, Да лам нар түшмэдээс эхлэн шар, хар болон бүхнээр Очирдара



Богд гэгээнтнээ шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, Түмэн наст богд эзэн хаан өргөмжлөн эрдэнийн сууринаа залаад Монгол Улсын тулгар төрийг шинэ байгуулсан цаг, бидний Монгол овгийн сайд, ноёд, түшмэд бүгдээр бурхан хааны түгээмэл өршөөлт их төрийн элдэв хэрэгт буцашгүй шударга чигч магад үнэнээр нэгэн сэтгэл хүчнээ гаргаж зүтгэн чин үнэнхүү туйлын санаагаар гүйцэтгүүлсүгэй. Жич, үүнээс цааш энэ тухайд дутагдсан ноёд шинэ тутам дагаар ирэгсдийг мөн тухай бүр ийнхүү бат тангараг хийлгэж амьсгал санааг итгүүлж нэгэн чанар болгож энх түвшин шашин төрд үүрд цэнгэлдүүлэхийг айлдан айлд” гэсэн тангараг өргөсөн байна. Энэ нь Монголчуудын үндэсний тусгаар тогтнолынхоо нэгэн сэтгэлээр бат тангараг барилдан зүтгэх уламжлалыг бий болгосон байдаг.

Улсын эзэн хаанаар 1918 онд батлуулсан “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг” хууль нь 65 дэвтэр 1100 орчим заалтыг багтаасан. Түүнд зааснаар Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамыг Шүүх, Ариутгах хоёр хэлтэстэй, тэргүүн сайдаас ташуурч хүртэл 55 орон тоотойгоор баталжээ.¹

Түүнчлэн “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг”-ийн 65 дэвтрийн 6-10 дугаар дэвтэрт оруулсан нийт 5 дэвтэр, 96 зүйл бүхий түшмэлийн зэрэг, дэв, түшмэлийг сонгон шалгаруулах, тушаал дэвшүүлэх, бууруулах, багасгах гээд бүхий л харилцааг зохицуулсан хуулийг “Түшмэл байгуулах тушаал

хууль” хэмээн нэрлэсэн буй.² Энэ хууль нь тухайн үеийн шүүх таслах ажилд оролцож байсан түшмэлийн чиг үүрэг, ёс зүй, хариуцлагыг нэгтгэн зохицуулсан онцлогтой байна.

II. Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үе (1921-1940 он)

Ардын төрд шүүн таслах ажлыг шилжүүлэх үйл явц 1921-1924 онд эрчимтэй өрнөсөн нь 1921 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Ардын намын төв хороо Түр засгийн газрын хамтарсан хурлаас Түр засгийн газрын харьяа гурван яамыг байгуулж, Дотоод яамны бүтцэд шүүн таслах хэлтэс байгуулахыг, цэргийн яаманд цэргийн хэргийг шүүн таслах газрыг байгуулахыг үүрэг болгосон байгаагаас харагдана.

МАХН-ын Төв хороо, Ардын түр Засгийн газрын гишүүдийн 1921 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан хурлын шийдвэрээр Хүрээний хуучин засгийн газрыг татан буулгаж засгийн дээд эрхийг Ардын засгийн газарт шилжүүлэх цагт таван яам, түүний дотор Шүүх яамыг уламжлан байгуулжээ.

“Уриа” сэтгүүлд 1921 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр нийтлэгдсэн Монгол Улсын Засгийн газрын хууль цаазын бодлогыг тодорхойлсон мэдээлэлд “ялтны хэргийг шийдэхэд дээд, доод гэж ялгахгүй нэгэн адил шүүн таслах” гэжээ. Шүүх яам нь шүүхийн байгууллагын бие даасан тогтолцоо бүрэлдэх хүртэл 6 жил орчим шүүхийн захиргааны төв байгууллага төдийгүй шүүн таслах дээд байгууллагын үүрэг гүйцэтгэсэн.³

1 С.Бадарчи, “Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн (Богд хаант Монгол Улсын) шүүх,” Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын дээд шүүх, “Монгол Улсын шүүхийн товчоон,” 2011, 107, 111, 116, 117 дэх тал.

2 Ерөнхий редактор Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 2 дугаар боть, 2010, 215-230 дахь тал.

3 А.Түвшинтулга, “Ардын хувьсгал ялж Монголын



Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын анхдугаар Их хурлаар баталсан. Гэхдээ түүнд шүүхийн тогтолцоотой холбоотой тусгайлсан бүлэг, зүйл ороогүй. Улсын II Их Хурлаас 1925 оны 11 дүгээр сард гаргасан “Шүүх таслах хэргийг шинэтгэн байгуулах тухай” тогтоол нь Үндсэн хуульд тусгагдаагүй үлдсэн асуудлыг төрийн эрх барих дээд байгууллагаас анхлан тодорхойлсон шинжтэй бөгөөд түүнд “шүүх таслах газар нь ардын шүүх байхын тулд ард олны сонгуулиар байгуулагдаж ажилдаа олон түмэн хийгээд ардын төлөөлөгчдийг оролцуулж тэдэнд ойр чирэгдэлгүй ажиллана”, “шүүгдэгч нь шүүгч, ардын төлөөлөгчийг татгалзах эрхтэй байна” гэжээ.⁴

Үүнээс хойш 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15 дугаар хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүх таслах газруудыг байгуулах тухай дүрэм”-ийг ерөнхий анги, ардын шүүх таслах газруудыг сонгох шилжүүлэх, ардын төлөөлөгчийг сонгох ба тэдний аливаа тушаалаа явуулах тухай гэсэн 3 бүлэг 24 зүйлтэй батлан гаргажээ. Энэхүү дүрэм нь Монголын төрт ёсны түүхэнд анх удаа “шүүхийн нэгдсэн тогтолцоо” үүсэж бий болох нөхцөлийг бүрдүүлжээ. Уг дүрэм ёсоор 1926 онд 5 аймаг, 3 хот, 71 хошуунд шүүх таслах газрыг байгуулж, улмаар Засгийн газрын 1926 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас Шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах

тусгаар тогтнолыг бататгасан үеийн шүүхийн тогтолцоо,” Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын дээд шүүх, “Монгол Улсын шүүхийн товчоон,” 2011, 131 дэх тал.

4 БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхгууд, 1956, 48-50 дахь тал.

тухай дүрмийг баталж, БНМАУ-ын Дээд шүүх таслах газрыг байгуулжээ.⁵

Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үе буюу 1921-1940 онд шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар баримтлах бодлого, шийдвэрийг тэр үеийн улс төрийн хүчин болох МАХН, Засгийн газар тодорхойлж, шүүхэд улс төр, намын үзэл суртал, ангич шинж давамгайлж байжээ.⁶

Энэ үед шүүгчийн ёс зүй, сахилгын талаарх тусгайлсан хэм хэмжээний талаар эх сурвалжид тодорхойгүй байна. Мөн 1939 онд хуралдсан Улсын XXII бага хурал “...сумын захиргаанаас шүүн таслах ажлыг тусгаарлан явуулах...” нь зүйтэй гэж заасан нь БНМАУ-ын Үндсэн хуулиар шүүхийн тогтолцоо, зарчмыг бэхжүүлэн тогтооход тусгалаа олжээ.⁷

III. БНМАУ-д социализмын үндсийг байгуулах үе (1940–1960 он)

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг 1940 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын VIII Их Хурлаар баталсан. Тус Үндсэн хууль 12 бүлэг, 95 зүйлтэй. БНМАУ-ын Үндсэн хуульд 16 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.⁸

Энэхүү Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлд “Шүүгч нь аливаа хэрэг таслахдаа бусдад хамаарагдахгүй,

5 А.Түвшинтулга, “Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үеийн шүүхийн тогтолцоо,” Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын дээд шүүх, “Монгол Улсын шүүхийн товчоон,” 2011, 138 дахь тал.

6 А.Түвшинтулга, “Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үеийн шүүхийн тогтолцоо,” Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын дээд шүүх, “Монгол Улсын шүүхийн товчоон,” 2011, 163, 164 дэх тал.

7 БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхгууд, 195, 366 дахь тал.

8 Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992) <https://www.parliament.mn/nn/13466/>



гагцхүү хуульд захирагдана” гэж заасан нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн үндэс болжээ.

Энэ үед “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн дээд эрхийг барих газар нь Улсын Их Хурал болно. Улсын Их Хурлын чөлөө завсар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн дээд эрхийг Улсын Бага Хурал барина” гэж төрийн эрх барих байгууллагын талаар заасан.

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1949 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн “БНМАУ-ын Шүүхийн зохион байгуулалтыг батлах тухай” 09 дүгээр зарлигаар БНМАУ-ын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийг баталжээ.

Энэ хуулийн 14 дүгээр зүйлд “Дээд шүүхийн гишүүд, тусгай шүүхийн гишүүдийг албан тушаалаас нь чөлөөлөх явдлыг Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар гүйцэтгэнэ. Аймаг, хотын ардын шүүхүүдийн шүүгч нарыг албан тушаалаас нь чөлөөлөх явдлыг аймаг, хотын гүйцэтгэх захиргааны хурлын шийдвэрээр гүйцэтгэнэ. Хэсгийн шүүгч нар ба ардын төлөөлөгч нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх явдлыг уул сонгогчдын саналаар гүйцэтгэнэ” гэж тухайн үеийн шүүгчдийг чөлөөлөх шийдвэр гаргах этгээдийг тусгайлан зааж байжээ.⁹

Улмаар БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1958 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 180 дугаар зарлигаар БНМАУ-ын шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийг баталж, дээрх хууль хүчингүй болжээ.

9 Ерөнхий редактор Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 4 дүгээр боть, 2010, 371 дэх тал.

Энэ хуулийн 17 дугаар зүйлд “БНМАУ-ын Дээд шүүх, тусгай шүүхийн шүүгч нарыг албан тушаалаас нь, мөн тэдгээрийн ардын төлөөлөгчдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг БНМАУ-ын Их Хурлаас гүйцэтгэнэ. Аймаг, хотын шүүхийн шүүгч, ардын төлөөлөгч нарыг үүрэгт нь ажлаас нь чөлөөлөхийг аймаг, хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын чуулганы шийдвэрээр гүйцэтгэнэ. Хэсгийн шүүгч, ардын төлөөлөгч нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг сонгогчдын саналаар гүйцэтгэнэ” гэжээ. Энэ зохицуулалтад шүүгчдэд сахилгын хариуцлага тооцон чөлөөлөх ба бусад үндэслэлээр чөлөөлөхийн аль нь болохыг тусгайлан заагаагүй байна.

Хуулийн зохицуулалтын дагуу БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн “Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм”-ийг батлах тухай 95 дугаар зарлигийн хавсралтаар Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм батлав.¹⁰

Тус дүрэмд зааснаар шүүгчдийн албан ажлын ямар нэгэн эндэгдэл, зан авирын зохимжгүй явдлууд нь шүүхийн нэр хүндийг гутаадгаар барахгүй шүүх таслах явдал, улсын ашиг сонирхол, ард иргэдийн эрхэд хор хүргэдэг учраас ийм явдлыг гаргасан шүүгчдэд хатуу хариуцлагыг хүлээлгэнэ.

Сахилга батын хариуцлагад татах зөрчилд “Хөдөлмөрийн сахилга батыг гажуудуулсан”, “Шүүхийн ардчилсан зарчмыг зөрчсөн, удирдлагын тушаал, даалгаврыг шуурхай биелүүлээгүй

10 Ерөнхий редактор Б.Чимид, Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 4 дүгээр боть, 2010, 472 дахь тал.



буюу шүүгчийн нямбай биш ажиллагаа хийгээд сахилга батгүй явдлын улмаас шүүх таслах ажилд гарсан дутагдал”, “Шүүгчийн алдар хүндэд зохимжгүй явдлуудыг үйлдсэн” нь хамаарч байв.

Эдгээр зөрчилд


- сануулах;
- донгодох;
- хатуу донгодох;
- огцруулах асуудлыг тавих хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Энэхүү хариуцлагын төрөл, хэлбэр нь уламжлан хадгалагдаж, өнөөгийн шүүгчийн сахилгын шийтгэлийн төрлийн үндэс болжээ.

“Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм”-д шүүгчдээс гаргасан сахилга батын эндэгдлийн хэргүүдийг хэлэлцэж байхын тулд БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэд сахилга батын хэргийн коллеги байгуулахаар заажээ.

Сахилга батын хэргийн коллегийг Дээд шүүхийн даргын томилолтоор байгуулах бөгөөд түүний бүрэлдэхүүнд Дээд шүүхийн дарга эсвэл түүний орлогчоос гадна хоёр гишүүн орохоор заасан. Шүүгчийн сахилгын хэргийг Дээд шүүхийн тусгайлсан коллеги хариуцаж, энэ хэрээр сахилгын хэргийг чухалчлан авч үзэж байсан нь харагдана.

Бүдүүвч 1:



Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэмд сахилгын хэргийг албан тушаалтан болон иргэний гомдол, мэдээллийн дагуу үүсгэх талаар тусгайлан заагаагүй байна. Харин тус дүрмийн 3-т зааснаар сахилга батын хэргийг үүсгэх эрхтэй хүмүүс нь бүх шүүгчдийн хувьд Шүүх яамны сайд, дээд шүүхийн гишүүдийн хувьд Дээд шүүхийн дарга, цэргийн шүүхүүдийн дарга нар ба гишүүдийн хувьд цэргийн коллегийн дарга байв. Энэ нь сахилгын хэрэг үүсгэх харьяаллыг тогтоосон онцлогтой болжээ.

Шүүгчийн сахилга батын хариуцлагын тухай дүрмийн 14-т “Сахилга батын коллегиос гаргасан шийдвэр нь эцсийн байх учир түүнийг даван заалдах эрхгүй” гэжээ. Энэ нь сахилгын хэргийг Дээд шүүхийн дэргэдэх сахилга батын хэргийн коллеги эцэслэн шийдвэрлэж байсныг харуулж байна.

IV. БНМАУ-д социализм байгуулах үе (1960–1990 он)

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг 1960 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан. Тус Үндсэн хууль 10 бүлэг, 94 зүйлтэй. БНМАУ-ын Үндсэн хуульд 16 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэхүү Үндсэн хуулийн Далан нэгдүгээр зүйлд “Шүүгч нар хэргийг шүүн таслахдаа хэний ч нөлөөнд үл автан, гагцхүү хуульд захирагдана” гэж заасан нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн үндэс болжээ. Мөн Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд “Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт төрийн эрхийг барих дээд байгууллага мөн” гэж заасан бөгөөд түүний эрх хэмжээ нь өнөөгийн



Улсын Их Хурлынхтай дүйцэж байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар зарлигийн хавсралтаар “БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэм” батлав.¹¹

БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэмд зааснаар шүүгчдэд сахилга батын хариуцлага хүлээлгэх үндэс нь

- Хөдөлмөрийн сахилга бат гажуудуулах, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандах, албан үүргийн эндэгдэл гаргах, удирдлагын үүрэг даалгавар үл биелүүлэх буюу ёс төдий хандах,
- Шүүхийн ардчилал зөрчих, эрүү, иргэний болон байцаан шийтгэх хуулийг зөрчиж социалист хууль ёс гажуудуулах,
- Албан байгууллага хөдөлмөрчдийн өргөдөл гомдол шуурхай бус хандаж чирэгдүүлэх,
- Шүүхийн байгууллага, шүүгчийн нэр хүндэд харшлах үлгэргүй байдал гаргах байв.

Эдгээр зөрчилд

- сануулах;
- донгодох;
- хатуу донгодох;
- албан тушаалаас нь 6 сар хүртэл хугацаагаар огцруулж дорд тушаалын ажилд шилжүүлэх санал тавих;
- шүүгчийн гаргасан зөрчил нь түүнийг цаашид шүүгчээр

¹¹ Ерөнхий редактор Б.Чимид. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 5 дугаар боть, 2010, 583 дахь тал.

ажиллуулах боломжгүйд хүргэсэн бол ажлаас халах санал тавих хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Үүнээс хойш БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “БНМАУ-ын Шүүх байгууламжийн тухай хууль, түүнд холбогдох бусад дүрмийг батлах тухай” 302 дугаар зарлигаар баталсан БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн тухай хуулийн “Шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлага” гэсэн 65 дугаар зүйлд “Шүүгч нь хөдөлмөрийн сахилга зөрчих, шүүн таслах ажилд алдаа дутагдал гаргах, шүүхийн байгууллага, шүүгчийн нэр хүндэд харшлах байдал гаргавал сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс баталсан дүрмээр тогтооно” гэж заажээ.¹² Үүний дагуу “БНМАУ-ын шүүхүүдийн шүүгч, ардын төлөөлөгчийг хугацааны өмнө огцруулах журмын тухай дүрэм” баталжээ.¹³

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 205 дугаар зарлигаар БНМАУ-ын шүүгч бүр тангараг өргөж байх журам тогтоож, тангаргийн үг болон тангараг өргөх журмыг хавсралтаар баталжээ.¹⁴ Хожим энэхүү тангаргийн үг уламжлал болж, шүүхийн хууль тогтоомжид тухай бүр тусгаж иржээ. Шүүгчийн тангаргийн үгэнд шүүгчийн ёс зүйн талаар ямагт тусгаж байв.

¹² Ерөнхий редактор Б.Чимид. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 5 дугаар боть, 2010, 363 дахь тал.

¹³ Монгол Улсын дээд шүүх, “Монголын шүүх I” хууль тогтоомжийн эмхэтгэл, хоёрдугаар хэсэг (1960-1991), 2017, 67 дахь тал.

¹⁴ Монгол Улсын дээд шүүх. “Монголын шүүх I” хууль тогтоомжийн эмхэтгэл, хоёрдугаар хэсэг (1960-1991), 2017, 139 дэх тал.



БНМАУ-ын Дээд шүүхийн Тэргүүлэгчдийн 1989 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар “Ардын шүүгчдийн ажил мэргэжлийн ёс зүйн зарчим, төр, ард түмний өмнө хүлээх үүрэг, хариуцлага” гэх дүрмийг баталсан. Үүнд “Шүүгч хүнлэг байх зарчмыг үйл ажиллагаандаа ямагт удирдлага болгож ‘Хүний эрхийн түгээмэл тунхаглал’-ын үзэл санааг чанд баримтална” гэж онцолжээ. Энэ нь бие хүнийг хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй байхыг шүүгчийн ёс зүйн үндэс болгосныг харуулж байна.¹⁵

БНМАУ-ын Бага хурлын 1991 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар БНМАУ-ын шүүгчийн тангаргийг баталжээ. Энэ тангарагт “Шүүгч би гагцхүү БНМАУ-ын хуулийг эрхэмлэн дээдэлж, хэний ч нөлөөнд үл автан ажиллаж, шүүгчийн ариун нэр төрийг өндөрт өргөж явахаа батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаа няцвал төрийн хуулийн хатуу цээрлэл хүлээнэ” гэжээ.¹⁶ Энэ тангаргийн үг нь дараа, дараагийн хууль тогтоомжид заасан шүүгчийн тангаргийн үгийн бүтцийн үндэс болжээ.

БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрмийн 5-т БНМАУ-ын Дээд шүүх, аймаг, хотын шүүхийн дэргэд шүүгчийн сахилга батын тухай хэргийг хэлэлцэхийн тулд шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллеги байгуулахаар заасан.


БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийг БНМАУ-ын Ардын Их Хурлын

Тэргүүлэгчдээс 3 жилийн хугацаагаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Аймаг, хотын шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийг аймаг, хотын шүүгчдийн дотроос мөн шүүхийн дарга нарын саналыг үндэслэн аймаг, хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурлаар 2 жилийн хугацаагаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

Үүний дагуу БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллеги байгуулах тухай” 72 дугаар зарлигаар БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийг 4 жилийн хугацаагаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Тус коллегийн даргаар Улсын дээд шүүхийн нэгдүгээр орлогч дарга Цэндийн Лувсаншарав, гишүүнээр Улсын дээд шүүхийн гишүүн Тогтохбуянгийн Дэндэв, Лувсандашийн Зэвгээ, Жамбын Ичинхорлоо, Буяндэлгэрийн Санжмятав нар томилогджээ. Харин энэ зарлигийг эрх зүйн зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хожим буюу БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар зарлигаар хүчингүй болгожээ.

Бүдүүвч 2:



15 Б.Сугар, Шүүгчийн ёс зүйн дүрмүүд эмхэтгэл, 2021, 18-21 дэх тал.

16 Монгол Улсын дээд шүүх, “Монголын шүүх I” хууль тогтоомжийн эмхэтгэл, хоёрдугаар хэсэг (1960-1991), 2017, 167 дахь тал.



БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэмд сахилгын хэргийг албан тушаалтан болон иргэний гомдол, мэдээллийн дагуу үүсгэх талаар тусгайлан заагаагүй байна. Харин тус дүрмийн 6-д “БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид Улсын Дээд шүүхийн гишүүд, аймаг, хот, тусгай шүүхийн дарга, орлогч дарга нарт холбогдох сахилга батын хариуцлагын талаар үүсгэсэн хэргийг хэлэлцэнэ. Аймаг, хотын шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид нүүдлийн шүүгчид, хот /аймгийн харьяа/ районы шүүхийн дарга, шүүгчид, аймаг, хотын шүүхийн гишүүдийн талаар үүсгэсэн сахилга батын хэргийг хэлэлцэнэ” гэж заасан. Энэ нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоосон онцлогтой байжээ.

Мөн дүрмийн 18 дугаар зүйлд “Аймаг, хотын шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегийн тогтоол гарсан өдрөөс эхлэн арга хэмжээ авагдсан этгээд өөрийн гомдлыг 7 хоногийн дотор уг коллегитор дамжуулан БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид гаргаж болно. Уг гомдлыг хэргийн хамт 3 хоногийн дотор БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегид явуулна. БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгч нарын сахилга батын хэрэг эрхлэх коллегиос эцсийн шийдвэр гаргах тул түүнийг давж заалдах эрхгүй” гэж заасан байна. Энэ нь сахилгын хэргийг Дээд шүүхийн дэргэдэх сахилга батын хэргийн коллеги эцэслэн шийдвэрлэж байсныг харуулж байна.

V. МОНГОЛ УЛСЫН АРДЧИЛСАН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН ДАХЬ ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

Монгол Улсын Ардчилсан шинэ Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлаар баталсан. Ардчилсан шинэ Үндсэн хууль 6 бүлэг, 70 зүйлтэй. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-т “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, 2-т “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж зааснаар шүүгч хараат бус байх төдийгүй ёс зүйтэй байх эрх зүйн үндсийг тодорхойлсон.

Мөн Дөчин наймдугаар зүйлийн 2-т “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж зааснаар Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу тусгайлсан хууль тогтоомжийг батлах болов. Улсын Их Хурлаас эдгээр хууль тогтоомжийг баталж, үйлчилсэн хугацаа болон шүүхийн тогтолцоонд гарсан өөрчлөлтийг харгалзан 1993-2002 он, 2002-2013 он, 2013-2021 он, 2021-2023 оныг хамарсан зурвас үеэр зааглан авч үзлээ.

Тодруулбал, Улсын Их Хурлаас 1993 онд баталсан Монгол шүүхийн тухай хуульд Үндсэн хуулийн үзэл баримтлал, зохицуулалтын дагуу шүүхийн тогтолцоог шинэчлэх, 2002 онд баталсан Шүүхийн тухай хуульд шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохоос гадна шүүгчийн



хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах, 2012 онд баталсан Шүүхийн тухай багц хуульд /Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль/ шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг бэхжүүлэх, 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2021 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг хуульчлахад анхаарчээ.

VI. Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүхийн тогтолцоог нийцүүлэх үе (1993-2002 он)

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2-т “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж, Дөчин есдүгээр зүйлийн 1-т “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж, 3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана” гэж заасан.

Ийнхүү Үндсэн хуульд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд Шүүхийн ерөнхий зөвлөл ямар эрх хэмжээтэй, чиг үүрэгтэй байх талаар хуульд тусгайлан заах шаардлагыг бий болгож, шүүхийн тогтолцоонд шүүхээс гадна ямар байгууллагууд ажиллах талаар тусгах болов.

Улсын Их Хурлаас 1993 оны 2 дугаар сарын 04-ний өдөр баталж, 2 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 8-д зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл “... шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, ... тогтоох” бүрэн эрхийг хэрэгжүүлэх болов.¹⁷

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1997 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Дүрэм батлах тухай” 03 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг батлав. Энэхүү 1997 оны “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-д “Шүүгчийн ёс зүйн үндсэн зарчим”, “Шүүгчийн биеэ авч явах ёс зүй”, “Улс төрийн хүрэн дэх ёс зүй”, “Санхүүгийн үйл ажиллагааны хүрэн дэх ёс зүй”-г тусгайлан зохицуулсан байна.

Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл

- сануулах;
- шүүгчдийн өмнө буруушаан зэмлэх;
- шүүгчийн албан тушаалын цалинг 3-6 сарын хугацаагаар 20 хүртэл хувиар хасах;
- шүүгчээс огцруулахаар заажээ.

Үүнээс хойш Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2002 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн “Шүүгчийн ёс зүйн дүрэм батлах тухай” 15 дугаар тогтоолоор тус дүрмийг шинэчлэн баталсан байна. Энэ дүрэм нь Шүүхийн тухай шинэ хуулийн дагуу Шүүгчдийн зөвлөлөөс шинэ ёс зүйн дүрэм батлах хүртэлх 10 сарын хугацаанд үйлчилжээ.

¹⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 он, №2.




VI.I. Монгол Улсын Шүүгчийн сахилгын хороо /1993-1994 он/:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд Шүүгчийн сахилгын хорооны талаар заасан. Тодруулбал, Шүүгчийн сахилгын хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, 6 жилийн хугацаагаар Шүүхийн ерөнхий зөвлөл байгуулах, Шүүгчийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд өндөр мэргэшилтэй, ажил, амьдралын туршлагатай шүүгчдийг оруулах, Шүүгчийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн орохгүй байх, Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг Шүүхийн ерөнхий зөвлөл батлахаар зохицуулсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1993 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн “Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн анхдугаар хуралдаанд хэлэлцэх асуудлыг батлах тухай” 01 дүгээр тогтоолд нийт 11 асуудлыг тусгасан байх бөгөөд үүнд “Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг батлах тухай” заажээ.

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1993 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Шүүгчдийн сахилгын хорооны дүрэм”-ийг баталж, 1993 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Шүүгчийн сахилгын хороог байгуулжээ.

Бүдүүвч 3:



Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн “Монгол Улсын шүүхийн тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай” 1994 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх тухай, сахилгын шийтгэлд гомдол гаргах, сахилгын шийтгэлийн төрөл сонгох тухай заалтууд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж үзжээ.¹⁸

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн “Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай” 1994 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Шүүгчийн сахилгын хороог байгуулж, дүрмийг батлах, сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох, сахилгын хорооны шийдвэрийг хянах, сахилгын шийтгэл ногдуулах эрх хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон байдаг.¹⁹

VI.II. Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо /1994-2002 он/:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд Шүүгчийн сахилгын хорооны тухай заасан. Энэ зүйлийг “Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр дүгнэлттэй маргааныг

18 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 он, №2.


19 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 он, №4.



эцэслэн хэлэлцсэн тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 1994 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулжээ.

Энэхүү өөрчлөн найруулсан зүйлд сахилгын зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэх Шүүгчийн сахилгын хороо Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэд тус тус ажиллах, Аймаг, нийслэлийн шүүхийн дэргэдэх Шүүгчийн сахилгын хороо аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдийн хуралдаанаас, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүгчийн сахилгын хороог Улсын дээд шүүхийн хуралдаанаас 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй 6 жилийн хугацаагаар тус тус сонгох, Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг Ерөнхийлөгч батлахаар тус тус заасан байна.

Бүдүүвч 4:



Үүний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн “Дүрэм батлах тухай /Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хорооны дүрэм/” 7 дугаар зарлигийн хавсралтаар “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хорооны дүрэм”-ийг баталсан.²⁰

Энэ дүрэмд зааснаар Сахилгын

²⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 он, №4.

хорооны бүрэлдэхүүнд шүүгчээр аль болох олон жил ажилласан, өндөр мэргэшилтэй, ажил амьдралын туршлагатай шүүгчдийн нэрийг дэвшүүлнэ. Шүүгчийн сахилгын хорооны гишүүдийг сонгох шүүгчдийн хуралдааныг түүнд оролцвол зохих нийт шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэй гэж үзнэ.

Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч болон сум буюу сум дундын дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид үүсгэсэн сахилгын хэргийг тухайн аймаг, нийслэлийн шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо, Улсын дээд шүүхийн шүүгч, аймаг, нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгчид үүсгэсэн сахилгын хэргийг Улсын дээд шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо тус тус хянан шийдвэрлэнэ.

Шүүгчийн сахилгын хорооны даргад хорооны гишүүд дотроосоо нэр дэвшүүлж хуралдаанаар хэлэлцэн саналыг илээр хурааж хорооны нийт гишүүний олонхын санал авсан хүнийг сонгоно.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1-т шүүгч хууль, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь давж заалдах болон хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад илэрсэн, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 2-т шүүгч хууль, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэлтэй гэж үзсэн бол шүүгчид сахилгын хэрэг үүсгэнэ гэж заасан.

Энэ нь шүүгчийн эсрэг гомдол гаргах эрхтэй албан тушаалтныг хязгаарлаж, зөвхөн давж заалдах болон хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцаар тогтоосон байна.



Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1-т зааснаар Улсын дээд шүүхийн хуралдаан, давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч нь Монгол Улсын бүх шүүгчдэд, аймаг, нийслэлийн шүүхийн давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нь тухайн аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдэд, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нь тухайн шүүхийн шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх эрхтэй байв.

Хэдийгээр шүүгчид сахилгын хэрэг үүсгэх харьяаллыг нарийвчлан тогтоосон шинжтэй боловч энэ нь шүүхэд босоо тогтолцоо, удирдлагын шинжийг хадгалсан байна. Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу шүүх эрх мэдлийг шүүх, шүүгчид хэрэгжүүлэх бөгөөд давж заалдах, хяналтын шатны шүүхийн тогтолцоо нь шүүхийн удирдлагатай хамааралгүй юм.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3-т зааснаар сахилгын шийтгэл ногдуулсан Шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг шүүгч эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно. Мөн зүйлийн 4-т зааснаар Улсын дээд шүүх гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор түүнийг хянан шийдвэрлэнэ.

Улсын дээд шүүх Шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг хянан хэлэлцээд түүнийг хэвээр үлдээх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгож сахилгын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх буюу хэргийг

хэрэгсэхгүй болгон шүүгчийг цагаатгах шийдвэрийн аль нэгийг гаргана. Энэ үед анхан болон давж заалдах шатны шүүхээс Шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг хянахгүй байх, зөвхөн Дээд шүүхээр эцэслэн хянуулах онцлогтой байжээ.

VII. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх үе (2002–2013 он)

Ардчилсан дэглэмтэй дэлхийн аль ч улсад шүүгчийн эрхэм үүрэг нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, шүүн таслах ажиллагааг шударгаар хэрэгжүүлэх, шүүгчийн ёс зүйн өндөр стандартыг чанд баримтлах явдал юм.

Энэ үүднээс эрх зүйн бүл, тогтолцооны ялгаанаас үл хамааран олон орны шүүгчдийн идэвхтэй оролцоо, хүчин чармайлт, мөн НҮБ-ын дэмжлэгээр Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудыг 2002 онд боловсруулж, олон нийтийн хүртээл болгосон билээ.

Энэ үйл явц 2001 оноос эхэлсэн бөгөөд түүнд “Шүүгчийн ёс зүйн аливаа дүрэм, шүүхийн бие даасан байдлын талаарх зарчмуудыг шүүх өөрөө боловсруулах ёстой. Энэ нь шүүхийн бие даасан байдал болон эрх мэдэл хуваарилах зарчимд нийцнэ.” гэж онцлон тэмдэглэсэн байна. Монгол Улсын хувьд энэ зарчмыг шинэчлэн баталсан Шүүхийн тухай хуульд тусгаж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чиглэжээ.

Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдөр баталж, 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилсэн Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Шүүгчийн



ёс зүйн дүрмийг Шүүгчдийн зөвлөл батална” гэж заасан.²¹

Шүүхийн тухай хуулийн 67 дугаар зүйлд Шүүгчдийн зөвлөл нь Улсын дээд шүүхийн шүүгч, аймаг, нийслэл, дагнасан шүүхийн Ерөнхий шүүгчдээс бүрдэх бөгөөд жил тутам хуралдана. Шүүгчдийн зөвлөл нь шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг, Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг тус тус сонгох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ.

Ийнхүү хууль хүчин төгөлдөр болж, Шүүгчдийн зөвлөлөөс ёс зүйн дүрэм батлах хүртэлх зурвас хугацаанд ямар ёс зүйн дүрмийг баримтлах вэ гэдгийг тухайн үед Шүүгчдийн зөвлөл шийдвэрлэсэн байна.

Тодруулбал, Шүүгчдийн зөвлөлийн 2002 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн “Шүүгчийн ёс зүйн дүрмийг мөрдөх тухай” 08 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2002 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг үргэлжлүүлэн мөрдөхөөр тогтжээ. Мөн шүүгчийн ёс зүйн дүрмийг Шүүхийн тухай хуультай нийцүүлэх талаар санал боловсруулан Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Шүүхийн сахилгын хорооны гишүүдэд даалгасан байна.

Үүний дагуу Шүүгчдийн зөвлөлийн 2003 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн

“Шүүгчийн ёс зүйн дүрэм батлах тухай” 01 дүгээр тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг баталжээ.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд “Шүүгчийн биеэ авч явах ёс зүй”, “Шүүгчийн мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага”, “Шүүгчийн шүүн таслах ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага”-г тусгажээ. Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл

- тухайн шүүхийн шүүгчдийн өмнө сануулах;
- шүүгчийн зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах;
- шүүгчээс огцруулах санал гаргахаар заасан.

Шүүгчдийн зөвлөлийн 2010 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан байна.

Энэхүү Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм нийт 17 зүйлтэй бөгөөд түүнд “Мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага”, “Шүүгчийн бусад үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага”-ыг тусгажээ. Үүнийг зөрчвөл

- тухайн шүүхийн шүүгчдийн өмнө сануулах;
- шүүгчийн зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах;
- шүүгчээс огцруулах санал гаргахаар заасан.

²¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №29.




Монгол Улсын Шүүхийн сахилгын хороо

Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд “Шүүхийн сахилгын хороо”-ны талаар заасан. Тодруулбал, тус зүйлийн 46.1-46.6-д зааснаар, Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороо нь улсын хэмжээнд нэг байна. Шүүхийн сахилгын хороо 15 гишүүнтэй байна.

Шүүхийн сахилгын хорооны гишүүнд Улсын ерөнхий прокурор, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөлөөс тус бүр хоёр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн хуралдаанаас тав, Шүүгчдийн зөвлөл бүх шатны шүүхээс тус бүр хоёр хүний нэрийг дэвшүүлнэ. Шүүхийн сахилгын хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална. Шүүхийн сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна. Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

Бүдүүвч 5:



Үүний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 191 дүгээр зарлигийн хавсралтаар “Шүүхийн сахилгын хорооны дүрэм”-ийг баталсан бөгөөд энэ зарлиг гарсантай холбогдуулан “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн сахилгын хорооны дүрэм” батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 07 дугаар

зарлигийг хүчингүй болсонд тооцсон байдаг.

Үүнээс хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 192 дугаар зарлигийн хавсралтаар “Шүүхийн сахилгын хорооны дүрэм”-ийг баталсан бөгөөд энэ зарлиг гарсантай холбогдуулан “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 191 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсон.²²

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 176 дугаар зарлигийн хавсралтаар “Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн”-ийг баталж, 2002 оны 176 дугаар зарлигаар Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилжээ.

Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим онцлог зохицуулалт

Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд гомдол, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч хүсэлт гаргах эрхтэй” гэж заасан. Үүний дагуу шүүх өөрөө шүүгчийнхээ ёс зүйн зөрчлийг хүсэлт гарган шийдүүлэх боломжтой болжээ. Тус хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т зааснаар сахилгын хэргийг Сахилгын хорооны гишүүн үүсгэнэ.

Шүүхийн тухай хуулийн 55 дугаар зүйлд зааснаар Шүүхийн сахилгын хороо анхан шатны журмаар хянан шийдвэрлэх болон давж заалдах гомдлоор сахилгын

²² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 он, №34.



хэргийг хянан хэлэлцэж шийдвэрлэх зохицуулалттай байв. Мөн зүйлийн 55.4-т зааснаар давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Шүүхийн сахилгын хорооны магадлал эцсийнх байхаар хуульчилснаар сахилгын хэргийг шүүх хянах боломжгүй байжээ.

Шүүхийн тухай хуульд заасан Шүүхийн сахилгын хорооноос сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах хэм хэмжээг Улсын Дээд шүүхээс тайлбарлаж байжээ. Тодруулбал, Улсын дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 01 дүгээр тогтоолын 22-т “Хуулийн 48.1.2-т заасан ‘... шалгах ажиллагааг ...’ Сахилгын хорооны гишүүд болон мөн хорооны ажлын албаны ажилтнууд явуулах бөгөөд шалгах ажиллагаа нь шүүгч, гомдол, хүсэлт гаргагч, тухайн асуудлын талаар мэдэх этгээдээс тайлбар авах, шүүгчийн ажил байдлын тодорхойлолтыг гаргуулж, шүүн таслах ажилтай нь танилцах, шаардлагатай бол тодорхой асуудлаар шинжээч томилуулж дүгнэлт гаргуулах зэргээр явагдана.

Харин шүүгч, гомдол, хүсэлт гаргагч, тухайн асуудлыг мэдэх этгээдээс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмаар хууль сануулж мэдүүлэг авах, нүүрэлдүүлэн байцаах зэргээр мөрдөх ажиллагаа явуулж болохгүй.”, 23-т “... Мөн заалтын дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэх тухай бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн хүсэлт, иргэдийн гомдлыг энэ хуулийн 54.2-т заасан хугацаанд Сахилгын хороонд холбогдох материалын хамт бичгээр ирүүлнэ.”, 24-т “Хуулийн 53.1.1-д заасан сахилгын

шийтгэлийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байгаа тохиолдолд оногдуулна.”, 25-д “Хуулийн 54.2-т заасан ‘Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар...өнгөрсөн ...’ гэдэгт тухайн шүүгчид холбогдуулан гомдол, хүсэлт гаргаснаас хойш, уг хэргийг Сахилгын хорооны анхан шатны хуралдаанаар хэлэлцэх хүртэл, шүүгчид холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш тус тус зургаан сарын хугацаа өнгөрсөн байхыг хамааруулж ойлгоно.

Мөн заалтын ‘...зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн...’ гэдгийг шүүгч энэ хуулийн 34.3, 44-т заасан хориглосон ажил, албан тушаал эрхэлсэн, үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөнөөс хойш нэг жилийн дотор уг зөрчил илрээгүй буюу шүүгчид сахилгын хэрэг үүсгээгүй, зөрчил мэдэгдээгүй өнгөрсөн байхыг ойлгоно.”, 26-д “Хуулийн 56.1-д заасан ‘Шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй...’, 59.1.2-т заасан ‘сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн’ гэдэг нь хугацааны хувьд нэг ойлголт бөгөөд шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш хуанлийн нэг жил бүтэн өнгөрснийг хэлнэ.

Харин мөн хуулийн 59.1.1-д заасан ‘шүүгчээс огцруулах тухай Сахилгын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон’ гэдгийг Сахилгын хорооны тогтоолыг сахилгын хэрэгт холбогдсон шүүгч давж заалдаагүй бол уг тогтоол гарсан өдрөөс,



хэрэв уг тогтоолд давж заалдах гомдол гаргасан бол хэрэг Сахилгын хорооны бүх гишүүдийн хурлаар хэлэлцэгдэж, тогтоол хэвээр батлагдсан өдрөөс, тогтоолд өөрчлөлт орсон бол магадлал гарсан өдрөөс хүчин төгөлдөр болно гэж тус тус ойлгоно” гэж тайлбарлажээ.

Үүнээс гадна Улсын дээд шүүхийн 2003 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Шүүхийн тухай зүйлийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг тайлбарлах тухай” 30 дугаар тогтоолд Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан “Сахилгын хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх үндэслэлтэй эсэхийг хянаж сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана” гэж заасан хугацааг Сахилгын хорооны гишүүн, ажлын албаны ажилтан болон албан тушаалтан, иргэдээс нэг мөр ойлгохгүй байгаагаас шалгах ажиллагаа явуулах хугацаа хэтэрсэн тохиолдолд шүүгчид сахилгын хэрэг үүсгэхгүйгээр татгалзах, нэгэнт үүсгэсэн сахилгын хэргийг зөвхөн энэ хугацаа хэтэрсэн гэдгээр хэрэгсэхгүй болгох тохиолдол нэг биш удаа гарч хуулийн заалтыг нэг мөр, зөв хэрэглэхгүй байна гэж тэмдэглэсэн байна.

Тус тогтоолд Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан 30 хоног гэснийг “Сахилгын хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авч, шалгах эрх бүхий албан тушаалтанд шалгуулахаар заалт өгсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухай шүүгчийн талаар гаргасан гомдол, хүсэлт үндэслэлтэй эсэхийг шалгаж зохих шийдвэр гаргах хугацаа” гэж ойлгох бөгөөд Шүүхийн тухай

хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан 30 хоногийн энэ хугацааг хэтрүүлсэн нь шүүгчид холбогдох сахилгын хэргийг үүсгэх буюу үүсгэхээс татгалзах, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болохгүй гэж тайлбарлажээ.

VIII. Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг эрчимжүүлэх үе (2013-2021 он)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол Улсын Засгийн газар, Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганыг 2011 оны 4 дүгээр сарын 14-15-нд зохион байгуулсан. Үндэсний чуулганы зорилго нь шүүх эрх мэдлийн салбарт тулгарч буй асуудал, түүний гарц шийдэл, шаардлагатай хууль тогтоомжийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хамтдаа олонхоороо тодорхойлох явдал байлаа. Энэхүү үндэсний чуулганд нийт 1600 гаруй төлөөлөгч оролцжээ.

Энэхүү чуулганы салбар хуралдаан эхлэхээс өмнө Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, профессор Б.Чимид нарын боловсруулсан шүүхийн тухай багц хуулийн төслийг урьдчилан бүх оролцогчдод хүргүүлжээ. Тус үндэсний чуулганаас “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Шүүхийн тухай багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, нэн даруй батлуулах” зөвлөмж гаргажээ.²³

²³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар,



Дээрх зөвлөмжийг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан Улсын Их Хурлаас 2012 онд баталсан шүүхийн багц хууль 2013 оноос мөрдөгдөж эхэлсэн. Шинээр мөрдөгдсөн шүүхийн багц хууль дотор Монгол Улсын шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиуд багтсан.

Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Шүүхийн тухай багц хуулийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан зохион байгуулалтын чиглэлийг заажээ. Энэ нь Монгол Улсад шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх эрх зүйн үндэс болжээ.

Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталж, 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2-т Хуульчдын холбооны шүүгчдийн хороо шүүгчийн ёс зүйн дүрмийг батлахаар заасан.²⁴

Үүний дагуу Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Санал хураалтын дүнг баталгаажуулж, Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах тухай” 1/08 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг баталжээ.

Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс, Үндэсний чуулганы зөвлөмжийн эмхэтгэл, 2011, 37-48 дахь тал.

24 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012, №11.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд “Нийгмийн харилцаанд шүүгчийн баримтлах ёс зүй”, “Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй”, “Нийтийн алба болон хувийн амьдралд шүүгчийн баримтлах ёс зүй”-г тусгасан. Эдгээрийг зөрчвөл

- сануулах;
- зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах;
- огцруулахаар заасан.

Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо

Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлд Шүүхийн ёс зүйн хорооны талаар зохицуулсан. Тодруулбал, тус хуулийн 32.1-32.6-д зааснаар шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн ёс зүйн хороо нь улсын хэмжээнд нэг байна.

Шүүхийн ёс зүйн хороо нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос гурав, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүний нэрийг дэвшүүлнэ.


Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.

Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх



бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно. Шүүхийн ёс зүйн хорооны даргыг хорооны гишүүдийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.

Бүдүүвч 6:



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор “Шүүгчдийн зөвлөгөөнөөс Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, санал болгох журам” баталсан. Энэ журмаар Шүүгчдийн зөвлөгөөнөөс нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдийн нэгдсэн жагсаалт гаргах, санал хураалт явуулах, дүн нэгтгэх, санал болгох харилцааг зохицуулсан. Тус журмыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагатай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 133 дугаар тогтоолоор тус журмыг хуульд нийцсэн гэж дүгнэжээ.²⁵

Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтаар “Шүүхийн мэргэшлийн болон Ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, санал болгох журам” баталсан. Энэ журамд Шүүхийн ёс зүйн хороонд Хуульчдын холбооноос нэр дэвшүүлэх ажиллагааг

зохион байгуулах, нэр дэвших өргөдлийг шийдвэрлэх, үе шаттайгаар хянан үзэх, нэр дэвшигчийг санал болгох харилцааг нарийвчлан зохицуулсан. Үүнээс өмнө энэ харилцааг Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 60.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх тухай” 14 дүгээр тогтоолоор зохицуулж байв.

Гэвч Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийг нэр дэвшүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгох байгууллагуудын дотоод зохион байгуулалтын харилцан адилгүй байдал болон санал болгосон нэр дэвшигчдийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилохгүй байх, буцаах зэргээс хамааран Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийг нэгэн зэрэг томилох боломжгүй байжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн төслийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр тогтжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигийн хавсралтаар Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийг баталсан бөгөөд үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 192 дугаар зарлигаар батлагдсан Шүүхийн сахилгын хорооны дүрмийг хүчингүй болсонд тооцсон.²⁶

Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим онцлог зохицуулалт

²⁵ Улсын дээд шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 133 тогтоол https://shuukh.mn/single_case/2288?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1

²⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №40.



Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргана” гэж заасан. Ингэснээр Шүүхийн тухай 2002 оны хуульд заасан бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн зүгээс шүүгчийн ёс зүйн асуудлыг шийдүүлэх хүсэлт гаргах зохицуулалтыг халав.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т “Ёс зүйн хорооны шийдвэрийг хэргийн оролцогчид эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлд гомдол гаргана” гэж заажээ.

Энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө буюу “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар “35.2.Энэ хуулийн 35.1-д заасан магадлалыг маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна” гэж нэмсэн байна.

Гэхдээ “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хассан. Ингэснээр 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Шүүхийн ёс зүйн хорооны шийдвэрийг Дээд шүүх хянах болжээ.

IX. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн үе (2021-)

Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаанд оролцсон 64 гишүүний 100 хувийн саналаар баталсан ба Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд нэмсэн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн үндэс

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана” гэж заажээ.

Үүний дагуу Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн тухай / Шинэчилсэн найруулга/ хуулийг 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 3 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилсэн байна.




Ийнхүү 2021 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 95 дугаар зүйлд Монгол Улсын Шүүхийн сахилгын хорооны талаар зохицуулсан. Тодруулбал, энэ хуулийн 95.1-95.4, 95.8, 98.9-д зааснаар энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

Монгол Улсын шүүхийн тухай / Шинэчилсэн найруулга/ хуульд заасны дагуу Шүүхийн сахилгын хороо орон тооны есөн гишүүнээс бүрдэнэ. Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.

Бүдүүвч 7:



Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн нь шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна. Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан иргэн орохыг хориглоно.

Шүүхийн сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд зөвхөн нэг удаа сонгогдож, томилогдоно. Шүүхийн сахилгын хорооны гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

Монгол Улсын Нийт шүүгчийн анхдугаар чуулган Төрийн ордонд 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр эхэлж, анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн 421 шүүгч биечлэн, 58 шүүгч цахимаар оролцсон байна.

Чуулганаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн



сахилгын хорооны шүүгч гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж, нийт шүүгчийн дунд явуулсан нууц санал хураалтаар олонхын санал авсан Улсын дээд шүүхийн шүүгч Готовдоржийн Цагаанцоож, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Очирбатын Номуулин, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Сономдовчингийн Энхтөр, Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Баясахын Сугар нарыг Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнээр сонгогдсонд тооцож, Нийт шүүгчийн чуулганы 2021 оны 10 дугаар сарын 11-ний 04 дүгээр тогтоолыг баталжээ.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтын томилгооны сонгол хийж, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд 24 хүн нэрээ дэвшүүлснээс сонгон шалгаруулалтын явцад нэг хүн нэрээ татаж, 23 хүн сонгон шалгаруулалтад оролцсоноос олонхын санал авсан 5 нэр дэвшигч оролцсон байна.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2021 оны 11 дүгээр сарын 18-ны үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэж, нэр дэвшигч Ц.Давхарбаярыг хуралдаанд оролцсон гишүүдийн 88.4, нэр дэвшигч Д.Мягмарцэрэнг 86.0, нэр дэвшигч Х.Хашбаатарыг 84.1, нэр дэвшигч Д.Ариунтуяаг 79.1, нэр дэвшигч Д.Эрдэнэчулууныг 76.7 хувь нь тус тус дэмжсэн тул “Шүүхийн сахилгын хорооны

шүүгч бус гишүүнийг томилох тухай” тогтоолын төслийг баталж²⁷, Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг томилжээ.²⁸

Шүүгчийн сахилгын асуудлыг зохицуулсан байдал

Монгол Улсын шүүхийн тухай / Шинэчилсэн найруулга/ хуульд шүүгчид хориглох зүйл, шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг, шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалтыг заасан бөгөөд тэдгээрийг зөрчвөл хаалттай сануулах, нээлттэй сануулах, цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, огцруулахаар заасан. Энэ хуулиар шүүгчийн ёс зүйн асуудлыг дүрмээр тогтоохгүй болов.²⁹

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2-т зааснаар Шүүхийн сахилгын хорооны илтгэгч гишүүн өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай захирамж гаргана.

Мөн хуулийн 112 дугаар зүйлийн 112.8, 114 дүгээр зүйлийн 114.1, 115 дугаар зүйлийн 115.1-т заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт давж заалдах гомдлыг хороонд өөрт

²⁷ “Чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг томиллоо” Монгол Улсын Их Хурлын цахим хуудас, <https://www.parliament.mn/nn/15934/> (Сүүлд үзсэн: 2024.03.13)

²⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №46.

²⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №05.



нь, хяналтын гомдлыг Дээд шүүхэд гаргах, Дээд шүүхээс Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг зөвхөн сахилгын хэргийн оролцогчийн эрхийг эдлүүлсэн эсэхтэй холбоотой хянахаар зохицуулсан болохыг харуулж байна. Ингэснээр Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийн агуулгыг шүүх хянахгүй болжээ.

X. Дүгнэлтийн оронд

Эрт дээр үеэс шүүгчийн сахилга бат, хариуцлагын асуудлыг чухалчлан авч үзэж байсан болох нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, БНМАУ-ын Дээд шүүхийн Тэргүүлэгчдийн хурал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, Шүүгчдийн зөвлөл болон Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн тогтоол зэрэг эрхийн актуудаар батлагдан мөрдөгдөж байсан шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, дүрмүүд, мөн шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сахиулах, хариуцлага тооцох чиг үүрэг бүхий байгууллагууд тухайн цаг үе бүртээ байгуулж хариуцлагын тогтолцоог бий болгож байсан зэргээс тодорхой харж болохоор байна.

Шүүгчийн хараат бус байдал болон шүүгчийн хариуцлага нь нэг зүйлийн хоёр тал учир тэдгээрийн тэнцвэрийг олж байх асуудал нь хурцаар тавигддаг. Шүүгчид хариуцлагатай, үнэнч шударга, мэргэшсэн чадварлаг байж олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг хадгалж хамгаалж явах ёстой.

Монголын ард түмний туйлын хүсэл нь шүүгч тэгш, шударга, зарчимч, чадварлаг, хариуцлагатай ажилладаг байх ёстой гэсэн итгэл сэтгэл байдаг болно.

Энэ том үүрэг хариуцлагыг тээж явдаг шүүгчид хариуцлагатай ажиллахад, шүүхэд итгэх ард олны итгэлийг хадгалах, хамгаалах үйл хэрэгт үе үеийн шүүхийн сахилга хариуцлагын байгууллагууд анхаарч ажилласаар ирсэн түүхэн уламжлалтай.

Монгол төрийн эрх мэдлийн нэгэн салаа болсон шүүх эрх мэдлийн цэвэр тунгалаг байдлыг хариуцан ажиллах чиг үүргийг хүлээсэн эл байгууллагын түүхэн хөгжлийг судалж маш товч байдлаар харуулан бичихийг хичээн эрмэлзэв.

XI. Ном зүй

Монгол эх сурвалж

1. А.Түвшинтулга, "Ардын хувьсгал ялж Монголын тусгаар тогтнолыг бататгасан үеийн шүүхийн тогтолцоо."
2. БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхгууд, 1956.
3. Б.Сугар, *Шүүгчийн ёс зүйн дүрмүүд* эмхэтгэл, 2021.
4. Ерөнхий редактор Б.Чимид, *Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл* 4 дүгээр боть, 2010.
5. Ерөнхий редактор Б.Чимид, *Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл* 2 дугаар боть, 2010.
6. Монгол Улсын дээд шүүх, "Монголын шүүх I" хууль тогтоомжийн эмхэтгэл, хоёрдугаар хэсэг (1960-1991), 2017.
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, *Шүүх эрх мэдлийн*



шинэчлэл ба шударга ёс, Үндэсний чуулганы зөвлөмжийн эмхэтгэл, 2011.

8. С.Бадарчи, “Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн (Богд хаант Монгол Улсын) шүүх.”
9. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын дээд шүүх, “Монгол Улсын шүүхийн товчоон.”

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Шүүхийн тухай хууль
2. Монгол Улсын шүүхийн тухай / Шинэчилсэн найруулга/ хууль
3. Монгол Улсын Үндсэн хууль
4. Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хорооны дүрэм

5. Шүүхийн сахилгын хорооны дүрэм
6. Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм
7. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

Цахим эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992), <https://www.parliament.mn/nn/13466/>
2. “Чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг томиллоо” Монгол Улсын Их Хурлын цахим хуудас, <https://www.parliament.mn/nn/15934/>



Хавсралт 1:

Шүүгчийн ёс зүй, сахилгын хэм хэмжээний харьцуулалт

Эх сурвалж	Зохицуулалт	Хүлээлгэх хариуцлага
1954 оны “Шүүгчдийн сахилга батын хариуцлагын тухай дүрэм”	Сахилга батын хариуцлагад татах: <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн сахилга батыг гажуудуулсан хэрэгт - Шүүхийн ардчилсан зарчмыг зөрчсөн, удирдлагын тушаал, даалгаврыг шуурхай биелүүлээгүй буюу шүүгчийн нямбай биш ажиллагаа хийгээд сахилга батгүй явдлын улмаас шүүх таслах ажилд гарсан дутагдлын хэрэгт - Шүүгчийн алдар хүндэд зохимжгүй явдлуудыг үйлдсэн хэрэгт. 	<ul style="list-style-type: none"> - Сануулах; - Донгодох; - Хатуу донгодох; - Огцруулах асуудлыг тавих.
1970 оны “БНМАУ-ын Шүүгч нарын сахилга батын хариуцлагын тухай дүрэм”	Шүүгчдэд сахилга батын хариуцлага хүлээлгэх үндэс <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн сахилга бат гажуудуулах, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандах, албан үүргийн эндэгдэл гаргах, удирдлагын үүрэг даалгавар үл биелүүлэх буюу ёс төдий хандах - Шүүхийн ардчилал зөрчих, эрүү, иргэний болон байцаан шийтгэх хуулийг зөрчиж социалист хууль ёс гажуудуулах - Албан байгууллага хөдөлмөрчдийн өргөдөл гомдолд шуурхай бус хандаж чирэгдүүлэх - Шүүхийн байгууллага, шүүгчийн нэр хүндэд харшлах үлгэргүй байдал гаргах. 	<ul style="list-style-type: none"> - Сануулах; - Донгодох; - Хатуу донгодох; - Албан тушаалаас нь 6 сар хүртэл хугацаагаар огцруулж дорд тушаалын ажилд шилжүүлэх санал тавих; - Шүүгчийн гаргасан зөрчил нь түүнийг цаашид шүүгчээр ажиллуулах боломжгүйд хүргэсэн бол ажлаас халах санал тавих.
1997 оны “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”	<ul style="list-style-type: none"> - Шүүгчийн ёс зүйн үндсэн зарчим - Шүүгчийн биеэ авч явах ёс зүй - Улс төрийн хүрээн дэх ёс зүй - Санхүүгийн үйл ажиллагааны хүрээн дэх ёс зүй 	<ul style="list-style-type: none"> - Сануулах; - Шүүгчдийн өмнө буруушаан зэмлэх; - Шүүгчийн албан тушаалын цалинг 3-6 сарын хугацаагаар 20 хүртэл хувиар хасах; - Шүүгчээс огцруулах.
2003 оны “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”	<ul style="list-style-type: none"> - Шүүгчийн биеэ авч явах ёс зүй - Шүүгчийн мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага - Шүүгчийн шүүн таслах ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага 	<ul style="list-style-type: none"> - Тухайн шүүхийн шүүгчдийн өмнө сануулах; - Шүүгчийн зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах; - Шүүгчээс огцруулах санал гаргах.
2010 оны “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага - Шүүгчийн бусад үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага 	<ul style="list-style-type: none"> - Шүүгчээс огцруулах санал гаргах.



<p>2014 оны “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”</p>	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн харилцаанд шүүгчийн баримтлах ёс зүй - Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй - Нийтийн алба болон хувийн амьдралд шүүгчийн баримтлах ёс зүй 	<ul style="list-style-type: none"> - Сануулах; - Зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах; - Огцруулах.
<p>2021 оны Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль</p>	<ul style="list-style-type: none"> - Шүүгчид хориглох зүйл - Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт - Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг - Шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт 	<ul style="list-style-type: none"> - Хаалттай сануулах; - Нээлттэй сануулах; - Цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах; - Шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах; - Огцруулах.



Шүүгчийн тангараг (1984–2021)

Эрх зүйн эх сурвалж	Шүүгчийн тангаргийн үг	Шүүгчийн тангаргийг өргөх
<p>БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн “БНМАУ-ын Ардын шүүгчийн тангараг батлах тухай” 205 дугаар зарлиг</p>	<p>БНМАУ-ын Ардын шүүгчийн тангараг</p> <p>БНМАУ-ын иргэн би БНМАУ-ын Үндсэн хуульд заасан ёсоор ардын шүүгчийн албан тушаалд сонгогдон тангараг өргөхдөө эх орон, нам, ард түмнээс надад хүлээлгэсэн өндөр итгэл, хариуцлагатай даалгаврыг бүрэн ухамсарлаж, ардын төрийн шүүн таслах үйл ажиллагааг МАХН-ын бодлого, БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу үнэнч шударгаар явуулахын төлөө цуцалтгүй тэмцэж ажиллахаа батлан илэрхийлж байна.</p> <p>Ардын шүүгч би БНМАУ-ын нэрийн өмнөөс хэргийг шүүн таслахдаа хэний ч нөлөөнд үл автан гагцхүү хуульд захирагдаж, улсын нууцыг чанд сахиж, БНМАУ-ын нийгэм, төрийн байгууламж, социалист өмч, ард иргэд, улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж ажиллахаа батлан тангараглая.</p> <p>Ардын шүүгч би хууль ёс зөрчих явдалтай шийдвэртэй тэмцэж, социалист сахилга, хуульчийн ёс суртахууны хэм хэмжээг үлгэр жишээчээр сахин биелүүлж, нийгмийн үйл ажиллагаа, хувийн амьдралдаа ардын шүүгчийн ариун нэр төрийг ямагт өндөр өргөж явахаа батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаа няцвал төрийн хуулийн хатуу цээрлэл хүлээнэ.</p>	<p>Ардын шүүгчийн тангаргийг аймаг, хот, тусгай шүүх болон БНМАУ-ын Дээд шүүхэд хамтран өргөнө.</p>
<p>БНМАУ-ын Бага хурлын 1991 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “БНМАУ-ын Шүүгчийн тангараг батлах тухай” 13 дугаар тогтоол</p>	<p>БНМАУ-ын Шүүгчийн тангараг</p> <p>Шүүгч би гагцхүү БНМАУ-ын хуулийг эрхэмлэн дээдэлж, хэний ч нөлөөнд үл автан ажиллаж, шүүгчийн ариун нэр төрийг өндөрт өргөж явахаа батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал төрийн хуулийн хатуу цээрлэл хүлээнэ.</p>	<p>Шүүгчийн тангаргийг БНМАУ-ын Дээд шүүхийн бүрэлдэхүүн БНМАУ-ын Бага хуралд, тусгай шүүхийн гишүүд БНМАУ-ын Дээд шүүхэд, бусад шүүгчид аймаг, хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдэд өргөнө.</p>



<p>Монгол Улсын Шүүхийн тухай 1993 оны хуулийн 9 дүгээр зүйл</p>	<p>Шүүгчийн тангараг</p> <p>Шүүгч би аливаа хэрэг, маргааныг зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсыг чанд сахиж явахаа батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуульд заасан хариуцлага хүлээнэ.</p>	<p>Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p>
<p>Шүүхийн тухай 2002 оны хуулийн 43 дугаар зүйл</p>	<p>Шүүгчийн тангараг</p> <p>Шүүгч би аливаа хэрэг, маргааныг зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсыг чанд сахиж явахаа батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуульд заасан хариуцлага хүлээнэ.</p>	<p>Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p>
<p>Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012 оны хуулийн 16 дугаар зүйл</p>	<p>Шүүгчийн тангараг</p> <p>Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульд байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ.</p>	<p>Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p>
<p>Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ 2021 оны хуулийн 38 дугаар зүйл</p>	<p>Шүүгчийн тангараг</p> <p>Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульд байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая.</p> <p>Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч, хуульд заасан хариуцлага хүлээнэ.</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн сүлдэнд тангараг өргөнө.</p>



Abstract

HISTORICAL DEVELOPMENT OF THE JUDICIAL DISCIPLINARY COMMITTEE OF MONGOLIA

B.SUGAR

Judge member of the Judicial Disciplinary Committee

The article summarizes the history dating back to the Bogd Khanate of Mongolia and the amendment to Article 49.6 of the Constitution of Mongolia on November 14, 2019. The ethics and disciplinary proceedings of judges were first established by a special rule in 1954, and the rule was revised in 1970, and the tradition has been continued. The paper aims to cover the historical process in which the main changes in the development of the judicial system in the legal framework of the new democratic Constitution of Mongolia, divided into the eras of the

Bogd Khanate of Mongolia (1911-1921), the independence of Mongolia after the victory of the People's Revolution (1921-1940), the primary stage of socialism in Mongolian People's Republic (1940-1960), the rise of the socialism in the Mongolian People's Republic (1960-1990), 1993-2002, 2002-2013, 2013-2021, and the present.

Keywords

Court, judge, judge's ethics, judge's discipline, judge's accountability, Judicial Disciplinary Committee, court and judge's accountability system

**УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН
ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ
УЛСЫН ТУРШЛАГА: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**Улсын дээд шүүхийн дэргэдэх
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн¹**

¹ Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Ph.D) Д.Эрдэнэчимэг удирдаж захиргааны эрх зүйн секторын эрхлэгч С.Цэрэндолгор, захиргааны эрх зүйн судлаач О.Тэнхлүүн, Н.Хулан, М.Отгондэлгэр, Үндсэн хууль, олон улсын эрх зүйн секторын судлаач С.Жансая нар хийж гүйцэтгэсэн болно.

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	79
УДИРТГАЛ	80
Судалгааны зорилго:	80
Судалгааны хамрах хүрээ:	80
Судалгааны арга зүй:	80
Судалгааны бүтэц:	80
ҮНДСЭН ХЭСЭГ	80
НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	81
1.1. Болгар Улс	84
1.2. Бүгд Найрамдах Чех Улс (Чех)	85
1.3. Эстони Улс	86
1.4. Испани Улс	86
1.5. Кипр Улс	87
1.6. Латви Улс	87
1.7. Литва Улс	88
1.8. Австри Улс	89
1.9. Польш Улс	89
1.10. Португал Улс	90
1.11. Румын Улс	91
1.12. Словени Улс	91
1.13. Словак Улс	92
1.14. Финланд Улс	93
1.15. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)	93
1.16. Бүгд Найрамдах Ангол Улс (БНАУ)	95
1.17. Оросын Холбооны Улс (ОХУ)	96
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	97
ХОЁР. УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	98
БҮЛГИЙН ДҮГНЭЛТ	106
ДҮГНЭЛТ	106
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	107



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНАУ	Бүгд Найрамдах Ангол Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
УДШ	Улсын дээд шүүх
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс



УДИРТГАЛ

Судалгааны зорилго:

Тус судалгааны зорилго нь улс төрийн намын бүртгэлийг гадаад улсад дээд шүүх эсхүл өөр байгууллага хөтөлдөг эсэх, нам байгуулах зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон холбогдох хууль тогтоомжийн талаар Монгол Улстай харьцуулсан судалгаа гүйцэтгэхэд оршино.

Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү судалгаа нь гадаадын болон дотоодын харьцуулсан судалгаанаас бүрдэх бөгөөд эхний хэсэгт Европын холбоо (цаашид "ЕХ" гэх)-ны гишүүн улсууд (тухайлан Монгол Улстай адил "пост-социалист" улсууд) болон эрх зүйн өндөр хөгжилтэйд тооцогддог нийт 17 улсын зохицуулалтыг нэг бүрчлэн судаллаа.

Харин удаах хэсэгт улс төрийн намын бүртгэл хөтлөх талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, түүхэн хөгжил, сүүлийн 6 жилийн (2016-2022 он) дотор улс төрийн намын бүртгэл хөтлөхтэй холбогдох асуудлаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр зэрэгт дүн шинжилгээ хийв.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичигт шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

Судалгааны бүтэц:

Энэхүү судалгаа нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт, санал, Хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Дэлхийн улсуудад улс төрийн намын эрх зүйн үндэс, түүнтэй холбоотой бусад харилцааг "Улс төрийн намын тухай хууль" (англ. *Party Law*), "Сонгуулийн тухай хууль" (англ. *Electoral Law*)-уудаар¹ зохицуулдаг.

Улс төрийн намыг бүртгүүлэх, бүртгэх харилцааг тухайлсан хуулиар зохицуулдаг эсэхээс бүртгэл хөтлөх чиг үүргийг тодорхой этгээд хариуцан гүйцэтгэдэг эсэх нь шууд хамаарахаар байгаа нь судалгааны явцад харагдлаа. Тодруулбал, (1) улс төрийн намын эрх зүйн байдлын талаарх тухайлсан хуульгүй улсын хувьд сонгуулийн болон бусад хуулиар нам байгуулахад тодорхой шалгуур заагаагүй, энэ утгаараа аливаа байдлаар бүртгүүлэх шаардлагагүй, гагцхүү сонгуульд нэр дэвших тохиолдолд Сонгуулийн төв байгууллагад бүртгүүлэх; (2) улс төрийн намын эрх зүйн байдлыг зохицуулсан тухайлсан буюу "Улс төрийн намын тухай хууль"-тай улсын хувьд улс төрийн намыг тодорхой эрх бүхий байгууллагад бүртгүүлдэг гэж ерөнхийд нь хоёр хувааж болохоор байна.

Үүнээс хоёр дахь төрөл буюу Улс төрийн намын тухай хуультай улсад улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага нь улс бүрд өөр байх

¹ Тухайлбал, ЕХ-ны гишүүн 27 улсын улс төрийн нам бүртгүүлэх зохицуулалтыг харьцуулан судалсан тайланд "Улс төрийн намын тухай хууль" гэх тухайлсан хууль тогтоомжгүй улсын зохицуулалтад дүн шинжилгээ хийхдээ хамгийн сүүлд батлагдсан "Сонгуулийн тухай хууль"-ийг хамруулан авч үзжээ.

European Parliament, Criteria, Conditions, and Procedures for Establishing a Political Party in the Member States of the European Union (European Union: 2012), p.19,

[https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET\(2012\)462512_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET(2012)462512_EN.pdf).



бөгөөд дараах хоёр төрлийн байгууллага бүртгэж байна:

- Шүүх эрх мэдлийн байгууллага (Ихэвчлэн анхан шатны шүүх эсхүл Үндсэн хуулийн шүүх);
- Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага (Ихэвчлэн Хууль зүйн яам эсхүл Дотоод хэргийн яам, цөөн тохиолдолд хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллага).

Ингэхдээ Дээд шүүх нь улс төрийн намыг бүртгэхтэй холбоотой гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрийг **гагцхүү давж заалдах журмаар хянах хэлбэрээр** оролцож байх юм.

Харин Монгол Улсад улс төрийн намын эрх зүйн үндсийг Улс төрийн намын тухай хуульд² хуульчилж, улс төрийн намын бүртгэлийг УДШ-д хариуцуулжээ. Харин УДШ-ийн улс төрийн намын бүртгэл хөтлөх чиг үүргийг “шүүн таслах ажиллагаанаас бусад бүрэн эрх” болохыг Шүүхийн тухай хуульд³ заасан. Энэхүү бүрэн эрхийг “анхнаасаа” буюу 1990 оны “Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль”-аас эхлэн УДШ-д олгосон бөгөөд процессын хувьд 2021 оноос нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх болсон билээ.

Судалгааны эхний бүлэгт харьцуулсан судалгааг, удаах бүлэгт Монгол Улсын зохицуулалтыг авч үзнэ.

НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улс төрийн намын бүртгэл хөтлөх эрх бүхий субъектийг гадаад улсад хэрхэн хуульчилсан, улс төрийн нам бүртгэхэд тавигдах шаардлагын ялгаатай болон төсөөтэй талыг тодруулах, бүрэн дүүрэн хариулт өгөхийн тулд харьцуулсан судалгаа гүйцэтгэх шаардлагатай болно.

Судалгааны энэхүү хэсэгт Улс төрийн намын тухай хуультай, хуульдаа бүртгэлийг зохицуулсан улсуудыг тухайлан дэлгэрэнгүй авч үзсэн бөгөөд дээр дурдсанчлан улс төрийн намын тухай хуульгүй улсад нам байгуулах шалгуур тавьдаггүй, гагцхүү сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх замаар оролцохыг Сонгуулийн хуульдаа зохицуулсан тул доорх хүснэгтэд товч дурдав:

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (2005) №7.

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021) №05.



№ УТНТХ байхгүй, Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчээр бүртгүүлэхийг зохицуулдаг улсууд

Бельги Улс

Бельги Улсад улс төрийн намын тухай хууль тогтоомж байхгүй бөгөөд Сонгуулийн тухай хуульд улс төрийн нам байгуулах талаар аливаа шалгуур заагаагүй. Тус хуульд гагцхүү нам байгуулмагц намд төрөөс санхүүжилт олгох, хянах асуудлыг⁴ зохицуулжээ.

Данийн Хант Улс (Дани)

Тус улсад улс төрийн намын тухай хууль тогтоомж байхгүй бөгөөд “Сонгуулийн тухай хууль”⁵-даа улс төрийн нам байгуулах талаар заасан ганц шалгуур нь шаардлагатай тооны гарын үсэг байхаар хуульчилжээ.

Ингэхдээ улс төрийн нам байгуулж бүртгүүлэх гэхээс илүү сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх зохицуулалтыг агуулсан байна.

Ирланд Улс

Тус улсад улс төрийн нам бүртгүүлэх асуудлыг “Сонгуулийн тухай хууль”-аар зохицуулдаг бөгөөд хуулийг анх 1992 онд баталж, хамгийн сүүлд 2001 онд шинэчилсэн найруулгыг⁶ хуульчилжээ. Ингэхдээ улс төрийн нам байгуулахад аливаа шалгуур заагаагүй, гагцхүү бүх шатны сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх тухай зохицуулсан.

Франц Улс

Франц Улсад улс төрийн намын тухай тухайлсан хууль байхгүй бөгөөд Сонгуулийн тухай хуульдаа хамгийн сүүлд 2016 онд нэмэлт, өөрчлөлт⁷ оруулсан.

Хуульд улс төрийн нам байгуулах талаар аливаа шалгуур заагаагүй. Харин улс төрийн намд төрөөс санхүүжилт олгох, хянах харилцааг зохицуулсан байна.

Итали Улс

Тус улсад Франц Улстай адил улс төрийн намын тухай хууль байхгүй тул улс төрийн нам байгуулах шалгуур хуульчлаагүй. Энэ утгаараа улс төрийн намын бүртгэл гэж мөн байхгүй бөгөөд нам байгуулах дүрэм нь хувийн эрх зүйн холбоо байгуулахтай⁸ адил зарчмаар явдаг байна.

Нидерланд Улс

Тус улсад улс төрийн намын тухай тухайлсан хууль байхгүй бөгөөд намыг бүртгүүлэх аливаа журам байхгүй. Харин сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх асуудлыг зохицуулсан Сонгуулийн тухай хууль байна.

Швед Улс

Тус улсад улс төрийн намын тухай тухайлсан хууль байхгүй бөгөөд намыг бүртгүүлэх аливаа журам байхгүй. Харин сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх асуудлыг зохицуулсан Сонгуулийн тухай хууль байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

Энэхүү жагсаалтаас Улс төрийн намын тухайлсан хуультай боловч нам байгуулахад бүртгүүлэх шаардлага тавьдаггүй ганц улс нь тус улс болно. Тус улсад улс төрийн намын эрх зүйн үндсийг Үндсэн хууль (*Basic Law*)⁹-ийн 21 дүгээр зүйл болон Улс төрийн намын тухай хууль (*Political Parties Act*)¹⁰-аар тогтоожээ. Ингэхдээ улс төрийн нам байгуулахад бүртгүүлэх шаардлага тавьдаггүй бөгөөд зөвхөн сонгуульд оролцох тохиолдолд бүртгүүлдэг.

⁴ 2 дэх эшлэл, 20 дахь тал.

⁵ Дани Улсын Сонгуулийн тухай хууль (2020 онд нэмэлт, өөрчлөлт орсон), <https://elections.im.dk/parliament-elections/folketing-parliamentary-elections-act> [Сүүлд үзсэн: 2023.01.18]

⁶ Ирланд Улсын Сонгуулийн тухай хууль, <https://www.irishstatutebook.ie/eli/2001/act/38/enacted/en/pdf> [Сүүлд үзсэн: 2023.01.18]

⁷ Франц Улсын Сонгуулийн тухай хууль, https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070239/LEGISCTA000006115455/#LEGISCTA000029930685 [Сүүлд үзсэн: 2023.01.20]

⁸ 2 дэх эшлэл, 28 дахь тал.

⁹ Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf> [Сүүлд үзсэн: 2022.12.15].

¹⁰ Political Parties Act, <https://germanlawarchive.iuscomp.org/?p=235>. [Сүүлд үзсэн: 2022.12.15].



Харин доорх хүснэгтэд Улс төрийн намын тухай хуультай улсууд дахь улс төрийн намын бүртгэлийг хариуцах эрх бүхий байгууллагыг тоймлон (дэлгэрэнгүйг дараагийн нүүрнээс унших боломжтой) харуулав:

№	Улсын нэр	Улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага	Давж заалдах журмаар гомдол гаргаж болох эсэх
	Болгар Улс	Софи хотын шүүх	Болгарын Дээд шүүхэд бүртгэхээс татгалзсан шийдвэрийг давж заалдах журмаар хянуулна.
	Чех Улс	Дотоод хэргийн яам	Бүгд Найрамдах Чех Улсын Дээд шүүхэд бүртгэхээс татгалзсан шийдвэрийг давж заалдах журмаар хянуулна.
	Эстони Улс	Тарту мужийн шүүхийн бүртгэлийн хэлтэс	Хуульд заагаагүй боловч Үндсэн хуулийн шүүхэд улс төрийн намын үйл ажиллагааны талаар гомдол гаргаж болно.
	Испани Улс	Дотоод хэргийн яам	Захиргааны хэргийн шүүхэд давж заалдах журмаар хандаж болно.
	Кипр Улс	Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Захиргааны хэргийн шүүхэд давж заалдах журмаар хандаж болно.
	Латви Улс	Хуулийн этгээдийн бүртгэлийн газар	Захиргааны хэргийн шүүхэд давж заалдах журмаар гомдол гаргаж болно.
	Литва Улс	Хууль зүйн яамны хуулийн этгээдийн бүртгэлийн газар	Бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хянуулахаар шүүхэд давж заалдах журмаар гомдол гаргаж болохыг заасан боловч аль шүүхэд хандахыг заагаагүй.
	Австри Улс	Холбооны Дотоод хэргийн яам	Хуульд заагаагүй.
	Польш Улс	Варшав хотын Дүүргийн шүүх	Давж заалдах шатны шүүхэд давж заалдах журмаар хянуулахаар гомдол гаргаж болно.
	Португал Улс	Үндсэн хуулийн шүүх	Хуульд заагаагүй.
	Румын Улс	Бухарест хотын шүүх	Бухарест хотын Давж заалдах шатны шүүхэд давж заалдах журмаар хандаж болно.
	Словени Улс	Дотоод хэргийн яам	Хуульд заагаагүй.
	Словак Улс	Дотоод хэргийн яам	Бүгд Найрамдах Словак Улсын Дээд шүүхэд улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргаж болно.
	Финланд Улс	Хууль зүйн яам	Давж заалдах журмаар гомдол гаргаж болохыг заасан боловч хаана гаргахыг заагаагүй.
	Их Британи	Сонгуулийн хороо	Хуульд заагаагүй.
	Ангол Улс	Үндсэн хуулийн шүүх	Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүх бүрэлдэхүүнд давж заалдах гомдол гаргаж болно.
	Оросын Холбооны Улс	Хууль зүйн яам	Шүүхэд улс төрийн нам эсвэл түүний бүс нутгийн салбарыг татгалзсан эсхүл зайлсхийсэн тохиолдолд гомдол гаргаж болохоор заасан боловч аль шүүх болохыг заагаагүй.



1.1. Болгар Улс

Болгар Улс 1990 онд “Улс төрийн намын тухай хууль”-аа баталж, 2006 онд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ тус хуульд улс төрийн намын бүртгэлийг **Софи хотын шүүх** хариуцахаар заасан¹¹ ба тухайн намын эрх бүхий этгээд үүсгэн байгуулах хурлаас хойш гурван сарын дотор бичгээр өргөдөл гаргасныг үндэслэж бүртгэнэ.

Улс төрийн нам бүртгүүлэхийг хүссэн өргөдөлд дараах зүйлийг агуулсан байна:

- Эвлэлдэн нэгдэх тухай мэдэгдэл;
- Нам үүсгэн байгуулах хурлын протокол;
- Намын дүрэм;
- 500-гаас доошгүй гишүүний (үүсгэн байгуулагч болон саналын эрхтэй гишүүн) нэр, регистрийн дугаар, байнгын хаяг, гарын үсгийг багтаасан жагсаалт;
- Намын удирдах байгууллагад сонгогдсон гишүүдийн нэр;
- Намын дүрмийн дагуу намыг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр;
- 2500-гаас доошгүй гишүүний¹² нэр, регистрийн дугаар, байнгын хаяг, гарын үсгийг багтаасан

¹¹ Мөн тэнд.

¹² Тус улсын хуулийн 10, 12, 15 дугаар зүйлд зааснаар 50, 500, 2500 гэсэн тусдаа тоо байх бөгөөд Нам үүсгэн байгуулах санаачилгын хороог саналын эрхтэй 50-аас доошгүй гишүүнтэйгээр байгуулж, “Нам үүсгэн байгуулах хурал”-ыг саналын эрхтэй 500-гаас доошгүй гишүүнтэйгээр хийж, нийтдээ нам нь 2500-гаас доошгүй гишүүнтэй байхаар тус тус заажээ.

Болгар Улсын Улс төрийн намын тухай хууль Төрийн сонин (State Gazette)-ы 2009 оны 6 дугаарт хамгийн сүүлийн байдлаар хэвлэгдсэн.

<https://www.partylaw.leidenuniv.nl/party-law/4d4150e9-7860-4c62-bf6b-35df5bda7d64>. pdf [Сүүлд үзсэн: 2023.01.18]

жагсаалт;

- Баримт бичгийн үнэн зөвийг нотариатаар баталгаажуулсан улс төрийн намын удирдлагын мэдэгдэл;
- Нэрийн онцгой байдлын гэрчилгээ.

Шүүх Иргэний процессын хуулийн дагуу дээрх өргөдлийг гаргасан өдрөөс нь хойш **нэг сарын дотор** нээлттэй хуралдаанаар **өргөдөл гаргасан этгээдүүд** болон **прокурорыг** байлцуулан¹³ хянан үзнэ. Тийнхүү хуралдаанаас хойш **14 хоногийн дотор** шийдвэрээ гаргана.

Холбогдох этгээд хэрэв улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан Софи хотын шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш **7 хоногийн дотор Улсын дээд шүүх (Supreme Court of Cassation)**-д¹⁴ давж заалдах гомдол гаргана. Улсын дээд шүүх давж заалдах гомдлыг гаргасан өдрөөс 14 хоногийн дотор хянан үзэж шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь **эцсийн шийдвэр** байна.

Харин улс төрийн намыг бүртгэхийг зөвшөөрсөн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор Софи хотын шүүх улс төрийн намыг “улс төрийн намын бүртгэл”-д бүртгэнэ. Тийнхүү бүртгүүлсэн өдрөөс эхлэн улс төрийн нам нь хуулийн этгээдийн эрхтэй болохоор заажээ.

¹³ Прокурорыг байлцуулах талаар тус улсын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 16 дугаар зүйлд заасан.

¹⁴ Болгарын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлд Дээд шүүхэд давж заалдах журмаар хандахыг заасан.



1.2. Бүгд Найрамдах Чех Улс (Чех)

Тус улс “Улс төрийн намын тухай хууль”¹⁵-аа 1991 онд баталж, 2006 онд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Хуульд зааснаар улс төрийн нам бүртгэх чиг үүргийг **Дотоод хэргийн яам** нь хариуцдаг. Ингэхдээ улс төрийн нам бүртгүүлэх талаарх бичгээр гаргасан өргөдөлд дараах баримтыг хавсаргасан байхаар заасан:

- 1000-аас доошгүй гишүүний овог, нэр, төрсөн огноо, байнгын хаяг, гарын үсэг;
- Дараах асуудлыг заасан намын дүрмийн хоёр хувь хуулбар:

Улс төрийн нам, хөдөлгөөний нэр, товчлол;

Бүртгэлтэй оффис;

Үйл ажиллагааны зорилго;

Гишүүдийн эрх, үүрэг;

Зохион байгуулалтын бүтэц;

Эрх бүхий этгээд, түүний эрх хэмжээ;

Бие даасан эвслийн улс төрийн намыг төлөөлөн явуулж болох үйл ажиллагааны хүрээ хязгаар, эрх хэмжээ;

Санхүү эрхлэх зарчим;

Гишүүн хураамж төлөхөөр заасан тохиолдолд хураамжийн тооцоолол, хэрэв аливаа гишүүний нэг жилд төлөх хураамж 50,000,000 чех кроноос дээш бол гишүүний биеийн байцаалт, санхүүгийн жилийн тайлангийн хавсралт;

Улс төрийн нам, хөдөлгөөн татан буугдсан тохиолдолд төрд хохирол учруулахааргүй бол татан буулгасны үр дүнд үүсэж болзошгүй хөрөнгө, өр

төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга зам.

Дотоод хэргийн яам дээрх баримт бичгийг хянан үзэж, дутуу буюу бодитой бус мэдээлэл байвал тухайн намын “Бэлтгэл хороо” (Preparatory Committee)-нд өргөдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор мэдэгдэх ба нэмэлт баримтыг ирүүлээгүй тохиолдолд бүртгэх ажиллагааг цуцална.

Хэрэв Дотоод хэргийн яамнаас өргөдлийг хүлээн авснаас хойш 10 өдрийн дотор Бэлтгэл хороонд аливаа байдлаар мэдэгдээгүй бол бүртгүүлэх өргөдлийг татгалзахгүйгээр хүлээн зөвшөөрсөнд тооцохоор байна. Харин Бэлтгэл хороо Дотоод хэргийн яамны мэдэгдлийг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор **харьяалах захиргааны хэргийн шүүхэд** өргөдөлд аливаа асуудал байхгүй болохыг маргахаар гомдол гаргаж болно. Ингэхдээ тус асуудлыг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь **эцсийн шийдвэр** байна.

Дотоод хэргийн яам бүртгэх ажиллагаа эхэлснээс хойш 15 хоногийн дотор улс төрийн нам, хөдөлгөөнийг бүртгэх буюу бүртгэхээс татгалзахаар шийдвэрлэнэ. Бүртгэхээр шийдвэрлэсэн бол бүртгэлийн огноо бүхий баримтыг намын Бэлтгэл хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүргүүлэх бөгөөд **энэ тохиолдолд давж заалдах гомдол гаргахгүй**. Харин бүртгэх ажиллагаа эхэлснээс хойш 30 хоногийн дотор Бэлтгэл хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч бүртгэхээс татгалзсан аливаа шийдвэр хүлээн аваагүй бол тухайн өдрөөс эхлэн улс төрийн намаар бүртгэгдсэнд

¹⁵ Чех Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.psp.cz/en/docs/laws/1991/424.html> [Сүүлд үзсэн: 2023.01.18]



тооцно. Бэлтгэл хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр бүртгэлийн огноо бүхий баримтыг Дотоод хэргийн яам хүргүүлнэ. Бүртгэхээс татгалзсан тохиолдолд шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор **Бүгд Найрамдах Чех Улсын Дээд шүүхэд** бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хянуулахаар давж заалдах журмаар хандаж болно. Дээд шүүх шийдвэрийг үндэслэлгүй бол хүчингүй болгож, бүртгэх шийдвэр гаргана.

Түүнчлэн, шинээр бүртгүүлсэн улс төрийн нам, хөдөлгөөний нэр, товчлол, бүртгэлтэй оффис зэргийн мэдээллийг Дотоод хэргийн яам бүртгэсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Чех Улсын бүртгэлийн газарт хүргүүлэхээр заажээ.

1.3. Эстони Улс

Эстони Улс 1994 онд “Улс төрийн намын тухай хууль”¹⁶-аа баталж, 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус хуулийн 1 дүгээр зүйлд “Улс төрийн нам нь ашгийн төлөө бус холбоо байна” гэж тодорхойлсон бөгөөд улс төрийн намын тогтвортой байдлыг¹⁷ хангах үүднээс “Рийгикогу (эстон. *Riigikogu*, -“Улсын хурал”) -ийн хоёр удаагийн ээлжит сонгуульд нэр дэвших эрх авч чадаагүй бол **бүртгэлээс хасагдах бөгөөд үйл ажиллагаагаа зогсооно**” гэж хуульчилжээ.

Улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь тус улсад **Тарту мужийн шүүхийн бүртгэлийн хэлтэс** байх бөгөөд улс төрийн намыг бүртгүүлэхдээ өргөдөл гаргахаар байна. Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд дараах

зүйлийг хавсаргахаар заажээ:

- Удирдах эрх бүхий этгээдүүдийн гарын үсэг бүхий намын дүрэм;
- Гишүүдийн (1000-аас доошгүй) нэр, регистрийн дугаар, улс төрийн намд гишүүнээр элссэн он, сар, өдөр;
- Намын дүрэмд заасан бол улс төрийн намын ялгах тэмдгийн дээж, дүрслэл;

Хэрэв бүртгэлтэй улс төрийн намын гишүүдийн тоо 1000-аас буурсны улмаас сайн дураараа татан буугдаагүй бол шүүхийн бүртгэлийн хэлтэс албадан татан буулгах ажиллагаа явуулах хүсэлт гаргаж болохоор байна.

Тус улсын хуульд зааснаар намын зорилго, үйл ажиллагаа Эстонийн Үндсэн хуулийн дэг журмыг хүчээр өөрчлөхөд чиглэсэн байвал Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (*Constitutional Review Court Procedure Act*)-ийн дагуу намын үйл ажиллагааг зогсооно.

1.4. Испани Улс

Испани Улс “Улс төрийн намын тухай хууль”¹⁸-аа 1978 онд баталж, 2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Тус улсын хуульд зааснаар улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Дотоод хэргийн яам** байна. Харин улс төрийн нам бүртгүүлэхдээ дараах баримтыг хавсаргахаар заажээ:

- Намын дүрмийн дагуу нам үүсгэн байгуулсан тухай гэрээг нотариатаар баталгаажуулсан хуулбар,

¹⁶ Эстони Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.riigiteataja.ee/en/eli/513042015011/consolide> [Сүүлд үзсэн: 2023.01.18]

¹⁷ 2 дэх эшлэл, 25 дахь тал.

¹⁸ Испанийн Улс төрийн намын тухай хууль, https://adsdatabase.ohchr.org/IssueLibrary/SPAIN_Organic%20Law%206-2002%20on%20political%20parties.pdf [Сүүлд үзсэн: 2023.01.18]



- Үүсгэн байгуулагчдын хувийн мэдээлэл,
- Намын нэр;
- Намын салбарын үйл ажиллагааг хариуцах гишүүд, хаяг;
- Намын дүрэм.

Дээрх зүйлсийг хуульчлахдаа намын нэр нь тухайн намын ялгах тэмдгийн хувьд иргэдийн үндсэн эрх, хууль зөрчсөн төөрөгдүүлэх буюу буруу мэдээлэл агуулсан нэр томъёо, хэллэгтэй байж болохгүйг тухайлан заасан байна. Намыг бүртгүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах этгээд нь намыг үүсгэн байгуулагчид байна.

Ийнхүү улс төрийн намыг бүртгүүлэх хүсэлт гаргаснаас хойш 20 хоногийн дотор Дотоод хэргийн яам бүртгэх бөгөөд улс төрийн намыг бүртгэх ажиллагаатай холбоотой асуудлаар **Захиргааны хэргийн шүүхэд** давж заалдах журмаар хандаж болно.

1.5. Кипр Улс

Кипр Улс “Улс төрийн намын тухай хууль”¹⁹-аа 2012 онд шинэчлэн баталжээ. Тус улсын хуулиар улс төрийн намын бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага нь “улс төрийн намын бүртгэлийн комиссар” буюу **Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга** байна. Ингэхдээ улс төрийн намын бүртгэлтэй холбогдох аливаа мэдээллийг “Бүгд найрамдах улсын албан ёсны хэвлэл”-д мэдээлэхээр заасан.

Улс төрийн намыг бүртгүүлэх хүсэлт гаргахдаа дараах баримтыг хавсаргахаар заажээ:

¹⁹ Кипр Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://aceproject.org/ero-en/regions/europe/CY/cyprus-the-political-parties-law-2012/view> [Сүүлд үзсэн: 2023.01.20]

- Намын дүрэм;
- Намын нэр;
- Намын ялгах тэмдэг;
- Намын удирдах этгээдүүдийн нэр, хаяг;
- Намыг бүртгүүлэх өргөдлийг дэмжиж санал өгөх эрхтэй 300 иргэний гарын үсэг;
- Харьяа байгууллагын жагсаалт;
- Бүртгэлийн хураамж (2000 евро) төлсөн баримт.

Дээрх хуулийн нэгэн онцлог зохицуулалт нь “Европын парламентад бүртгэлтэй намаас бусад улс төрийн намыг бүртгэх асуудлаар гаргасан Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр нь Үндсэн хуульд заасанчлан **захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах захиргааны акт** байна” гэж заасан 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг байна.

1.6. Латви Улс

Латви Улсын парламент 2007 онд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг²⁰ баталжээ. Тус улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Хуулийн этгээдийн бүртгэлийн газар** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд дараах баримтыг хавсаргасан байхаар заасан:

- Улс төрийн намын нэр;
- Намын үйл ажиллагааны зорилго;
- Үүсгэн байгуулагчдын эрх, үүрэг;
- Бүх үүсгэн байгуулагчийн (200-аас доошгүй) зөвшөөрөл, хоёроос

²⁰ Jānis Ikstens, “Party Regulation in Latvia: A Relative Success”, Working Paper Series on the Legal Regulation of Political Parties, 2013, No. 37, <http://www.partylaw.leidenuniv.nl/uploads/wp3713.pdf> [Сүүлд үзсэн: 2023.01.23]



доошгүй үүсгэн байгуулагчийн гарын үсэг;

- Намын бүртгэлийн хураамж болон төрийн мэдээллийн эмхэтгэл болох *Latvijas Vēstnesis* сэтгүүлд хэвлүүлэх хураамж төлсөн баримт.

Дээрх өргөдөл, хавсаргасан баримтыг бүрэн хүлээн авснаас хойш Хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь ажлын долоо хоногийн дотор шийдвэр гаргах үүрэгтэй. Хэрэв өргөдөлд байгаа баримт хоорондоо зөрчилтэй, улс төрийн нам байгуулах процедурыг зохих ёсоор явуулаагүй, хавсаргасан баримт бичиг дутуу бол бүртгэхээс татгалзах буюу хойшлуулж болно.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улс төрийн намын бүртгэлтэй холбогдох аливаа шийдвэрийг хянуулахаар **Захиргааны хэргийн шүүхэд давж заалдах журмаар** гомдол гаргаж болно.

1.7. Литва Улс

Тус улс Улс төрийн намын тухай хуулиа²¹ анх 1990 онд баталснаас хойш 2019 онд шинэчлэн баталсан. Ингэхдээ улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Хууль зүйн яамны хуулийн этгээдийн бүртгэлийн газар** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл гаргахдаа намын дүрмийг хавсаргах бөгөөд намын дүрэмд дараах зүйлийг заавал тусгасан байхаар заасан:

- Улс төрийн намын нэр;
- Улс төрийн намын эрх зүйн хэлбэр (*legal form*);

²¹ Литва Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/2a2faf104f7811eba1f8b445a2cb2bc7?jfwid=i3h7wu63e> [Сүүлд үзсэн: 2023.01.23]

- Улс төрийн намын суудал өөрчлөх журам;
- Улс төрийн намын үйл ажиллагааны чиглэл, зорилго;
- Улс төрийн намд гишүүнээр элсэх, гарах нөхцөл, журам;
- Гишүүний эрх, үүрэг;
- Улс төрийн намын гишүүний хураамж авах, төлөх, залруулах журам;
- Улс төрийн намын салбар байгуулах, татан буулгах журам;
- Улс төрийн намын хурал хийх хугацаа, бүрэн эрх, түүнийг зохион байгуулах журам;
- Улс төрийн намын удирдах байгууллагыг сонгох, улируулах журам, хугацаа, бүрэн эрх;
- Улс төрийн намын удирдагчийг сонгох, улируулах хугацаа, журам, бүрэн эрх;
- Улс төрийн намын удирдах эрх бүхий этгээдийн хариуцлага хүлээх, хурал зохион байгуулах журам;
- Улс төрийн намын дүрэм, хөтөлбөрийг өөрчлөх журам;
- Улс төрийн намын бэлэг тэмдэг (хэрэв ашиглах бол);
- Улс төрийн намын төсөв, хөрөнгийг захиран зарцуулах журам;
- Улс төрийн намын үйл ажиллагаа явуулах хугацаа (тодорхой хугацаатай бол);
- Улс төрийн намыг бүртгүүлэхээс татгалзах нөхцөл.

Дээрх баримтад гарын үсэг зурсан этгээдийн гарын үсгийг нотариатаар батлуулах шаардлагагүй болохыг тухайлан хуульчилсан байна.

Хууль зүйн яам дээрх өргөдөл, холбогдох баримтыг бүрэн хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүртгэнэ. Хэрэв холбогдох баримт дутуу бол Хууль зүйн яамны хуулийн этгээдийн бүртгэлийн газар хүлээн авснаас хойш 15-аас дээшгүй хоногийн дотор улс төрийн намын үүсгэн байгуулагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид бичгээр мэдэгдэж, авах арга хэмжээг заана. Тийнхүү дутуу баримтыг бүрэн бүрдүүлснээс хойш шинээр 30 хоног тоолно.

Ингэхдээ Хууль зүйн яам улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл, түүнд заасан баримт бичгийн үнэн зөв байдалтай холбоотой асуудлаар төрийн бусад байгууллагад хандаж, дүгнэлт гаргуулж болохоор заажээ. Улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан Хууль зүйн яамны шийдвэрийг эс зөвшөөрвөл **шүүхэд давж заалдах журмаар** гомдол гаргаж болно.

1.8. Австри Улс

Тус улс Улс төрийн намын тухай хуулиа²² 2012 онд шинэчлэн баталжээ. Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой хариуцах эрх бүхий байгууллага нь Австри Улсад **Холбооны Дотоод хэргийн яам** байна.

Ингэхдээ улс төрийн нам бүртгүүлж, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар олж авахад (1) улс төрийн нам; (2) улс төрийн намын дүрмийг Холбооны Дотоод

хэргийн яамд хүргүүлэх бөгөөд улс төрийн намын дүрэмд дараах зүйлийг заавал тусгасан байхаар заажээ:

- Улс төрийн намыг төлөөлөх эрх бүхий байгууллага, ээлжит хурал зохион байгуулах журам;
- Гишүүний эрх, үүрэг;
- Улс төрийн намын бүтэц;
- Улс төрийн намыг сайн дураар татан буулгах журам.

Улс төрийн нам сайн дураараа татан буугдах тохиолдолд Холбооны Дотоод хэргийн яамд мэдэгдэнэ. Тус улсад хэдийгээр ийнхүү улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлыг хариуцах байгууллага нь Холбооны Дотоод хэргийн яам байх боловч бүртгүүлэхэд аливаа төлбөр, хураамж авдаггүй, яамны оролцоо, бүрэн эрх харьцангуй хязгаарлагдмал, бүртгэхтэй холбоотой хатуу шаардлага хуулиар зохицуулаагүй нь онцлог байна.

1.9. Польш Улс

Тус улс Улс төрийн намын тухай хуулиа²³ 1990 онд анхлан баталснаас хойш 1997 онд шинэчилсэн найруулгыг хуульчилж, 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Польш Улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Варшав хотын Дүүргийн шүүх** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд дараах зүйлийг тусгасан байхаар заасан:

- Улс төрийн намын нэр, товчлол;
- Улс төрийн намын удирдах

²² Австри Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://advocatetamoy.com/2020/11/18/political-parties-act-2012-austria/> [Сүүлд үзсэн: 2023.01.23]

²³ Польш Улсын Улс төрийн намын тухай хууль, https://europam.eu/data/mechanisms/PF/PF%20Laws/Poland/Poland_Law%20on%20political%20parties_1997_amended2016_pol.pdf [Сүүлд үзсэн: 2023.01.23]



байгууллагын хаяг;

- Улс төрийн намын дүрмийг баталсан, төлөөлж, хариуцлага хүлээх эрх бүхий гишүүдийн овог, нэр, хаяг;
- Улс төрийн намын бэлэг тэмдгийн жишиг хуулбарыг хавсаргаж болно.

Харин дараах баримтыг хавсаргасан байна:

- Улс төрийн намын дүрэм;
- Өргөдлийг дэмжиж гарын үсэг зурсан эрх зүйн бүрэн чадамжтай, 18-аас дээш насны намын 1000-аас доошгүй гишүүний овог, нэр, оршин суугаа хаяг.

Улс төрийн намыг бүртгэх ажиллагааг шүүх нэн даруй эхлүүлэх бөгөөд хаалттай хуралдаанаар шийдвэрлэнэ. Ингэхдээ шүүх “шүүх хуралдаан” зарлаж болно. Улс төрийн намыг бүртгэсэн шүүхийн шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд **Давж заалдах шатны шүүхэд давж заалдах журмаар хянуулахаар гомдол гаргаж** болно.

Хэрэв улс төрийн дүрэмд заасан зорилго, чиглэл, зарчим нь Үндсэн хуульд харшилсан байж болзошгүй гэж үзвэл Варшав хотын Дүүргийн шүүхээс **Үндсэн хуулийн шүүхэд мэдээлэл** гаргана. Үндсэн хуулийн шүүх намын дүрмийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн тохиолдолд Варшав хотын Дүүргийн шүүх улс төрийн намыг бүртгэхээс татгалзана. Тийнхүү татгалзсан шийдвэрийг давж заалдахгүй.

1.10. Португал Улс

Португал Улс Улс төрийн намын тухай хуулиа²⁴ 1974 онд анхлан баталснаас хойш 2003 онд шинэчлэн баталж, улмаар 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **анх Дээд шүүх байсан** бөгөөд 2003 оны хуулиас эхлэн **Үндсэн хуулийн шүүх** болжээ.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл нь дараах шаардлагыг хангасан байхаар заасан:

- 7500 бүртгэлтэй сонгогчийн гарын үсэг;
- Өргөдлийг бичгээр гаргасан байх ба дараах баримтыг хавсаргана:
 - Намын дүрэм;
 - Намын нэр, товчлол, бэлэг тэмдэг;
 - Бүх гарын үсэг зурсан гишүүний регистрийн дугаар, сонгогчийн үнэмлэхийн дугаар.

Үндсэн хуулийн шүүх улс төрийн намыг бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд Бүгд Найрамдах Улсын эмхэтгэл (*Diário da República*)-д шүүхийн шийдвэр болон намын дүрмийг хэвлүүлнэ. Түүнчлэн, **Улсын прокурорын газрын хүсэлтээр** Үндсэн хуулийн шүүх нь хэдийд ч улс төрийн намыг бүртгэлийг хянан үзэж, хууль бус болохыг зарлаж болно. Тийнхүү хянан үзэж болох нь дараах тохиолдолд байна:

- Улс төрийн намыг зэвсэгт хүчний эсхүл цэргийн, хагас цэргийн үйл ажиллагаа явуулсан, эсхүл арьс өнгөөр ялгаварлан гадуурхах

²⁴ Португал Улсын Улс төрийн намын тухай хууль, <http://www.parliament.am/library/Political%20parties/Portugal.pdf> [Сүүлд үзсэн: 2023.01.23]



- буюу фашист үзэл баримтлалтай байгууллага гэж үзсэн бол;
- Улс төрийн намын гишүүний тоо 5000-д хүрээгүй бол;
 - Улс төрийн нам нь 6 ээлжит сонгуулийн жил дараалан парламентын бүх сонгуулийн тойргийн гуравны нэгээс доошгүйд нь нэр дэвшүүлээгүй, эсхүл орон нутгийн сонгуулийн тавны нэгд нь нэр дэвшүүлээгүй бол;
 - Улс төрийн нам нь 6-гаас доошгүй жил үндэсний эрх бүхий байгууллагад мэдээллээ шинэчлэн хүргүүлээгүй бол;
 - Улс төрийн нам нь 3 жил дараалан тайлангаа танилцуулаагүй бол;
 - Шүүхэд бүртгүүлсэн жагсаалын дагуу нам нь дотооддоо үйлчлэх, мэдэгдэх боломжгүй болсон бол.

1.11. Румын Улс

Румын Улс Улс төрийн намын тухай хуулиа²⁵ 1996 онд баталж, 2003 онд шинэчилсэн найруулгыг хуульчилжээ. Тус хуулиар улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Бухарест хотын шүүх** байна.

Улс төрийн намын бүртгүүлэх өргөдөлд дараах баримтыг хавсаргасан байхаар заасан:

- Улс төрийн намыг шүүхэд төлөөлөх эрх бүхий 3-аас доошгүй үүсгэн байгуулагч гишүүн болон удирдах эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий өргөдөл;

- Намын дүрэм;
- Намын хөтөлбөр;
- Үүсгэн байгуулагчдын гарын үсгийн жагсаалт бүхий үүсгэн байгуулсан гэрээ, дүрэм;
- Намын төв байр, өмч хөрөнгийн талаарх мэдэгдэл;
- Намын эзэмшлийн банкны дан нээлгэсэн баримт.

Дээрх өргөдөл, баримтыг Бухарест хотын шүүх **15 хоногийн дотор** шийдвэр гаргаж мэдээлэх бөгөөд **3 хоногийн дотор** өргөдөл гаргагч өөрөө төрийн төв хэвлэлд холбогдох зарыг нийтлүүлнэ.

Хэрэв улс төрийн намыг бүртгэсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл Яам болон холбогдох этгээд **Бухарест хотын Давж заалдах шатны шүүхэд зар гарснаас хойш 5 хоногийн дотор давж заалдах журмаар хандах** бөгөөд Давж заалдах шатны шүүх 15-аас дээшгүй хоногт багтаан нээлттэй хуралдаанаар шийдвэрлэнэ. Бухарест хотын **Давж заалдах шатны шүүхийн** шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

1.12. Словени Улс

Тус улс Улс төрийн намын тухай хуулиа²⁶ 1994 онд баталж, 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Словени Улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Дотоод хэргийн яам** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд дараах зүйлийг заавал тусгасан байна:

²⁵ Румын Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.partylaw.leidenuniv.nl/party-law/4e2d4e07-e470-4396-ba64-08e084e5412d.pdf> [Сүүлд үзсэн: 2023.01.23]

²⁶ Словени Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://europam.eu/data/mechanisms/PF/PF%20Laws/Slovenia/Slovenia%20PolS%201994%20amended2014%20SLV.pdf> [Сүүлд үзсэн: 2023.01.23]



- Үүсгэн байгуулагч 200 гишүүний гарын үсэг бүхий мэдэгдэл;
 - Намын дүрэм, хөтөлбөр;
 - Үүсгэн байгуулах хурлын огноо, протокол;
 - Намын бэлэг тэмдэг (өнгөтөөр болон хар, цагаан техникээр).
- Намын регистрийн дугаар;
 - Намын удирдах эрх бүхий этгээдийн овог, нэр, төрсөн огноо, байнгын оршин суугаа хаяг, бүрэн эрх;
 - Намын хаяг, дүрэм, удирдах этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулсан огноо, дугаар;
 - Шинэ дүрмийн бүртгэлийн дугаар;
 - Намыг татан буулгасан баримт, шалтгаан;
 - Дампуурлыг зарласан мэдэгдэл;
 - Улс төрийн намын бүртгэлээс хасуулах огноо, шалтгаан.

Бүртгэх эрх бүхий байгууллага нь мөн намыг төлөөлөх эрх бүхий гишүүдийн овог, нэр, хүйс, түр болон байнгын оршин суух хаяг зэрэг хувийн болон бусад мэдээллийг Дотоод хэргийн яамны мэдээллийн сангаас гаргуулах бөгөөд өргөдөл гаргагч этгээдээр гаргуулахаар заажээ.

1.13. Словак Улс

Словак Улс Улс төрийн намын тухай хуулиа²⁷ 1993 онд баталж, 2005 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Тус улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Дотоод хэргийн яам** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх, өөрчлөлт оруулах, хасуулах аливаа өргөдөлд дараах зүйлийг тусгаж, холбогдох баримтыг хавсаргахаар заасан:

- Улс төрийн намын нэр, товчлол;
- Бүртгэлтэй оффис (Төв байр)-ын хаяг;
- Намын бүртгэлийн огноо, дагуур;
- Намын Бэлтгэл хорооны бүх гишүүний овог, нэр, төрсөн огноо, байнгын оршин суугаа хаяг;

Хэрэв өргөдөлд хавсаргасан аливаа **баримт дутуу** байвал Дотоод хэргийн яам өргөдлийг хүлээн авснаас хойш **5-аас илүүгүй хоногийн** дотор намын **Бэлтгэл хороонд бичгээр мэдэгдэнэ**. Хэрвээ Дотоод хэргийн яам өргөдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Бэлтгэл хороонд аливаа мэдэгдэл хүргүүлээгүй бол өргөдөл, холбогдох баримт бичиг бүрэн гэж ойлгоно. Харин Бэлтгэл хороо Дотоод хэргийн яамны мэдэгдлийг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 15 өдрийн дотор **харьяалах шүүхэд өргөдөл нь бүрэн, үнэн зөв болох талаар маргаж гомдол гаргаж болно**. Харьяалах анхан шатны шүүхийн энэ талаарх **шүүхийн шийдвэрийг давж заалдахгүй**.

Харин өргөдөл, холбогдох баримт нь бүрэн эсхүл харьяалах шүүхээс өргөдлийг хүлээн аваагүй нь буруу болохыг тогтоосон шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд Дотоод хэргийн яам улс төрийн намыг бүртгэх ажиллагааг эхлүүлж, **5 хоногийн дотор**

²⁷ Словак Улсын Улс төрийн намын тухай хууль, http://www.sze.hu/~smuk/Nyilvanossag_torvenyek_CEE/Valasztasi_szabalyok/Slovakia%20Act%20on%20Political%20Parties_2005_en.pdf [Сүүлд үзсэн: 2023.01.23]



шийдвэрлэнэ. Улс төрийн намыг бүртгэж шийдвэрлэснээс хойш 7 хоногийн дотор Дотоод хэргийн яам нь Бүгд Найрамдах Словак Улсын Бүртгэлийн газарт намын нэр, товчлол, бүртгэсэн шийдвэрийг хүргүүлнэ.

Хэрэв улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл **Бүгд Найрамдах Словак Улсын Дээд шүүхэд давж заалдах журмаар** гомдол гаргаж болно. Гомдолд Бэлтгэл хорооны бүх гишүүд гарын үсэг зурсан байхыг шаардах бөгөөд Дээд шүүх бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хууль бус гэж шийдвэрлэсэн тохиолдолд Дээд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс Дотоод хэргийн яам шийдвэрийг биелүүлнэ.

1.14. Финланд Улс

Тус улс Улс төрийн намын тухай хуулиа²⁸ 1969 онд анхлан баталж, 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Финланд Улсад улс төрийн намыг бүртгэх эрх бүхий байгууллага нь **Хууль зүйн яам** байна.

Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдлийг бичгээр гаргах бөгөөд өргөдөлд дараах баримтыг хавсаргасан байхаар заажээ:

- Төрийн хэрэгт оролцох үйл ажиллагааны үндсэн чиглэл;
- Парламентын сонгуульд оролцож санал өгөх эрх бүхий 5000-аас доошгүй гишүүний гарын үсэгтэй дэмжсэн картын (Хууль зүйн яамнаас баталсан загварын дагуу) жагсаалт;

²⁸ Финланд Улсын Улс төрийн намын тухай хууль, https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1969/en19690010_19920653.pdf [Сүүлд үзсэн: 2023.01.23]

- Ардчилсан зарчмыг хэрэгжүүлж ажиллахыг баталгаа болгосон намын дүрмийн баталгаажуулсан хуулбар;
- Намын хөтөлбөр.

Парламентын сонгуульд хоёр дараалж суудал авч чадаагүй намыг улс төрийн намын бүртгэлээс хасна. Түүнчлэн нам нь бүртгүүлэхээс татгалзсан тохиолдолд бүртгэлээс хасна. Улс төрийн нам бүртгэлээс хасуулах хүсэлтээ мөн Хууль зүйн яамд гаргаж болно.

Хууль зүйн яамны улс төрийн намын бүртгэлтэй холбоотой аливаа шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргасан эсэхээс үл хамаарч **давж заалдах гомдлыг шийдвэрлэх хүртэл Хууль зүйн яамны шийдвэр хүчинтэй хэвээр** байна. Гэсэн хэдий ч тус хуульд давж заалдах журмаар хаана хандахыг заагаагүй байна.

1.15. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад улс төрийн намын бүртгэлийг 2000 оны Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай хууль (англ. *Political Parties, Elections and Referendums Act 2000*)²⁹-ийн 2 дугаар бүлэг (Улс төрийн намуудын бүртгэл)-ээр нарийвчлан зохицуулсан байна. Уг хуулиар улс төрийн нам болон ардчиллын үйл явцад оролцох бусад байгууллагын бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, орлого, зарлагыг хянах хяналтын шинэ тогтолцоог бий болгосон.

²⁹ Political Parties, Elections and Referendums Act 2000, <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/part/II?timeline=false> [Сүүлд үзсэн: 2022.12.23]



Бүртгэлийг **Сонгуулийн хороо** (англ. *the Electoral Commission*) хариуцдаг бөгөөд Сонгуулийн хороо нь Их Британи дахь сонгуулийн үйл ажиллагааг хянаж, улс төрийн санхүүжилтийг зохицуулдаг бие даасан байгууллага юм. Уг байгууллагын чиг үүргийг “Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.1.а-д “улс төрийн намын бүртгэлийн ажлыг эрхэлнэ” гэж тусгасан байна.

Сонгуулийн хороо зохицуулагчийн чиг үүргийн хүрээнд 1998 оны “Улс төрийн намуудын бүртгэлийн тухай хууль” (англ. *Registration of Political Parties Act 1998*)³⁰ болон 2000 оны “Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай” хуулиудын зохицуулалтын дагуу ИБУИНХУ-ын хэмжээнд улс төрийн намын бүртгэл хөтлөх, нам бус нэр дэвшигчдийг бүртгэх, зааварчилгаа өгөх, улс төрийн санхүүгийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, нам болон дэвшигчдийн сурталчилгааг хянах, улс төрийн санхүүгийн хууль зөрчсөн гэж хардах үндэслэл байвал арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Тус улсад онолын үзэл баримтлалын хувьд улс төрийн нам нь эрүүл ардчиллын амин чухал хэсэг гэж үздэг. Улс төрийн намаар бүртгүүлэхийн тулд намууд нь “Сонгуулийн тухай хууль” (англ. *Electoral Law*)³¹-аар хүлээсэн үүргээ биелүүлэх чадамжтай гэдгээ харуулах шалгуур

тавьдаг.

“Улс төрийн намуудын бүртгэлийн тухай хууль” болон “Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай хууль”-уудын дагуу улс төрийн намыг бүртгэхтэй холбоотой дараах асуудлыг зохицуулжээ:

- Намын нэр дэвшигчид сонгуульд өрсөлдсөн тохиолдолд намыг бүртгэнэ. Нэр дэвшигчид бие даан нэр дэвших боломжтой;
- Бүртгүүлсэн нам Сонгуулийн тухай хуулийн дагуу санхүүгийн мэдээллээ Сонгуулийн Хороонд тайлагнах зэрэг хуулийн хариуцлага хүлээх болно;
- Намаар бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд Сонгуулийн Хороо татгалзсан шалтгааныг дурдах бөгөөд дахин хүсэлт гаргах эрх нээлттэй;
- Намаар бүртгүүлэх хүсэлт, өргөдлийг цахимаар гаргаж болдог.

“Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай хууль”-ийн 26 дугаар зүйлд зааснаар намыг бүртгэхийн тулд өргөдөл, хураамж (150), намын бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон дүрмийн хуулбар, намын санхүүгийн схемийн хуулбар, мөн 24 дүгээр зүйлд заасны дагуу намын дарга, нягтлан бодогч, нэр дэвшигч гишүүн гэх үүргийг гүйцэтгэх дор хаяж хоёр албан тушаалтны мэдээлэл шаардлагатай. Мөн намын даргаар бүртгүүлсэн этгээд нь нэр дэвшигч болон нягтлангийн аль алианаар нь бүртгүүлж болдог байна.

³⁰ Registration of Political Parties Act 1998, <https://www.legislation.gov.uk/ukpga/1998/48/contents> [Сүүлд үзсэн 2022.12.20]

³¹ Electoral law нь Их Британи дахь 17 хууль, 30 орчим багц журмуудад тусгалаа олсон байдаг ба хуулийн ихэнх хэсэг нь 19-р зууны бичиглэл, практикт үндэслэсэн бөгөөд орчин үеийн сонгуулийн удирдлагыг тусгаагүй байна.

“Улс төрийн нам, сонгууль, ард нийтийн санал асуулгын тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн дагуу улс төрийн нам нь Сонгуулийн хороонд намын бүртгэлийг шинэчлүүлэхээр хүсэлт гаргаж болно. Үүний дагуу хороо уг хүсэлтийг хүлээж авах эсхүл хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд татгалзаж болдог. Харин хороо нь намын дарга, намын нэр дэвшигч, нягтлангийн гарын үсэгтэй өргөдлийг хүлээн авахаас бусад тохиолдолд намыг **бүртгэлээс хасах эрхгүй** ажээ.

1.16. Бүгд Найрамдах Ангол Улс (БНАУ)

Бүгд Найрамдах Ангол Улс (цаашид “БНАУ” гэх)-ын хувьд улс төрийн намын эрх зүйн үндсийг БНАУ-ын Үндсэн хууль (англ. *Constitution of the Republic of Angola*)³²-ийн 17 дугаар зүйл болон Улс төрийн намын тухай хууль (англ. *Political Parties Law*)³³-аар тогтоожээ. БНАУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлд “Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан улс төрийн нам **Үндсэн хуулийн шүүхийн бүртгэлд** бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрхийг олж авна” гэж заасан буюу БНАУ-ын онцлог нь улс төрийн намыг **Үндсэн хуулийн шүүх** нь бүртгэдэг байна. БНАУ-ын Үндсэн хуулийн 17 дугаар зүйл болон Улс төрийн намын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар улс төрийн нам нь үндэсний тусгаар тогтнол, эв нэгдэл, ардчиллын зарчмуудыг хүндэтгэн

иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэх, төлөөлөх, эрх мэдлийн төлөө чөлөөтэй өрсөлдөх бие даасан, тогтвортой иргэний байгууллага болохыг томъёолон хуульчилжээ.

БНАУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар “Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч нь улс төрийн намыг бүртгэх хүсэлтийг шийдвэрлэхдээ намын нэр, таних тэмдэг, бэлгэдлийн ижил төстэй байдал, түүний нөлөөлөл; өмнөх зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх; намын дүрэм болон мөрийн хөтөлбөр энэ хуульд нийцэж байгаа эсэхийг хянана” гэжээ. Мөн Ерөнхий шүүгч нь улс төрийн намыг бүртгэх эсэх шийдвэрээ 60 хоногийн дотор гаргах бөгөөд хэрэв намын нэр, таних тэмдэг, бэлгэдлийг өөрчлөх, эсхүл 14 дүгээр зүйлийн 2-т заасан баримт бичгийн бүрдүүлбэрт нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл 15 хоногийн дотор бүртгүүлэх хүсэлт гаргасан намд мэдэгдэж, шийдвэр гаргах хугацааг түр зогсоохоор хуульчилсан.

Хэрэв БНАУ-ын Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч Улс төрийн намын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан үндэслэлээр улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан бол тухайн нам нь Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүх бүрэлдэхүүнд **давж заалдах гомдол гаргах** эрхийг тус хуулийн 18 дугаар зүйлээр зохицуулсан байна. Давж заалдах гомдлыг сонирхогч нам эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргасан нам, эсхүл БНАУ-ын Ерөнхий прокурор шийдвэр нийтлэгдсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор гаргах бөгөөд БНАУ-ын Үндсэн хуулийн шүүхийн нийт шүүх бүрэлдэхүүн 60 хоногийн дотор гомдлыг

³² Constitution of the Republic of Angola, <https://ecnl.org/sites/default/files/files/2021/AngolaConstitution.pdf>. [Сүүлд үзсэн: 2022.12.19].

³³ Political Parties Law <https://aceproject.org/ero-en/regions/africa/AO/zz%20Law%20No%202005%201%20of%20July.pdf>. [Сүүлд үзсэн: 2022.12.19].



шийдвэрлэхээр хуульчилжээ³⁴.

1.17. Оросын Холбооны Улс (ОХУ)

ОХУ-ын Хууль зүйн яамны 2022.09.26-ны өдрийн №199 “Ашгийн төлөө бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх шийдвэр гаргах төрийн үйлчилгээ үзүүлэх ОХУ-ын Хууль зүйн яамны захиргааны журмыг батлах тухай журмын” 9 дэх хэсэгт зааснаар **ОХУ-ын Хууль зүйн яамны төв аппарат улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэх эсэх шийдвэрийг гаргадаг**.³⁵

Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд улс төрийн нам эсвэл түүний бүс нутгийн салбарыг бүртгэх тухай бичилтийг ОХУ-ын 2001.07.11-ний өдрийн №95 “Улс төрийн намын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2004.09.30-ны өдрийн ОХУ-ын “Татварын албаны тухай журам”³⁶-д заасны дагуу **ОХУ-ын Татварын алба оруулна**.

ОХУ-ын 2001.07.11-ний өдрийн №95

³⁴ БНАУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 2 <https://aceproject.org/ero-en/regions/africa/AO/zz%20Law%20No%202%2005%201%20of%20July.pdf>. [Сүүлд үзсэн: 2022.12.20].

³⁵ Приказ Минюста России от 26.09.2022 N 199 “Об утверждении Административного регламента Министерства юстиции Российской Федерации по предоставлению государственной услуги по принятию решения о государственной регистрации некоммерческих организаций” (Зарегистрировано в Минюсте России 26.09.2022 N 70217) // (ОХУ-ын Хууль зүйн яамны 2022 оны 09-р сарын 26-ны өдрийн № 199 “Ашгийн төлөө бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх шийдвэр гаргах төрийн үйлчилгээ үзүүлэх ОХУ-ын Хууль зүйн яамны захиргааны журмыг батлах тухай журам”), http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_427450/53383761e6e04221b187648b12bbd4a1cd9adcec/ [Сүүлд үзсэн: 2022.12.20].

³⁶ Положение о Федеральной налоговой службе (утв. постановлением Правительства РФ от 30 сентября 2004 г. N 506) // 2004 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ОХУ-ын “Татварын албаны тухай журам” URL: https://base.garant.ru/12137054/#block_11012 [Сүүлд үзсэн: 2022.12.20].

“Улс төрийн намуудын тухай хууль”³⁷ батлагдахаас өмнө Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (цаашид “ЗСБНХУ” гэх)-ын 1990.10.09-ний өдрийн №1708-1 “Олон нийтийн нэгдлийн тухай хууль”³⁸ хүчин төгөлдөр мөрдөгдөж байв. Тус хуулийн 8 болон 11 дүгээр заалтуудын дагуу ЗСБНХУ-д улс төрийн намыг болон улс төрийн намын дотоод журмыг ЗСБНХУ-ын Хууль зүйн яам бүртгэдэг байсан бөгөөд одоо ч субъект нь хэвээр байна.

ОХУ-ын “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг³⁹ заасны дагуу улс төрийн нам дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

а) Улс төрийн нам нь дор хаяж ОХУ-ын Холбооны талтай тэнцэхүйц бүс нутгийн салбартай байх ёстой бөгөөд мөн нэг бүс нутагт тухайн улс төрийн намын гагцхүү нэг салбар байгуулж болно;

б) Улс төрийн нам нь энэхүү хуулийн 23 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт⁴⁰ заасан шаардлагыг харгалзан, дор хаяж таван

³⁷ Федеральный закон “О политических партиях” от 11.07.2001 N 95-ФЗ // Оросын Холбооны Улсын 2001 оны 7-р сарын 11-ний өдрийн № 95 “Улс төрийн намуудын тухай” хууль URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_32459/.

³⁸ Закон СССР от 09.10.1990 N 1708-1 (с изм. от 19.05.1995) “Об общественных объединениях” // Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын 1990 оны 10-р сарын 9-ний өдрийн № 1708-1 “Олон нийтийн холбооны тухай хууль”, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_1883/ [Сүүлд үзсэн: 2022.12.20].

³⁹ ОХУ-ын “Улс төрийн намуудын тухай хуулийн” 3 дугаар зүйл. (Улс төрийн намын тухай ойлголт болон түүний бүтэц).

⁴⁰ ОХУ-ын 2001 оны 7-р сарын 11-ний өдрийн № 95 “Улс төрийн намуудын тухай” хуулийн 23 дугаар зүйл. (Улс төрийн намын гишүүнд элсэх). ОХУ-ын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна. Улс төрийн намын гишүүн нь тухайн улс төрийн намын зөвхөн нэг бүс нутгийн салбарын гишүүн байж болно.



зуун гишүүнээс бүрдэх ёстой. Улс төрийн намын дотоод журамд улс төрийн намын бүс нутгийн салбарын гишүүдийн тооны доод хэмжээний талаарх шаардлагыг тогтоож болно;

в) Улс төрийн намын удирдах болон бусад байгууллагууд, түүний бүс нутгийн салбарууд болон бусад бүтэц нэгжүүд нь ОХУ-ын нутаг дэвсгэрт байрлах ёстой.

ОХУ-ын "Улс төрийн намын тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу улс төрийн намыг төрийн байгууллагуудын болон албан тушаалтнуудын зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй үүсгэн байгуулах бөгөөд улс төрийн нам үүсгэн байгуулах их хурлаар үүсгэн байгуулж болно.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар улс төрийн нам болон түүний бүс нутгийн салбаруудыг улсын бүртгэлд бүртгүүлсэн болохыг хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд түүний талаар бичилт хийснийг баталгаажуулсан баримт бичиг батална.

Түүнчлэн, ОХУ-ын Хууль зүйн яам жил бүрийн 1-р сарын 1-ний байдлаар улс төрийн нам болон түүний бүс нутгийн салбар бүрийг бүртгэсэн огноог харуулсан жагсаалт, улс төрийн нам, түүний бүс нутгийн салбаруудын жагсаалтыг бүх Оросын тогтмол хэвлэлд нийтлэх ба улс төрийн намын дотоод журам болон хөтөлбөрийн эх бичвэрийг олон нийтийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний тусгай цахим хуудаст байршуулна.

Улс төрийн нам эсвэл түүний бүс нутгийн салбарыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан эсхүл зайлсхийсэн тохиолдолд эс зөвшөөрч **шүүхэд давж заалдах журмаар гомдол гаргаж**

болох бөгөөд гомдол гаргасан өдрөөс хойш тус нэг сарын дотор шүүх хянан хэлэлцэнэ.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлэгт ЕХ-ны гишүүн улсууд болон эрх зүйн өндөр хөгжилтэйд тооцогддог нийт 17 улсын зохицуулалтыг тухайлан судаллаа.

Ингэхэд тус 17 улсын 10 улсад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага (6-д нь *Дотоод хэргийн яам*, 2-т нь *Хууль зүйн яам*, 2-т нь *Хуулийн этгээдийн бүртгэлийн газар*), 6 улсад шүүх эрх мэдлийн байгууллага (4-т нь анхан шатны буюу хотын, дүүргийн шүүх, 2-т нь Үндсэн хуулийн шүүх), үлдсэн 1 улсад сонгуулийн төв байгууллага буюу Сонгуулийн хороо тус тус бүртгэж байна. Ингэхдээ Монгол Улстай адил "пост-социалист" улсуудын хувьд Дотоод хэргийн яам эсхүл Хууль зүйн яам нь улс төрийн намын бүртгэлийг хариуцаж байгаа нь ажиглагдав.

Дээрх 17 улсын дотор **Дээд шүүх нь улс төрийн намын бүртгэлийг хариуцдаг нэг ч улс байхгүй** байна. Харин Дээд шүүх нь гагцхүү улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг давж заалдах журмаар шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр (*Болгар, Чех, Словак*) улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх харилцаанд оролцож байх юм.

Түүнчлэн Дээд шүүхэд бус Захиргааны хэргийн анхан шатны шүүх эсхүл Давж заалдах шатны шүүх (*Испани, Кипр, Латви, Польш, Румын*)-д улс төрийн намын бүртгэлийг давж заалдах журмаар шийдвэрлэх чиг үүргийг харьяалуулсан хувилбар, эсхүл Үндсэн хуулийн шүүх, түүний нийт шүүгчийн хуралдаан



(Эстони, Ангол)-д давж заалдах гомдол гаргаж болохыг хуульчилсан хувилбар тус тус байна.

ХОЁР. УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсад 1990 оноос өмнө нэг намын тогтолцоо үйлчилж ирсэн бөгөөд олон намын тогтолцоо хөгжих эрх зүйн үндэслэл 1990 онд буюу Ардын Их Хурлаас Улс төрийн намуудын тухай хуулийг баталснаар⁴¹ тавигджээ. Тус хуулиар улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх чиг үүргийг **УДШ-д хариуцуулсан.**

Тодруулбал, БНМАУ-ын Улс төрийн намуудын тухай хуулийн 6 дугаар зүлд “Намыг бүртгүүлэх тухай ирүүлсэн материалыг Монгол Улсын Дээд шүүх хянан үзээд намын дүрэм, мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд нийцэж байвал 21 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэнэ. Намыг бүртгэсэн тухай Монгол Улсын Дээд шүүх албан ёсоор зарлана.

Хэрэв Монгол Улсын Дээд шүүх намыг бүртгэхээс татгалзвал шийдвэртээ тодорхой үндэслэлийг заана. Бүртгэгдсэн нам хуулийн этгээд болно. ... Нам тэмдэг, мөрийн хөтөлбөртөө нэмэлт, өөрчлөлт оруулбал түүнийг Монгол Улсын Дээд шүүхэд 7 хоногийн дотор бүртгүүлнэ” гэж тус тус заасан.

Чухам юуны учир улс төрийн нам бүртгэх чиг үүргийг өөр байгууллагад бус УДШ-д хариуцуулсныг 1990 оны дээрх хуулийн үзэл баримтлал, тэмдэглэлд тодорхой дурдаагүй байх боловч дараах агуулгыг хуулийн үзэл баримтлалд тусгажээ⁴²:

⁴¹ 1990 оны “Улс төрийн намуудын тухай хууль”, <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&active=1&page=1&sort=enacteddate&page=1> [Сүүлд үзсэн: 2022.12.14]

⁴² Архивын ерөнхий газрын Үндэсний төв архиваас судалгааны хүрээнд хуулбарлан авсан хуулийн үзэл баримтлалын хэсэг. Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль, түүнд холбогдох баримт, II боть, 172 дахь тал.



Үндэсний төв архивд хадгалагдаж байгаа 1990 оны Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хуулийн үзэл баримтлал

"... Хуулийн төсөлд зааснаар аливаа улс төрийн намыг БНМАУ-ын Үндсэн хуульд заасны дагуу **ардын төрийн зүгээс хүлээн зөвшөөрч улсын бүртгэлд БНМАУ-ын Дээд шүүх бүртгэх журмыг** тогтоож байна. Намыг бүртгэх журмыг хуульчлан тогтоомж байгаа нь намыг төрийн зүгээс хуулийн хамгаалалтад авч намуудын үйл ажиллагааны эрх тэгш байдлыг хангах, нийгэмд эзлэх байр сууриа тодорхойлох, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах өргөн бололцоог олгох юм.

БНМАУ-ын Дээд шүүх намыг бүртгэхдээ:

Нэг. Намын удирдагчид намыг бүртгүүлэхээр ирүүлсэн материал, тухайлбал намын бүтэц, нэр, зохион байгуулалт, батлагдсан дүрэм, мөрийн хөтөлбөр, 451-ээс доошгүй гишүүний бүртгэл, хөрөнгийн тухай мэдээг хянан шалгана.

Хоёр. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр нь БНМАУ-ын Үндсэн хууль, улс төрийн намуудын тухай хууль, бусад хуульд хэрхэн нийцэж байгааг хянан үзнэ.

Энэ бүхэн нь намыг бүртгэх хууль зүйн үндэслэл болно.

БНМАУ-ын Дээд шүүх дээр дурдсан байдлыг хянан үзээд, намыг бүртгэх нь хуульд нийцэж байвал тухайн намыг улсын бүртгэлд бүртгэж, энэ тухай шийдвэр гаргана. Хэрэв намыг бүртгэх хууль зүйн үндэслэл бүрдээгүй гэж үзвэл Дээд шүүх намыг бүртгэхээс татгалзаж болно. Тэгэхдээ намыг бүртгэхээс ямар үндэслэлээр татгалзаж байгаагаа Дээд шүүх шийдвэртээ тодорхой зааж өгөх үүрэгтэй гэж төсөлд заасан байна. ..."

"... Төсөлд зааснаар нам БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчсөн буюу дүрэм, мөрийн хөтөлбөрөөсөө гажсан нь нотлогдвол БНМАУ-ын Дээд шүүх уг зөрчлийг арилгахыг шаардах буюу ноцтой гэж үзвэл намын үйл ажиллагааг зогсоох эрхтэй юм. Намын үйл ажиллагааг зогсоовол Дээд шүүх энэ тухай нийтэд мэдээлнэ. Харин ... улс эх орон, ард түмний эсрэг үйл ажиллагаа явуулсан намыг БНМАУ-ын Дээд шүүхээс тараахаар заасан юм. Ийнхүү тараасан намын хөрөнгийг улсын орлого болгож намыг тараасан тухай нийтэд мэдээлэхээр зааж байна ..."

Ийнхүү УДШ-д намын бүртгэлийг хариуцуулсан 1990 оны хуулиас хойш 15 жилийн дараа буюу 2005 онд УИХ "Улс төрийн намын тухай хууль"-ийг шинэчлэн батлахдаа⁴³ улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх **УДШ-ийн чиг үүргийг хэвээр үлдээсэн**. Тус 2005 оны хуульд 2015, 2018 онд тус тус нийт 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан⁴⁴ байх боловч Хуулийн этгээдийн улсын

бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан эш татсан хуулийн холбогдох зүйл, заалтын тоог өөрчилснөөс агуулгын хувьд өөрчлөөгүй байна.

Түүнчлэн, үе үеийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003, 2015, 2018) холбогдох зохицуулалт болох Улсын дээд шүүх намыг бүртгэх зохицуулалтыг агуулгын хувьд хэвээр хуульчилж иржээ.

Мөн үе үеийн Шүүхийн тухай хуульд (1993, 2002, 2012) УДШ-ийн намын бүртгэл хөтлөх чиг үүргийг заагаагүй боловч 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийн 25.8.8-д "улс төрийн намын бүртгэл хөтлөх" нь УДШ-ийн **шүүн таслах ажиллагаанаас бусад**

⁴³ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2005) №7.

⁴⁴ 2015 оны Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "14.1-д" гэснийг "15.1-д" гэж, 9.2 дахь хэсгийн "14.2-т" гэснийг "15.2-т" гэж, 9.3 дахь хэсгийн "16.1-д" гэснийг "17.1-д" гэж тус тус өөрчилсүгэй" гэжээ.

2018 оны Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "15.1" гэснийг "14.1" гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн "15.2" гэснийг "14.2" гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн "17.1" гэснийг "16.1" гэж тус тус өөрчилсүгэй" гэжээ.



асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахаар хуульчилсан. Ингэхдээ мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар УДШ нийт шүүгчийн хуралдаанаар улс төрийн намын бүртгэл хөтлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргахаар заасан нь шинэ зохицуулалт болсон. Ингэхдээ тус чиг үүргийг нийт шүүгчийн хуралдаанд яагаад хариуцуулах болсны учрыг хуулийн хэлэлцүүлгийн тэмдэглэлд дараах байдлаар тусгажээ:

2021 оны Шүүхийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийн Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл⁴⁵

С.Бямбацогт: ... 25.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 25.6.11 дэх заалт нэмэх. 25.7.8.Улс төрийн намын бүртгэл хөтлөх гэсэн ийм заалтыг нэмье гэсэн улсын дээд шүүхэд харьяалал. Нямбаатар гишүүн санал гаргасан байна. Нямбаатар гишүүн саналаа тайлбарлая

Х.Нямбаатар: Одоо улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэж байгаа дүрмийн өөрчлөлтийг бүртгэж байгаа. Ингэхдээ улсын дээд шүүхийн иргэний танхим дээр энэ хэрэг харьяалагдаж байгаа. Өөрөөр хэлбэл бүртгэл. ... олон намын тогтолцоо бол энэ Монгол Улсад ардчилал түүний үнэт зүйл орших үндсэн баталгаа. Аль болох энэ улс төрийн намуудыг улс төрийн зорилгоор нэр усыг нь өөрчилдөг жижиглэдэг хагалдаг бутаргадаг магадгүй бүртгэхгүй байх гэдэг бол өөрөө ардчиллын үнэт зүйлд халтай. Тийм учраас улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар улсын дээд шүүхийн улс төрийн намуудыг бүртгэдэг болъё. 2028 оноос эхлээд улс төрийн намуудын тухай хууль шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу өөрчлөлт орж бүртгэгдэж явна. Тэгэхээр энэ саналыг та бүхэн дэмжиж өгөөч. **Илүү их олуулаа шийдэж байж хараат бус байдлаар улс төрийн нөлөөлөл хань хамаарал багатай байдлаар энэ шийдвэрийг гаргаж бүртгэж авна** гэсэн ийм зүйл байгаа юм. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан бол улс төрийн намын бүртгэл хийнэ. Одоо энэ хуулиар мөн дээд шүүхийн тайлбар хийнэ. Мөн дээр нь нэмээд улсын дээд шүүхийн томилгоонуудыг хийдэг ийм том чиг үүргүүд ингээд өргөжиж нэмэгдэж байгаа гэдгийг бас давхар хэлье. Тэгэхээр энэ дээр та бүхэн дэмжиж өгөөрэй.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн саналаа тайлбарлаж хэллээ. 25.6 дахь хэсэг. 25.7.8-д улс төрийн намын бүртгэл хөтлөх санал гаргасан Нямбаатар гишүүн. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүний саналаар энэ **санал дэмжигдлээ**. Ганбат гишүүн дэмжсэн гэж байна шүү ..."

Шүүхийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийн УИХ-ын намын ээлжит чуулганы 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэл⁴⁶

Г.Занданшатар: ... Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх саналын томьёоллоор санал хураалт явуулна.

7.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.8 дахь заалт нэмэх:

"25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	8
Бүгд:	62

87.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Х.Нямбаатар сайд аа. Цаашдаа улсын төрийн намын бүртгэлийг Сонгуулийн ерөнхий хороон дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нөгөө сонгогчдын тоотой уялдаж байгаа учраас сонгогчдын тоо Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн газар л байдаг учраас уг нь тийшээ л. Бусад дийлэнх улс тийм л юм билээ. Дээд шүүх бүртгэдэггүй. Сонгуулийн хороон дээрээ л бүртгэдэг юм билээ"

⁴⁵ Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, 177 дахь тал, <https://www.parliament.mn/nn/13622/> [Сүүлд үзсэн: 2023.01.09]

⁴⁶ Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, 6 дахь талд, <https://www.parliament.mn/nn/13580/> [Сүүлд үзсэн: 2023.01.09]



Дээрхээс үзвэл "... илүү их олуулаа шийдэж байж хараат бус байдлаар улс төрийн нөлөөлөл хань хамаарал багатай байдлаар энэ шийдвэрийг гаргаж бүртгэж авна ..." гэсэн саналыг Хууль зүйн байнгын хорооны хэлэлцүүлэгт дэмжиж, улмаар УИХ-ын чуулганд дэмжсэнээр улс төрийн намыг бүртгэлийг нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэж, тогтоол гаргадаг байхаар хуульчилсан байна.

Ийнхүү өнөөдрийн байдлаар Монгол Улсад улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх асуудлыг **УДШ хариуцахдаа Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн тухай хуулийн** холбогдох зохицуулалтыг дагаж мөрдөж, хэрэглэж байна. Ингэхдээ Улс төрийн намын тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд улс төрийн намыг бүртгэхэд тавих шаардлагыг хуульчилсан бол Шүүхийн тухай хуулиар улс төрийн намыг бүртгэх нь шүүн таслах ажиллагаанаас бусад бүрэн эрх болохыг хуульчилж, нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэхийг заасан.

Цаашилбал, УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны 2021.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор⁴⁷ **"Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"**-ыг баталж, улс төрийн намын бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулжээ. Гэсэн хэдий ч дурдсан хууль тогтоомжид улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлаар гомдол гаргах боломжтой эсэх, хэрхэн,

хаана хандах талаар зохицуулаагүй тул тус асуудал **тодорхойгүй үлдсэн байна.**

Онолын хувьд намын бүртгэлтэй холбоотой асуудлыг гүйцэтгэх эрх мэдлийн аль нэг байгууллагад хариуцуулах нь **улс төрийн нөлөөнд автах эрсдэлтэй** гэж үзэж хараат бус, бие даасан шинж бүхий байгууллагад хариуцуулах хандлагатай байдаг⁴⁸ бөгөөд намд Үндсэн хуулийн шүүх, намыг бүртгэсэн шүүх хяналт тавьж байх нь улсын аюулгүй байдал, Үндсэн хуульд байгууллагын үүднээс зүй ёсны хэрэг. Энэ нь нам Үндсэн хуулийн дагуу ажиллаж байгаа эсэхийг хэмжих, улс төрийн зохиомол хямрал бий болгохгүйн тулд хэрэгтэй байдаг⁴⁹ болохыг судлаачид тэмдэглэжээ.

Иймд цаашид улс төрийн намын бүртгэлийн УДШ-ээс өөр байгууллага бүртгэдэг болох эсэх, улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлаар давж заалдах гомдол гаргадаг болох, түүнийг хянан үзэх байгууллага зэргийг ул суурьтай хэлэлцүүлэх, шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Улс төрийн намын бүртгэлтэй холбогдох асуудлаар шүүхэд шийдвэрлэсэн маргаан байгаа эсэхийг сүүлийн зургаан жилээр хайхад гагцхүү 2022 онд шийдвэрлэсэн дараах маргаан байна:

⁴⁷ Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт, https://www.supremecourt.mn/files/202211/0_1671524555.pdf [Сүүлд үзсэн: 2022.12.15]

⁴⁸ Б.Эрхэмбаяр, "Улс төрийн намын бүртгэл ба түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх асуудал" Legaldata.mn (2012 он), 2 дахь тал, <https://legaldata.mn/buteel/pdf?id=23>.

⁴⁹ Б.Чимид, Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, нэгдүгээр дэвтэр (Улаанбаатар: 2008), 200 дахь тал.



Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 3986 дугаар захирамж⁵⁰, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 462 дугаар тогтоолтой⁵¹ хэрэг:

Нэхэмжлэлийн шаардлага: “А” намаас Улсын дээд шүүхэд холбогдуулан “Улсын дээд шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн нийт шүүгчийн хуралдаанаараа “А” намын дүрмийн нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн нь хууль бус болохыг тогтоож, нийт шүүгчийн хуралдааны 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах”-аар маргасан.

Анхан шатны шүүх: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

“Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д захиргааны байгууллагад хамаарах нийтийн эрх зүйн этгээдийг нэрлэн заасны зэрэгцээ 5.3-д бүх шатны шүүх нь хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад шийдвэрийнхээ хувьд захиргааны байгууллагад тооцогдохоор хуульчилсан. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8-д улс төрийн намын бүртгэл хөтлөх нь Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан Улсын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллага бөгөөд тус шүүхийн Монгол Улсын шүүхийн тухай хуулиар эрх олгосон эрхийн хүрээнд гаргасан **нийт шүүгчдийн хуралдааны шийдвэр нь захиргааны акт биш** байна” гэжээ.

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн. Ингэхдээ дараах байдлаар дүгнэсэн байна.

“... Улс төрийн намын дүрэм, мөрийн хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлт нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэхийг хянан бүртгэх хуульд заасан онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлж нийт шүүгчийн хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэсэн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол нь захиргааны акт биш бөгөөд уг тогтоолыг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэл нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны хуульд заасан онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж гаргасан тогтоолд нэхэмжлэл гаргах харилцааг зохицуулаагүй” гэжээ.

Дээрх маргааны хувьд нэхэмжлэгч намаас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлийн асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагааны шийдвэр нь шүүн таслах бусад үйл ажиллагаа буюу захиргааны, тэр дундаа бүртгэлийн чиг үүргийг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа” гэж үзэж нэхэмжлэл гаргасан байх бөгөөд анхан шатны шүүхээс уг асуудал нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан

шийдвэрлэх маргаан биш, УДШ-ийн холбогдох шийдвэр нь захиргааны акт биш гэж үзжээ. Анхан шатны шүүхийн шийдвэрийг Давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн.

Мөн УДШ-ийн цахим бүртгэлд бүртгэсэн намын мэдээллийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлэх талаар маргаан гарсныг шийдвэрлэсэн дараах шийдвэр байна:

⁵⁰ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022.05.06-ны 3986 дугаар захирамж, Захиргааны хэргийн шүүхийн бүртгэл хяналтын нэгдсэн систем.

⁵¹ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022.06.03-ны өдрийн 462 дугаар тогтоол, ЗХДЗШШ-ийн Тогтоолын сан.



Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 4393 дугаар захирамж⁵², Захиргааны хэрийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 459 дүгээр тогтоолтой⁵³ хэрэг:

Нэхэмжлэлийн шаардлага: “А” намаас Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газарт холбогдуулан “1/ Улсын дээд шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 05 дугаар тогтоолоор А намын 2017 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар Их хурлаас батлагдсан “А намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлт”-ийг бүртгэсэн бүртгэл”, Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор “Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд Ц.Т-г А намын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгэснийг хасаж, А намын даргаар бүртгүүлэх С.Э-ийн хүсэлтийг хангахаас татгалзсан”-ыг бүртгэсэн бүртгэл”-ийг тус тус А намын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилтийг хийж өгөх хүсэлтийг шийдвэрлээгүй Улсын дээд шүүхийн Тамгын газрын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоох, 2/ А намын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд дээрх бүртгэлүүдийн бичилтийг хийхийг Улсын дээд шүүхийн Тамгын газарт даалгах”-аар маргажээ.

Анхан шатны шүүх: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

“Улс төрийн намын дүрэм, мөрийн хөтөлбөр, намын хувийн хэрэгт зайлшгүй байх мэдээлэл буюу намын удирдлагад оруулсан өөрчлөлтийн бүртгэлийг хийж, энэ талаар мэдээллийн санд тухайн өөрчлөлтийг Улсын дээд шүүх бүртгэхээр заасан байна.

Дээрх маргаан нь Монгол Улсын дээд шүүхийн хуулиар олгогдсон бүрэн эрхэд хамаарах асуудал байх тул анхан шатны шүүхийн харьяаллын бус гэж үзэж хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй” гэжээ.

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн. Ингэхдээ анхан шатны шүүхийн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд өгсөн дүгнэлтийг учир дутагдалтайг дурдаж, зөвтгөсөн.

“Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт өгөөгүй байна. Нэхэмжлэгчийн тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээс үзвэл нэхэмжлэгчийн маргаж буй бүртгэл, уг бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлээгүй Улсын дээд шүүхийн Тамгын газрын эс үйлдэхүй нь Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд дурдсан захиргааны актын шинжүүдийг агуулахгүй байх тул захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх маргаан биш байна” гэжээ.

Дээрх маргааны хувьд нэхэмжлэгчээс УДШ-ийн цахим бүртгэлд бүртгэгдсэн мэдээллийг намын улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийлгүүлэхээр маргасан байх бөгөөд анхан шатны шүүхээс “Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарна” гэсэн үндэслэлээр “захиргааны хэргийн шүүхийн харьяалсан шийдвэрлэсэн маргаан биш” гэж дүгнэсэн бол давж заалдах шатны

шүүхээс анхан шатны шүүхийн шийдлийг хэвээр үлдээсэн боловч дүгнэлтийг “Улсын дээд шүүхийн Тамгын газрын эс үйлдэхүй нь захиргааны актын шинжийг агуулаагүй” гэж шийдлийн үндэслэлийг нь зөвтгөсөн байна.

⁵² Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022.05.23-ны 4393 дугаар захирамж, Захиргааны хэргийн шүүхийн бүртгэл хяналтын нэгдсэн систем.

⁵³ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022.06.02-ны өдрийн 459 дүгээр тогтоол. ЗХДЗШШ-ийн Тогтоолын сан.



Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 5477 дугаар захирамж⁵⁴, Захиргааны хэрийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 643 дугаар тогтоолтой⁵⁵ хэрэг:

Нэхэмжлэлийн шаардлага: “А” намаас Улсын дээд шүүхийн Тамгын газарт холбогдуулан *Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 05/2945 дугаар А намын улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгох үндэслэлгүй гэсэн шийдвэр хууль бус болохыг тогтоож, дахин гэрчилгээ олгохыг даалгах*”-аар маргасан байна.

Анхан шатны шүүх: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.6-д заасан “...**уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан ... шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байгаа**” гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзжээ.

“...Тус шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 128/ШЗ2021/4393 дугаар захирамжаар А намаас Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасны дагуу хүлээн авахаас татгалзаж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 459 дугаар тогтоолоор захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Нэхэмжлэл гаргагчийн нэхэмжлэлийн шаардлагад дурдагдаж буй үйл баримтыг агуулгын хувьд дээр дурдсан хуулийн хүчин төгөлдөр шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор дүгнэсэн байна”

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн. Ингэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна.

“... 4393 дугаар захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54.1.1-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 459 дүгээр тогтоолоор ... 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан үндэслэлийг зөвтгөж, “... маргаж буй бүртгэл, уг бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлээгүй Улсын дээд шүүхийн Тамгын газрын эс үйлдэхүй нь Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд дурдсан захиргааны актын шинжүүдийг агуулахгүй байх тул захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх маргаан биш” гэж дүгнэсэн байх бөгөөд одоо маргаж байгаа нэхэмжлэлтэй ижил байгаа тул эрх зүйн зарчмын дагуу нэхэмжлэлийн нэг зүйлд хоёр өөр агуулгаар гаргасан гэж үзэх үндэслэлтэй байна” гэжээ.

Нэхэмжлэгч “А” намын өмнө нь гаргасан УДШ-ийн цахим бүртгэлд бүртгэгдсэн мэдээллийг намын улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийлгүүлэх талаарх нэхэмжлэлийн шаардлага нь дээрх нэхэмжлэлийн	шаардлагатай агуулгын хувьд ижил буюу уг үйл баримт нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй талаар нэгэнт дүгнэсэн гэж үзэж хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.
---	--

⁵⁴ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022.07.05-ны өдрийн 5477 дугаар захирамж, Захиргааны хэргийн шүүхийн бүртгэл хяналтын нэгдсэн систем.

⁵⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022.08.11-ний өдрийн 643 дугаар тогтоол, ЗХДЗШШ-ийн Тогтоолын сан.



Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 618 дугаар шийдвэртэй захиргааны хэрэг:⁵⁶

Нэхэмжлэлийн шаардлага: "А" намаас Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргад холбогдуулан "Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд Ц.Т-г А намын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгэснийг хасаж, Улсын Дээд шүүхийн цахим бүртгэлд А намын даргаар бүртгүүлэх С.Э-ийн хүсэлтийг хангахаас татгалзсан гэсэн бүртгэлийг А намын улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийж өгөхөөс татгалзсан амаар гаргасан шийдвэрийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах"-аар маргажээ.

Анхан шатны шүүх: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Ингэхдээ дараах дүгнэлтийг хийжээ:

"Улсын Дээд шүүхийн Тамгын газрын Ц.Т-г А намын даргын үүрэг гүйцэтгэгчээр бүртгэлээс хасаж, А намын даргаар бүртгүүлэх С.Э-ийн хүсэлтийг хангахаас татгалзсан Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоол гарсан гэдгийг А намын гэрчилгээнд бичихээс татгалзсан үйлдэл нь А намын дарга нь хэн болох, тус намыг хэн төлөөлөх эрхтэй болох нь олон нийт, үүний дотор тус намын гишүүн иргэд, түүнчлэн төрийн болон төрийн бус байгууллагуудад тодорхойгүй болгосон, С.Э өөрийгөө намын дарга гэж тодорхойлон намыг төлөөлж эрх зүйн харилцаанд орох боломжийг олгож байгаа эрх зүйн үр дагавар бүхий фактыг бий болгосон байх тул эрх зүйн үр дагавар бүхий **захиргааны акт мөн** гэж үзлээ.

Хуулийн этгээдийн мэдээлэлд хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын нэр хамаарч байгаа бол ийм этгээд байхгүй бол хуулийн этгээдийг гүйцэтгэх удирдлага байхгүй гэдэг мэдээлэл ч бүртгэгдэх ёстой байна.

Улсын дээд шүүхийн цахим сайтад байгаа Улс төрийн намын бүртгэл дэх А намын бүртгэлд төлөөлөх эрхтэй этгээд байхгүй гэх мэдээлэл бүртгэгдсэн нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 10 дугаар зүйлийн 10.1-д заасантай нийцэж байна.

Гэрчилгээ нь цаасан болон цахим хэлбэрээр олгогдох баримт бичиг бөгөөд гэрчилгээний арын нүүрэнд Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл гэсэн хүснэгт гаргаж хүснэгтэд С.Э-г намын даргаар бүртгэснийг тэмдэглэж бичилт хийсэн байгаагаас үзвэл энэ нь цаасан бүртгэлд хамаардаг гэдгийг нотолж байна.

"... улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь мэдээлэл нь цаасан эх хувьтай адил байна" гэж заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн Улсын дээд шүүхийн цахим сайтад байгаа Улс төрийн намын бүртгэл дэх А намын бүртгэлд төлөөлөх эрхтэй этгээд байхгүй гэх мэдээлэл нь цаасан гэрчилгээнд бичигдэх ёстой мэдээлэл мөн байна.

Дээрхээс гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д зааснаас өөрөөр гэрчилгээнд юу бичих, юу бичихгүй байх зохицуулалтыг хуульд тусгаагүй, ямар нэг хориглосон зохицуулалт ч байхгүй байна.

Эндээс үзвэл Улсын дээд шүүхийн хөтөлдөг улс төрийн намын бүртгэлийн цахим хэлбэр бүхий бүртгэлд оруулсан мэдээлэл нь хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт орсон болохыг мэдээлсэн бүртгэл мөн гэж үзэж байна.

Улсын Дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор цахим бүртгэлд бүртгэх гэж заасан нь Дээд шүүхийн шийдвэрийг хуулийн этгээдийн гэрчилгээнд бичиж болохгүй, хориглосон гэх дагаврыг үүсгэсэн шийдвэр биш юм" гэжээ.

⁵⁶ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022.08.24-ний өдрийн 618 дугаар шийдвэр, https://shuukh.mn/single_case/10716?daterange=2022-01-01%20-%202022-12-08&id=1&court_cat=3&bb=1 [Сүүлд үзсэн: 2022.12.12]



Гэтэл өмнөх шийдвэртэй адил агуулга бүхий нэхэмжлэлийн шаардлагыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх **бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн** байх бөгөөд давж заалдах гомдол гаргасны дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсад улс төрийн намын бүртгэлтэй холбогдох харилцааг 1990 оноос эхлэн үе үеийн холбогдох хуулиар УДШ-д хариуцуулж ирсэн. Ингэхдээ өнөөдрийн байдлаар Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалт болон УДШ-ийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолын хавсралтаар баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-аар тус тус улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх харилцааг зохицуулж байна.

Гэсэн хэдий ч дээрх хууль тогтоомжид улс төрийн намын бүртгэл хөтлөх асуудлаар гаргасан УДШ-ийн шийдвэрийн эрх зүйн байдал (захиргааны акт мөн эсэх), гомдол гаргаж болох эсэх асуудлыг зохицуулаагүй үлдээсэн нь шүүхийн практикт эргэлзээтэй байдал үүсгэж байна. Тодруулбал, сүүлийн зургаан жилд УДШ-ийн улс төрийн намын бүртгэлтэй холбогдох асуудлаар гаргасан шийдвэрийг шүүх хянан үзсэн тохиолдол бараг байгаагүй бөгөөд гагцхүү 2022 онд “А” намаас хэд хэдэн удаа нэхэмжлэлийн шаардлага холбогдох асуудлаар гаргажээ.

Ингэхдээ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Давж заалдах шатны шүүх УДШ-ийн холбогдох асуудлаар гаргасан шийдвэрийг **захиргааны акт биш** гэж үзэж шийдвэрлэж ирсэн боловч хамгийн сүүлд буюу Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022.08.24-ний өдрийн шийдвэрээр “А” намын нэхэмжлэлийн шаардлага дахь шийдвэрийг **захиргааны акт мөн** гэж бүхэлд нь хангажээ.

Иймд цаашид улс төрийн намын бүртгэлийг хариуцах УДШ-ийн чиг үүргийг эргэн харах, тус асуудлаар гаргасан шийдвэрийг хянуулах эрх зүйн боломж бий болгох зэрэг шаардлага үүсэж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад улс төрийн намын бүртгэлтэй холбогдох харилцааг 1990 оноос эхлэн үе үеийн холбогдох хуулиар УДШ-д хариуцуулж ирсэн нь нийтийн захиргааны байгууллагад аливаа хэлбэрээр нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох зэргээс зайлсхийх зорилгоор төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад бус УДШ-д хариуцуулсан гэж хэлж болох юм.

Гэсэн хэдий ч харьцуулсан судалгааны хүрээнд Монгол Улстай адил **дээд шүүх нь** улс төрийн намыг бүртгэдэг, бүртгэл хөтөлдөг **улс нэг ч байхгүй байна**. Гагцхүү Португал Улсад дээд шүүх нь бүртгэдэг байсан боловч 2003 оноос эхлэн Үндсэн хуулийн шүүх улс төрийн намыг бүртгэх болжээ.

Харьцуулсан судалгаанд Улс төрийн намын тухайлсан хуультай нийт 17 улсын холбогдох зохицуулалтыг нэг бүрчлэн



судалсан бөгөөд ихэвчлэн **Дотоод хэргийн эсхүл Хууль зүйн яам**, эсхүл **анхан шатны шүүх** нь улс төрийн намыг бүртгэх, бүртгэл хөтлөх чиг үүргийг гүйцэтгэж байна. Харин улс төрийн намын тухай хуульгүй улсад гагцхүү сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх замаар Сонгуулийн төв байгууллага буюу Сонгуулийн хороонд бүртгүүлдэг туршлага байна.

Харьцуулсан судалгааны хүрээнд судалсан улсуудад улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуудлаар давж заалдах журмаар гаргасан гомдлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүх зэрэг байгууллага байх бөгөөд давж заалдах журмаар шийдвэрлэсэн шийдвэр нь эцсийн шийдвэр байхыг хуульчилжээ.

Ялангуяа **Монгол Улстай адил пост-социалист улсууд (ОХУ, Литва, Латви, Словени, Словак, Чех, Болгар, Польш, Румын, Эстони)**-д 1990 оноос хойш олон намын тогтолцоог бий болгохдоо улс төрийн намын бүртгэлийг **Дотоод хэргийн яам, Хууль зүйн яам эсхүл анхан шатны шүүх** (хотын эсхүл дүүргийн)-д хариуцуулан хуульчилсан байна. Харин дээд шүүх эсхүл захиргааны хэргийн шүүх, давж заалдах шатны шүүхүүдэд улс төрийн намын бүртгэлтэй холбогдох асуудлаар гагцхүү давж заалдах журмаар хандаж болохоор зохицуулсан.

Иймд цаашид улс төрийн намын бүртгэлийг УДШ-д хариуцуулсан өөр улсад байдаггүй Монгол Улсын зохицуулалтыг эргэн харах замаар боловсронгуй болгох, улс төрийн

намын бүртгэлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэсэн шийдвэрийг давж заалдах эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Улс төрийн намуудын тухай хууль. (1990).
- Монгол Улсын “Улс төрийн намын тухай хууль” (2005)
- Монгол Улсын “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль” (2018)
- Монгол Улсын дээд шүүхийн Бүгд хурлын 1992 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар “Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль ... -ийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” тогтоол.
- Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар “Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоол.

Монгол хэлээр:

- Б.Чимид. *Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Нэгдүгээр дэвтэр* (Улаанбаатар: 2008).

Гадаад хэлээр:

- European Parliament, *Criteria, Conditions, and Procedures for Establishing a Political Party in the Member States of the European Union* (European Union: 2012), https://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_



- ET(2012)462512_EN.pdf
- Дани Улсын Сонгуулийн тухай хууль, <https://elections.im.dk/parliament-elections/folketing-parliamentary-elections-act>
 - Ирланд Улсын Сонгуулийн тухай хууль, <https://www.irishstatutebook.ie/eli/2001/act/38/enacted/en/pdf>
 - Франц Улсын Сонгуулийн тухай хууль, https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070239/LEGISCTA000006115455/#LEGISCTA000029930685
 - Болгар Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.partylaw.leidenuniv.nl/party-law/4d4150e9-7860-4c62-bf6b-35df5bda7d64.pdf>
 - Чех Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.psp.cz/en/docs/laws/1991/424.html>
 - Эстони Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.riigiteataja.ee/en/eli/513042015011/consolide>
 - Испанийн Улс төрийн намын тухай хууль, https://adsdatabase.ohchr.org/IssueLibrary/SPAIN_Organic%20Law%206-2002%20on%20political%20parties.pdf [Сүүлд үзсэн: 2023.01.18]
 - Кипр Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://aceproject.org/ero-en/regions/europe/CY/cyprus-the-political-parties-law-2012/view>
 - Jānis Ikstens, "Party Regulation in Latvia: A Relative Success", *Working Paper Series on the Legal Regulation of Political Parties*, 2013, No. 37, <http://www.partylaw.leidenuniv.nl/uploads/wp3713.pdf>
 - Литва Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/2a2faf104f7811eba1f8b445a2cb2bc7?jfwid=i3h7wu63e>
 - Австри Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://advocatetamoy.com/2020/11/18/political-parties-act-2012-austria/>
 - Польш Улсын Улс төрийн намын тухай хууль, https://europam.eu/data/mechanisms/PF/PF%20Laws/Poland/Poland_Law%20on%20political%20parties_1997_amended2016_pol.pdf
 - Португал Улсын Улс төрийн намын тухай хууль, <http://www.parliament.am/library/Political%20parties/Portugal.pdf>
 - Румын Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://www.partylaw.leidenuniv.nl/party-law/4e2d4e07-e470-4396-ba64-08e084e5412d.pdf>
 - Словени Улсын Улс төрийн намын тухай хууль, <https://europam.eu/data/mechanisms/PF/PF%20Laws/Slovenia/>



- Slovenia%20PoIS%201994%20amended2014%20SLV.pdf
- Словак Улсын Улс төрийн намын тухай хууль,
 - http://www.sze.hu/~smuk/Nyilvanossag_torvenyek_CEE/Valasztasi_szabalyok/Slovakia%20Act%20on%20Political%20Parties_2005_en.pdf
 - Финланд Улсын Улс төрийн намын тухай хууль,
 - https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1969/en19690010_19920653.pdf
 - Political Parties, Elections and Referendums Act 2000,
 - <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/part/II?timeline=false>
 - Political Parties, Elections and Referendums Act 2000,
 - <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/part/II?timeline=false>.
 - The Electoral Commission in the United Kingdom,
 - <https://www.electoralcommission.org.uk/>.
 - Registration of Political Parties Act 1998,
 - <https://www.legislation.gov.uk/ukpga/1998/48/contents>.
 - Federal Election Campaign Laws, <https://www.fec.gov/resources/cms-content/documents/feca.pdf>.
 - Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>.
 - Political Parties Act, <https://germanlawarchive.iuscomp.org/?p=235>.
 - Act on the Federal Constitutional Court,
 - https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Downloads/EN/Gesetze/BVerfGG.pdf?__blob=publicationFile&v=1.
 - Constitution of the Republic of Angola,
 - <https://ecn1.org/sites/default/files/files/2021/AngolaConstitution.pdf>.
 - Political Parties Law <https://aceproject.org/ero-en/regions/africa/AO/zz%20Law%20No%202%2005%201%20of%20July.pdf>.
 - Федеральный закон "О политических партиях" от 11.07.2001 N 95-ФЗ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_32459/.
 - Положение о Федеральной налоговой службе (утв. постановлением Правительства РФ от 30 сентября 2004 г. N 506) https://base.garant.ru/12137054/#block_11012.
 - Закон СССР от 09.10.1990 N 1708-1 (с изм. от 19.05.1995) "Об общественных объединениях" http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_1883/.



Цахим эх сурвалж:

- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - <https://legalinfo.mn/mn>.
- ИБУИНХУ-ын Сонгуулийн Хорооны цахим хуудас - <https://www.electoralcommission.org.uk/>.
- АНУ-ын Холбооны Сонгуулийн Комиссын цахим хуудас - <https://www.fec.gov/>.
- German Law Archive - <https://germanlawarchive.iuscomp.org/>.
- ОХУ-ын хууль тогтоомжийн сан - <http://www.consultant.ru>.

ХЯТАДЫН ЦАХИМ ШҮҮХИЙН ХУВЬСГАЛ¹

/China e-justice revolution/

Зохиогч: **Жухао Ван**²

Орчуулагч: **З.Гэрэлмаа (LL.M.)**³

- I. Institute structure
- II. Institute functions
- III. Judicial Training Centre
- IV. Judicial Research Centre
- V. Information Centre
- VI. The Non-standing Committee of the Training Programme
- VII. “Mongolian State and Law” journal

¹ “Duke Law” их сургуулийн Bolch Judicial Institute-ээс эрхлэн гаргадаг “Judicature” сэтгүүлийн 2021 оны Vol.105 No.1 дугаарт нийтлэгдсэн өгүүллийг орчуулан хүргэж байна. Та бүхэн англи хэл дээрх хувилбарыг https://judicature.duke.edu/wp-content/uploads/2021/04/EJustice_Spring2021.pdf холбоосоор нэвтрэн унших боломжтой. Энэхүү орчуулгатай холбоотой санал, шүүмжээ gerelmaa24@gmail.com цахим шуудангаар ирүүлнэ үү.

² Хятадын Улс төрийн шинжлэх ухаан, хууль зүйн сургуулийн дэд профессор, Нортвестерн Притцер Хууль зүйн сургуулийн докторант.

³ Улсын дээд шүүхийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ахлах шинжээч.



ХЯТАДЫН ЦАХИМ ШҮҮХИЙН ХУВЬСГАЛ

З.ГЭРЭЛМАА, Улсын дээд шүүхийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ахлах шинжээч

Цахим технологийн үр нөлөөгөөр шүүхэд хандах болон шүүхийн нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх арга замууд эрчимтэйгээр өөрчлөгдөж байна. Уламжлалыг баримтлагч, хэм хэмжээ, хязгаарлалт их Хятадын нийгэм л гэхэд шүүн таслах үйл ажиллагаандаа цахим технологийг нэвтрүүлэх ажлыг шуурхайлан зохион байгуулж ирлээ. Энэ төрлийн өөрчлөлт, хөгжил эрчимтэй явагдаж байгаагаас шүүхийн систем дотор ажиллаж байгаа хүн ч хөгжлийг нь гүйцэхгүй, нийт цар хүрээг нь гүйцэт сайн харж амжихгүй байх нөхцөл бүрдэх боломжтой болсон. Энэ өгүүлэгээр дамжуулан Хятадын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь цахим шүүхийн хөгжлийн сүүлийн үеийн голлох 3 өөрчлөлтийн талаар танилцуулъя. Үүнд: цахим нотлох баримт болон блокчэйний хэрэглээ, үндэстэн даяарх Ухаалаг шүүх төсөл болон интернэт шүүх байгуулагдсан тухай асуудал багтана.

Цахим технологиуд дэлхийг гүн гүнзгий өөрчилж байгаа бөгөөд шүүхийн үйл ажиллагаанд ч энэ өөрчлөлт нөлөөлж байна. Цахим шүүн таслах ажиллагааг хөгжүүлэх буюу ил тод, үр дүнтэй, шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд цахим технологийг ашиглах нь

аливаа шүүхийн тогтолцоог шинэчлэхэд зайлшгүй шаардлагатай болсон. Сүүлийн жилүүдэд Ерөнхий шүүгч Жоу Чيانгийн удирдлага дор Ардын дээд шүүх Хятад даяар иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажиллагаанаас эхлэн шүүх тогтолцоог аажимдаа бүхэлд нь цахимжуулахад анхаарч ажиллаж байна.¹ Энэ мэт эрчимтэй бөгөөд огцом өөрчлөлт Хятадад тохиож байгаагүйгээс гадна дэлхийд ч сонин үзэгдэл тул энэ асуудлыг гүнзгийрүүлэн судаллаа.

ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ БА "ШҮҮХ ЗАСАГЛАЛ + БЛОКЧЭЙН"

Өнгөрсөн арванд Хятадын шүүхийн цахимжилтад гарсан хамгийн томоохон өсөлтүүдийн нэг нь 2012 оныг хүртэл үл хүлээн зөвшөөрөгдөж байсан цахим нотлох баримтыг зөвшөөрч, ашиглаж эхэлсэн явдал байлаа. Шүүгч хүчинтэй гэж үзвэл аливаа нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөг АНУ-ын шүүхээс ялгаатай нь Хятадын шүүхүүд зөвхөн тодорхой тогтоосон ангилалд багтах тохиолдолд нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөг. Хятадад 1) баримтат нотлох баримт, 2) бодит нотлох баримт, 3) дуу

¹ Интернэт шүүхээс бусад зүйлд дурдсан олон үйл явдал нь Хятад дахь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа энэ нийтлэлийн анхаарлын гадна байгаа юм.



дүрсний материал, 4) гэрчийн мэдүүлэг, 5) талуудын мэдүүлэг, 6) шүүх эмнэлгийн дүгнэлт, 7) мөрдөн байцаалтын ажиллагааны тэмдэглэл гэсэн долоон төрлийн нотлох баримтыг л зөвшөөрдөг байжээ. Цахим гэрээний "өгөгдлийн цахим текст"²-д цахим нотлох баримтын эх загвар байдаг ч Хятадад цахим нотлох баримтыг бие даасан, хууль ёсны нотлох баримт гэж албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй байв. ³Харин ч талуудын маргааны нэг сэдэв байсаар ирсэн бөгөөд "баримтат нотлох баримт" эсхүл "дуу авиа бүхий нотлох баримт"-д тооцох уу? Ер нь шүүх ажиллагаанд ашиглаж болох юм уу? гэх зэрэг олон нээлттэй асуултуудын хариултыг 2012 онд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулан иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд найм дахь төрлийн нотлох баримт буюу "цахим мэдээлэл"-ийг тооцохоор тогтсон.

² "Өгөгдлийн цахим текст"-ийг 1999 онд БНХАУ-ын Гэрээний тухай хууль (1999 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний Конгрессийн Байнгын хорооноос баталж, 1999 оны 10 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн)-ийн 11, 16, 26, 33, 34 дугаар зүйлд цахим гэрээний хууль зүйн үр дагаврыг зохицуулах асуудал тусгагдсан байдаг бол БНХАУ-ын 2004 оны Цахим гарын үсгийн тухай хууль (2004 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Үндэсний Конгрессийн Байнгын хорооноос баталж, 2005 оны 04 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн)-иар өгөгдлийн цахим бичвэрийн бүрдэл, хадгалалт, хяналтын асуудлыг нарийвчлан зохицуулсан.

³ "БНХАУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-ийг хэрэглэх тухай Хятадын Ардын дээд шүүхийн гаргасан Шүүхийн тайлбар №5 (2015) (Ардын дээд шүүхийн Тайлбарын хорооноос 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр баталж, 2015 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн) -ийн 116 дугаар зүйлийг харах. <http://gongbao.court.gov.cn/Details/63ff48da6a9792f8ad1cb65a8b99d1.html>. Ардын дээд шүүхийн тайлбар нь Хятадын хууль тогтоох байгууллага болох Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаас батлагдаагүй тул техникийн хувьд хууль биш юм. Гэхдээ шүүхийн тайлбар нь Хятадад де факто хууль мэт ажилладаг.

3 жилийн дараа Хятадын ардын дээд шүүх энэ шинэ төрлийн нотлох баримтын бүлэгт хамаатуулан ойлгох зүйлсийн талаар тайлбар гаргасан. Шүүхээс 2015 онд гаргасан БНХАУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбарт дурдсанаар "и-мэйл, цахим мэдээлэл солилцоо, цахим харилцааны бүртгэл, блог, микроблог, гар утасны текст зурвас, цахим гарын үсэг эсвэл домэйн нэр г.м тодорхой цахим мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хадгалсан, үүсгэсэн мэдээлэл"-ийг "цахим мэдээлэл"-д тооцно гэжээ. Энэ дүрэм цахим мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэлд хадгалсан дуу болон дүрс бүхий бичлэг⁴ мөн хамаарна. Түүнээс хойш Хятадын шүүхийн практик цахим нотлох баримтыг тайлбарлах тал дээр улам бүр өргөжин тэлж, хүртээмжтэй хандлагыг баримталж ирсэн бөгөөд өнөөгийн шүүх хурлын шүүгчид дижитал хэлбэрээр хадгалж, боловсруулж, дамжуулж байгаа аливаа нотлох баримтыг цахим нотлох баримт гэж үзэж байна.

Улмаар 2015 оноос хойш Хятадын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт гаргах үзэгдэл ихээр нэмэгдсэн. 2018 онд хэлэлцсэн иргэний хэргийн 73%-д нь цахим нотлох баримт агуулагдсан байжээ.⁵ Гэвч шүүх хуралд гаргаж өгсөн цахим нотлох баримтаас зөвхөн 3%-

⁴ Жишээ нь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны цахим мэдээллийн нотлох баримтын талаарх шүүхийн шалгалтын Ханжоугийн интернет шүүхийн дүрэм 2-ыг үзнэ үү [2018] <http://www.xn--fiq8k55ad6inseq1wsth8rle6yb5qck6a.cn/index.php?id=5305>.

⁵ Хөдөлгөөнт нотариатын мэдээллийн төв, Хятадын цахим нотлох баримтын хэрэглээний 2018 оны цагаан ном (2019 оны 3-р сарын 27), https://mp.weixin.qq.com/s/w6q14mcaD_v68bFz61-5HQ.



ийг нь л үндэслэл бүхий гэж үзсэн.⁶ Шүүхээс цахим нотлох баримтад итгэх итгэл маш бага байгаа нь асуудал дагуулж байгаа юм. Хятадын иргэний хэргийн шүүгчид бусад улсын шүүгчдийн нэгэн адил цахим нотлох баримтын эх байдлыг тодорхойлоход хүндрэлтэй тулгарч байгаа юм. Бусад төрлийн мэдээлэлтэй харьцуулахад цахим мэдээллийг өөрчлөх, хувиргахад хялбар байхаас гадна орсон өөрчлөлтийг ялган таних бараг боломжгүй байгаад асуудал байна. Үүний дээр зохиогчийн асуудал ч мөн маргаан дагуулдаг. Хятадын иргэний хэргийн шүүгчид цахим нотлох баримтын эх байдлыг тогтоохдоо аль аль нь алдаа оноотой хоёр төрлийн арга хэрэглэж байна. Эхнийх нь эсрэг талаар нь таниулах, хоёр дахь нь аль нэг талын хүсэлтээр баталгаажуулалт хийлгэх гэсэн арга байна. Маргалдагч талуудын аль нэг нь шүүх хуралдаанд цахим мэдээллийг нотлох баримт хэмээн гаргахад эсрэг тал нь уг нотлох баримтын эсрэг эсэргүүцэл гаргаагүй бол шүүгч ерөнхийдөө тухайн нотлох баримтыг эх баримт хэмээн үзэх боловч оролцогч талууд эсрэг талын гаргаж байгаа баримтыг эх баримт хэмээн зөвшөөрөх нь түгээмэл биш байдаг. Өөр нэг арга нь оролцогч талуудын хүсэлтийн дагуу нотариатын байгууллага цахим нотлох баримтыг тодорхойлох арга байна. Баталгаажуулалтын энэ аргыг шүүгчид харьцангуй найдвартай⁷ хэмээн үзэх боловч энэ аргыг хэрэглэх нь цаг хугацаа, зардал шаардсан процесс

болдог нь энгийн иргэн хэрэглэхэд хүртээмжтэй, тохиромжтой бус гэж үзэж байгаа. Цаашилбал, Хятадын нотариатын байгууллагууд цахим нотлох баримтын агуулга, мөн чанарын үнэн зөвийг бус цахим нотлох баримтыг засах, хадгалахтай холбоотой үйл явцыг баталгаажуулдаг.⁸ Хятадын шүүгчид цахим нотлох баримтын найдвартай байдлын талаар илүү сайн ойлголттой байх хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд цахим нотлох баримтыг баталгаажуулах зарим арга хэрэгслүүд Хятадад бий болсоор байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2012 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу шүүх хуралдаанд техникийн шинжээч дэмжлэг үзүүлж болно гэж заасан.⁹ Цахим нотлох баримтыг баталгаажуулахад тулгарах техникийн төвөгтэй асуудлуудыг танилцуулахад тэдний өмнөөс мэдүүлэг өгөх зорилгоор эдгээр шинжээчдийг шүүхэд ажиллуулна. Хятадын иргэний хэргийн шүүгчид мөн эх байдлыг нь үнэлж, дүгнэлт гаргуулахаар шүүх шинжилгээ хийлгэх саналыг гаргаж болно. Дээрх хувилбарууд нь эх байдлыг тогтоон тодорхойлоход шүүгчдэд боломж олгож байгаа боловч дагалдан гарах нэмэлт зардал (цаг хугацаа болон мөнгө) нь холбогдогч талуудыг энэ процессыг зөвшөөрөхөд хүндрэл учруулж, санхүүгийн боломж тааруу талд нь ашиггүй байдлыг бий болгохоор байна. Эдгээр аргууд мөн баталгаатай биш гэдгийг санах хэрэгтэй бөгөөд

⁶ Пиншин Лю, Баталгаажуулалт ба магадлал: Цахим нотлох баримтыг хүлээн авах, 39 Glob. L. Rev 109 (2017).

⁷ Жишээ нь, Бээжингийн Ардын шүүхээс зарласан янз бүрийн төрлийн хэргийн нотлох баримтын асуудлаарх заалтууд (2001), <https://www.bjac.org.cn/news/view?id=93>.

⁸ Хятадын Нотариатын Холбооноос гаргасан Цахим нотлох баримтын нотариатаар гэрчлүүлэх тухай заавар (2012)-ын 4(3), http://www.lngzw.org/list_b/list_d/487.html.

⁹ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2012)-ийн 79 дүгээр зүйл.



дээрх хоёр аргыг хэрэглэсэн ч шүүх хуралдааныг даргалагч шүүгч эх байдлыг тодорхойлохдоо алдахыг үгүйсгэхгүй.

“Блокчэйн + шүүх засаглал” хэмээх харьцангуй зардал багатай шийдэл Хятадад дэлгэрч байна. Энэ нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд дижитал файлуудыг хадгалах зорилгоор шүүхийн салбараас хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл ажиллуулдаг блокчэйн үйлчилгээг ашиглах явдал юм. Блокчэйн технологи нь анх 2008 онд Биткойн криптовалютын нийтийн гүйлгээний дансны хэлбэрээр хэрэглээнд нэвтэрч эхэлсэн.¹⁰ Хэдий биткойны үр ашгийн талаар олон нийт эргэлзээтэй байдаг ч гэлээ блокчэйны амжилтыг үгүйсгэж болохгүй бөгөөд түүний нөлөө санхүүгийн салбараас хальж, бусад салбарт ч нөлөөлөөд эхэлсэн. Блокчэйн бол тархсан бүртгэлийн технологийн (DLT) жишээ юм: нэг үе тэнгийн сүлжээн дэх бүх оролцогч гишүүдийн (эсвэл “зангилаа”) хооронд хуулбарлаж, хуваалцаж, синхрончлох дижитал мэдээллийн сан гэж тодорхойлж болно.¹¹ Тархсан бүртгэлийн технологи (DLT) нь зөвшилцлийн алгорифмаас шалтгаалдаг: Зангилаа бүр өгөгдлийн сангийн мэдээллийг бие даан баталгаажуулдаг

бөгөөд зөвхөн оролцогч бүх зангилааны зөвшилцөлд хүрсэн тохиолдолд мэдээллийн сан шинэчлэгддэг. Уламжлалт мэдээллийн сангаас ялгаатай нь тархсан данс нь мэдээллийн төвлөрсөн хадгалалт эсвэл удирдлагын функцгүй тул гаднаас халдахад хэцүү байдаг: Халдагчид амжилтад хүрэхийн тулд бүх хуулбарыг нэгэн зэрэг хакердах хэрэгтэй болно. DLT-ийн бүх ерөнхий шинж чанаруудыг эзэмшихээс гадна блокчэйн нь зөвхөн хавсралтад зориулагдсан бүтцийг ашигладаг бөгөөд энэ нь түүний хөндлөнгийн эсэргүүцлийг улам бэхжүүлдэг. Нэг ёсондоо цахим файлыг бүртгэх (эсвэл өгөгдлийн блокыг кодлох)-ээр блокчэйнд илгээсний дараа түүнийг хэш болгодог (өгөгдөл оруулахдаа “хурууны хээ” ашиглаж алгоритмын дагуу үүсгэгддэг тусгай код болох “хэш утга”), дижитал гарын үсэг зурж, өмнөх блокын криптограф хэшийг гинжин хэлхээнд суулгасан нь блокуудыг гинж шиг бүтэцтэй холбодог. Дараа нь шинэ блокыг сүлжээнд тарааж, бүх зангилаа нь шинэчлэгдсэн өгөгдлийг тусгаж, зангилаа бүр блокчэйний бүрэн хуулбарыг агуулдаг. Хамгийн чухал нь цахим файл өөрөө блокчэйн дээр байхгүй, зөвхөн түүний хэш нь энэ гинжин хэлхээний нэг хэсэг байна. Архивлагдсан блокт өчүүхэн төдий өөрчлөлт оруулахад л гинжин дэх хэш кодыг өөрчилж, гинжийг эвддэг тул тараагдсан хуулбарт дахин таарахгүй болох нөхцөл үүсдэг. Гинж тасраагүй/эвдрээгүй бол тухайн блокуудыг хэвийн нөхцөлд байна гэж үзэх юм. Гаднын нөлөөнд үзүүлэх энэ хариу үйлдэл нь блокчэйнийг цахим нотлох баримтыг баталгаажуулах эрэлт хэрэгцээг хангах сонирхолтой шийдэл

¹⁰ Blockchains: The Great Chain of Being Sure about Things, The Economist, Oct. 31, 2015, <https://www.economist.com/briefing/2015/10/31/the-great-chain-of-being-sure-about-things> үзэх.

¹¹ Distributed Ledger Technology: Beyond Block Chain, Их Британийн Засгийн газрын Шинжлэх ухааны асуудлаарх Ахлах зөвлөхийн гаргасан тайлан. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/492972/gs-16-1-distributed-ledger-technology.pdf.

¹¹ Хятадын Ардын Дээд шүүхийн интернэт шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэд хэдэн асуудлын талаарх заалтууд (2018), 11 дүгээр зүйл. <http://www.court.gov.cn/zixun-xiangqing-116981.html>.



болгож байна. Улмаар тодорхой цахим файл (видео бичлэг г.м) нь тодорхой цагт, тодорхой төхөөрөмжөөс хуулагдсан болохыг нотлох бүртгэлийг үүсгэж байгаа юм. Хэрэв тухайн видео бичлэгийг хожим нь шүүхэд нотлох баримт болгон үзүүлбэл шүүх түүний блокчэйн бүртгэлийг ашиглан тухайн нотлох баримтыг үйлдсэнээс хойш ямарваа өөрчлөлт, боловсруулалт орсон эсэхийг баталгаажуулах боломжтой болно.

Хятадын шүүх нэхэмжлэгчийн цахим нотлох баримтаа блокчэйн ашиглан баталгаажуулах хүсэлтийг зөвшөөрсөн анхны хэрэг нь 2018 оны 6 дугаар сард Huatai Yimei болон Daotong Technology хоорондын зохиогчийн эрхэд хамаарах маргаан байсан.¹² Дээрх хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч уг шийдвэрийнхээ талаар “Бид аливаа хэргийг дүгнэн шинжлэхдээ блокчэйн ашиглах эсэх талаар нээлттэй бөгөөд төвийг сахисан байр суурийг баримтлах нь зүйтэй бөгөөд ойлгоход хүндрэлтэй технологи гэдгээр нь шалтаглан хэрэглээнээс хасах, хэрэглэхгүй байх нь зөв шийдэл биш. Зөвхөн блокчэйн зориулж нотлох баримтын стандартыг бууруулж ч болохгүй” гэжээ.¹³ Блокчэйнээс гаргаж авсан эсвэл хадгалсан цахим нотлох баримтыг эх баримт бөгөөд хэрэгт хамааралтай, хууль ёсны гэж баталсан тохиолдолд шүүгч хүчин төгөлдөр нотлох баримт гэж тооцож болох тухай шинэ

заалтыг Хятадын ардын дээд шүүх дээрх үйл явдлаас 3 сарын дараа гаргасан.

Түүнээс хойш “блокчэйн + шүүх засаглал” системийн үйл ажиллагаа эрчимжлээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим нотлох баримт бүрдүүлэх, хадгалах, танилцуулах ажлыг хөнгөвчлөхийн тулд Хятадын шүүхүүд тус улсын томоохон технологийн компаниудтай хамтран өөрсдийн блокчэйн платформуудыг бий болгохоор ажиллаж эхэлсний дотор Ханжоугийн “Шүүхийн блокчэйн” (Алибаба компанитай хамтран 2018 оны 9 сард ашиглалтад оруулсан), Бээжингийн “Balance Chain” (Байду компанитай хамтран 2019 оны 3 сард ашиглалтад оруулсан), Гуанжоугийн “Internet Legal Chain” (JD.com-той хамтран 2019 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан) тус тус багтаж байна. 2019 оны 11 дүгээр сард Хятадын Ардын дээд шүүх “Ардын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн блокчэйн платформ” (буюу Хятадын Ардын дээд шүүхийн блокчэйн)-ыг цахим файлыг блокчэйн хадгалах зорилгоор Хятадын хамгийн том цахим худалдааны компани болох Алибабагийн охин компани Ант финаншлтай хамтран бүтээсэн байна. Энэ үеэрээ Ардын дээд шүүх өөрсдийн блокчэйн платформыг нээн ажиллуулж байгаа шүүхүүд тухайн платформоо үргэлжлүүлэн ашиглаж болох бөгөөд шинээр бүтээхээр төлөвлөж буй шүүхүүд уг төслөө зогсоож Ардын дээд шүүхийн платформыг үргэлжлүүлэн ашиглана гэж мэдэгдсэн.¹⁴

¹² “Wei Wu & Honglian Huang, Hangzhou Интернет шүүх анх удаа блокчэйн нотлох баримтын эрх зүйн үр нөлөөг хүлээн зөвшөөрсөн,” Hangzhou Daily, 2018 оны 6-р сарын 29, https://hangzhou.zjol.com.cn/jrsd/xzjd/201806/t20180629_7654403.shtml.

¹³ Жеймс Гудефрой, “Хятадын шүүхээс хүлээн зөвшөөрсөн блокчэйн нотолгоо,” ROUSE || The сэтгүүл, 2018, <https://www.rouse.com/magazine/news/blockchain-evidence-accepted-by-chinese-court>.

¹⁴ Фан Сяо, “Хятадын шүүхүүд нэгдсэн шүүхийн блокчэйн платформыг байгуулсан тухай,” CHAINNEWS, 2019, <https://www.chainnews.com/articles/89430877481.htm>.



Хятадын бүх шүүхийн блокчэйн платформууд нь нэгдсэн блокчэйн бөгөөд олон нийтийн блокчэйний бүрэн төвлөрсөн бус системээс (Bitcoin blockchain болон Ethereum blockchain гэх мэт) ялгаатай нь байгууллагууд зөвхөн хостоос урьдчилан зөвшөөрөл авснаар сүлжээний гишүүн (зангилаа) болох боломжтой. Нэгдсэн блокчэйн нь нийтийн блокчэйнтэй ижил хамгаалалтын бүтэцтэй байх боловч илүү үр ашигтай, зардал багатай. Хятадын Ардын шүүхийн блокчэйн одоогоор 27 гишүүнтэй байгаа бөгөөд үүнээс 21 нь ямар нэгэн шатны шүүхүүд байгаа ба бусад нь нотариатын газрууд, шүүхийн шинжилгээний байгууллага зэрэг бусад байгууллагууд байна. Эдгээр гишүүд тус бүр блокчэйний цахим хуулбарыг хадгалдаг бөгөөд өндөр хурдны серверүүд, өгөгдөл хадгалах төхөөрөмж, тусгайлсан дотоод сүлжээгээр тоноглогдсон байдаг. Бүх гишүүд цахим нотлох баримтыг оруулах, хадгалах, гаргаж авахдаа зөвхөн найдвартай, тогтсон өгөгдлийг хадгалахын тулд ижил дүрмийг баримталдаг. Хамтран ажиллаж буй технологийн компани нь цахим гарын үсэг, байршил, цагийн тэмдэг, өгөгдлийг шифрлэх, тайлах зэрэг чухал технологиудаар хангадаг. Ухаалаг утасны программ, вэб сайт зэрэг эцсийн хэрэглэгчийн порталууд нь цахим файл (жишээ нь вэб хуудас, онлайн гүйлгээний бүртгэл, цахим гэрээ) харьцангуй бага зардлаар байршуулах боломжийг хэн бүхэнд олгодог.

Хятад дахь уламжлалт нотариатын үйлчилгээтэй харьцуулахад шүүхийн блокчэйн нь харьцангуй хямд, үйлчилгээ авахад төвөг багатай мөртлөө эх байдлыг баталгаажуулахад ч илүү

найдвартай болж байгаа. Иргэний хэрэг маргаан, ялангуяа жижиг маргаанд нотлох баримтыг гаргаж өгөх зардлыг блокчэйн технологи хамаагүй багасгаж байна. Жишээ нь: 4000 юань (\$560) буюу түүнээс бага хэмжээний хохирлыг гаргуулах маргаанд нэг цахим хуудсыг нотариатаар баталгаажуулахад зарцуулах зардал нь тухайн нэхэмжилсэн хохирлын хэмжээтэй дүйцэхүйц байхад блокчэйний санал болгодог хадгалах үйлчилгээний хөлс нь 1 юань (14 цент) байна.¹⁵

Блокчэйн + шүүх засаглал блокчэйнд ч мэдээж тодорхой зарим асуудлууд бий. Цахим файлыг системд хадгалахаас өмнө ямар нэгэн өөрчлөлт оруулах, хувиргах зэргийг зогсоох боломжгүй. Гэхдээ үүнээс илүү асуудал дагуулж байгаа зүйл нь шүүх системийн блокчэйн платформууд хувийн технологийн компаниудаас хамааралтай байгаа явдал юм. Хятадад хувийн компаниуд их хэмжээний хувийн мэдээлэл хадгалж байгаа нь буруугаар ашиглах боломжийг бүрдүүлэх вий хэмээн олон нийтийн зүгээс анхааруулж байгаа. Арилжааны хувийн компаниуд шударга байж чадах уу гэдэгт олон нийт ч, олон шүүгчид ч эргэлзэж байгаа.¹⁶ Хэдийгээр тоо томшгүй олон цахим файлууд шүүхийн янз бүрийн блокчэйнд хадгалагдаж байгаагийн дотор 180 сая гаруй хувь цахим файл зөвхөн Хятадын Ардын дээд шүүхийн блокчэйнд байршсан боловч өнөөг хүртэл хадгалагдсан ихэнх мэдээлэл нь шүүх ажиллагаанд онцын ач холбогдолтой байж чадахгүй байна. Практикт 2018 оны 6-р сараас 2019 оны 12-р сар хүртэл Хятадын шүүхүүд

¹⁵ Жеймс Годефрой, *supra* note 13.

¹⁶ “Ган Гуо, Вэнью Ли, Ин Шен, Гуравдагч этгээдийн цахим өгөгдөл хадгалах платформын асуудлууд болон саналуудын дүн шинжилгээ,” 138 China Intell. Тухай 68 (2018).



блокчэйн цахим нотлох баримтыг ердөө 400 орчим хэрэгт авч үзсэн байна. Гэсэн хэдий ч одоогийн чиг хандлагаас харахад блокчэйнээр дамжуулан цахим файл байршуулах хэрэглээ ирэх жилүүдэд өсөх төлөвтэй байна.

УХААЛАГ ШҮҮХ ТӨСӨЛ

Дэлхийн бусад ихэнх орны нэгэн адил Хятад улсад хууль эрх зүйн салбар дахь технологи, тэр дундаа таван жилийн өмнөөс эрч хүчээ авч эхэлсэн хиймэл оюун ухааны (AI) хэрэглээ, түүний талаарх ойлголт харьцангуй шинэ хэвээр байна. Хувийн хэвшил, зах зээлд чиглэсэн хөгжлийн стратеги нь хуулийн салбар дахь технологийн хөгжлийг чиглүүлж байдаг Америкаас ялгаатай нь хуулийн салбар дахь технологийн хөгжлийг удирдан чиглүүлэгч нь Хятадын Ардын дээд шүүх байдаг бөгөөд ухаалаг шүүх байгуулах асуудлыг үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэл болгосон байна. Хууль эрх зүйн салбар дахь технологийг хөгжүүлэх Хятадын энэхүү дээрээс доошоо чиглэсэн арга барил нь Хятадын хууль эрх зүйн тогтолцоонд хурдацтай ахиц гаргахад хүргэсэн.

2017 онд болсон Хятадын Ардын дээд шүүхийн чуулганы үеэр танилцуулсан үндсэн илтгэлдээ Ерөнхий шүүгч Жоу Чيان шүүхийн шинэчлэл болон ухаалаг шүүх байгуулах хос зорилтыг “унадаг дугуйны хоёр дугуй, шувууны хоёр далавч”-тай адилтган зүйрлэж, “ухаалаг шүүх төсөл нь Хятадын шүүхийн шинэчлэлийн гол хэсэг мөнөөс гадна Хятадын шүүхийн шинэтгэлийг дараагийн түвшинд хүргэх хөдөлгөгч хүч” хэмээн онцолсон байдаг.¹⁷

¹⁷ Чيان Жоу, “Ухаалаг шүүх”-ийг байгуулах гол чиглэлийг тогтоон үйл явцыг хурдасгах нь,” Ардын шүүхийн өдөр тутмын сонин, 2017, [http://rmfyyb.chinacourt.org/paper/html/2017-](http://rmfyyb.chinacourt.org/paper/html/2017-02/24/content_122134.htm?div=0)

Харин ухаалаг шүүх гэж ямар ойлголтын талаар хэлж байна вэ? Ухаалаг шүүх гэж юу вэ? гэсэн бүрэн тодорхойлолт байхгүй боловч Хятадын Ардын дээд шүүхээс гаргасан баримтуудаас харахад олон нийтэд үйлчлэх зорилгоор, шүүн таслах ажиллагааны бүх үйл явц (хэрэг бүртгэхээс шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хүртэлх)-д цахимаар нэвтрэх, ажиллах боломжийг олгосон ил тод, сүлжээгээр холбогдсон, ухаалаг мэдээллийн технологийн системийг хөгжүүлсэн дэвшилтэт технологийн хамгийн сүүлийн үеийн шийдэл гэж ойлгож болохоор байгаа бөгөөд улмаар Хятадын шүүх тогтолцоог сайжруулж, орчин үед нийцүүлэн хөгжүүлэх зорилготой байна.¹⁸ Бодит байдалд ухаалаг шүүх гэж Хятад дахь бүх шүүхүүд болон шүүгчдэд зориулсан онлайн программ хангамжийн систем бөгөөд энэхүү систем нь бүх хэргийн материалыг цахимжуулах, хууль эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлэх, цахим баримт бичиг, нотлох баримтыг хянах, батлах болон шилжүүлэх ажиллагааг хөнгөвчлөх, шүүх хурлын тэмдэглэлийг автоматаар үүсгэх, ижил төстэй хэргийн шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийг автоматаар иш татах зэрэг үйлдлийг гүйцэтгэх чадвартай байх ёстой.¹⁹

Ардын дээд шүүх супер компьютер, 5G сүлжээний систем, үүлэн санах ой, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан зэрэг сүүлийн үеийн дэвшилтэт

02/24/content_122134.htm?div=0.

¹⁸ Хятадын Ардын Дээд Шүүхийн Ухаалаг шүүхийг байгуулах үйл явцыг түргэсгэх удирдамжийн 1 дүгээр зүйл, Шүүхийн хэвлэл №12 (2017)-ыг үзнэ үү. <http://gongbao.court.gov.cn/Details/5dec527431cdc22b72163b49fc0284.html>.

¹⁹ Чихон Шион, “Хятад дахь шүүхийн шинэчлэлийг эрчимжүүлэхэд ухаалаг шүүхийг бий болгох нь,” *Guangming Daily*, 2017.



технологийн бий болгож буй давуу талыг бүрэн ашиглаж, хөгжүүлэх хүсэлтэй байдаг. Ухаалаг шүүхийг хөгжүүлэхэд шүүгчийн ажиллах хүчний хомсдол, шүүхийн тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл сул байгаа байдал, Хятадын хууль, эрх зүйн тогтолцоог яаралтай шинэчлэх шаардлага гэх 3 хүчин зүйл тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж үзэж байна.

Нэгдүгээрт, шүүгчийн ажиллах хүчний хомсдол: 1978-2015 оны хооронд (анхан, дунд, давах шатны шүүхүүдийг оролцуулан) хүлээн авсан хэргийн тоо 613.000-аас 16.7 сая хүрсэн буюу 27.3 дахин өссөн байна. Энэ хугацаанд хүлээн авсан иргэний хэрэг 34.7 дахин буюу 318.000-аас 11.05 сая болж өсжээ. Хятад дахь шүүгчдийн тоо ч мөн энэ өсөлтийг дагаж өссөн буюу 1981 онд 60.000 байсан бол 2015 онд 196.000 болж, 3.27 дахин өсжээ. Хэдий тийм боловч шүүгчдийн өсөлтийг хүлээн авч буй хэрэгтэй харьцуулахад хамаагүй бага байгаа нь харагдаж байна. Иймд нэг шүүгчид оногдох ажлын ачаалал энэ хирээр өссөн юм. Тухайлбал, 1981 онд нэг шүүгчид 20 хэрэг ноогдож байсан бол 2015 онд 85 хэрэг хуваарилагджээ.²⁰ Түүнчлэн 2015 онд Хятадын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны систем нь уламжлалт шүүхийн хяналтын загвараас бүртгэлийн загварт шилжсэнээр иргэний хэрэг үүсгэх нь өмнөхөөсөө хамаагүй хялбар болж, хүлээн авах хэргийн тоо нэмэгдсэн.²¹ Харин 2017 оноос хойш

“мэргэжлийн ур чадвар сул” шүүгчдийг халах, тоог цөөлөх үндэсний хэмжээний санаачилгын улмаас шүүгчдийн тоо цөөрөөд байна.²² Үүний дээр ажлын өндөр ачааллаас болж ажлаа орхих шүүгчдийн тоо ч нэмэгдсэн байна.²³ Ухаалаг шүүх төслийн зорилго бол шүүн таслах ажиллагааны зарим процессыг автоматжуулсан системийг бий болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, шүүгчийн ажлын стрессийг бууруулах юм.

Хоёрдугаарт, олон нийтийн итгэл: Ухаалаг шүүх төслийг хэрэгжүүлснээр олон нийтийн зүгээс ил тод бус хэмээн шүүмжлүүлдэг шүүхийн тогтолцооны гажуудлыг засаж, хүн бүрд нээлттэй мэдээллийг хүргэх зорилготой.²⁴ Онлайн платформууд нь аливаа хэргийн төлөв байдлыг чөлөөтэй, хялбар шалгах, шүүх хуралдааныг шууд үзэх, хэргийн шийдвэр, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг хайх, хянах боломжийг олон нийтэд олгодог. Энэ ил тод байдал, хялбар нэвтрэх боломж зэрэг нь шүүхийн системд итгэх итгэл, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлнэ гэж найдаж байгаагаас гадна Хятадын шүүгчдийг хэргээ илүү анхааралтай, няхуур хэлэлцэхэд нөлөөлөх боломжтой.

Эцэст нь, хуулийн тогтолцоог

хэмжээний тухай (2015), <http://www.court.gov.cn/shenpan-xiangqing-14151.html>.

²² Линлин Фенг, “Чадварлаг шүүгчдийг сонгон шалгаруулах ба шүүх бүрэлдэхүүнийг шүүн сонгох шинэчлэл улс даяар хэрэгжиж өмнөх 90,000 шүүгч сонгон шалгаруулалтад тэнцэхгүй хэвээр байсаар байна,” China Daily, 2017, <https://www.chinanews.com/gn/2017/07-05/8269363.shtml>.

²³ Линлин Лай, “Шүүгчдийн дутагдал, Шүүхүүд ажлаас гарсан шүүгчдийн жагсаалтыг харж сандралд орж байна уу?” 2016, <https://www.kunlunce.com/ssjj/guojipinglun/2016-07-10/105840.html>.

²⁴ Меган Пенник, “Хятад дахь арбитр ба гадаадын хөрөнгө оруулалт: Ил тод байдалгүй, урьдчилан таамаглах боломжгүй,” Sarbanes-Oxley Compliance J., 2005, http://www.s-ox.com/dsp_getFeaturesDetails.cfm?CID=526.

²⁰ Хайян Жанг, “Хятадын шүүхэд тулгарч буй “Хэтэрхий олон хэрэгт хэт цөөн шүүгч” бэрхшээлд зохицон урагшлах нь – Иргэний хэргийн шинжилгээ J. Shandong U.” (Phil. & Soc. Sci.) 48 (2018).

²¹ БНХАУ-ын Коммунист намын Улс төрийн товчоо, Шинэчлэлийг иж бүрэн гүнзгийрүүлэх төв тэргүүлэгч бүлэг, Хэрэг бүртгэх бүртгэлийн тогтолцооны шинэчлэлийг дэмжих арга



шинэчлэх хэрэгцээ шаардлага: Хятад улс орчин үеийн хуулийн тогтолцоог бий болгох чиглэлээр хоцрогдмол бөгөөд шүүх тогтолцооны хувьд ч гаднын орны загварыг ашигладаг. Хятад улс шүүх танхимд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар энэ хэвшмэл ойлголтыг өөрчлөхийн зэрэгцээ Хятадын шүүхийн тогтолцооны эерэг дүр төрхийг дэлхийн бусад оронд харуулахыг зорьж байна.²⁵ Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Жоу 2012 онд томилогдсон цагаасаа хойш ухаалаг шүүхийн бүтээн байгуулалтад хэдэн зуун сая юань, асар их хүний хөрөнгийг зарцуулж богино хугацаанд виртуал шүүхийн орчныг бий болгож чадсан. Шүүхийн цахимжилтын асуудлаар өнөөг хүртэл авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дөрвөн асуудлыг товчлон танилцуулья.

Шүүхийн баримт материалыг цахимжуулах. Хятадын Ардын дээд шүүх ухаалаг шүүх төслийг шүүхийн баримт материал (голчлон шүүхийн шийдвэрүүд)-ыг цахимжуулах ажлаар эхэлсэн. 2012 оноос өмнө Хятадын шүүхийн ихэнх файлууд, ялангуяа шүүхийн шийдвэр зэрэг чухал файлууд нь зөвхөн цаасан хэлбэрээр байсан бөгөөд олон нийтэд хүртээмжтэй байсангүй. 2013 оны 7 дугаар сард “China Judgments Online” буюу шүүхийн шийдвэрийг цахимаар хадгалах, хайх олон нийтэд зориулсан нээлттэй, үнэ төлбөргүй системийг нэвтрүүлсэн.²⁶ Одоогоор уг системд 84 сая гаруй

²⁵ “Ухаалаг шүүхийг байгуулах ажлыг эрчимжүүлэх нь цуврал ярилцлага,” Хятадын Ардын Дээд шүүхийн ажлын тайлан, 2018, <http://www.court.gov.cn/zixun-xiangqing-85042.html>.

²⁶ Хятадын шүүхийн шийдвэрийн цахим сан, <http://wenshu.court.gov.cn/> (Сүүлд үзсэн 2020.01.27)

хэргийн материал, түүний дотор 52 сая иргэний хэргийн шүүхийн шийдвэр байх бөгөөд хандалтын тоо 1 тэрбумыг даваад байна. Системийг хөгжүүлснээр олон нийтэд ашиг тустай байгаад зогсохгүй Ардын дээд шүүхийн үйл ажиллагаанд ч асар үр ашигтай байгаа юм. “Шүүхийн их өгөгдөл” гэж нэрлэгдэж буй энэ их мэдээллийг эргэлтэд оруулснаар өмнө нь ямар ч боломжгүй гэж бодож байсан статистик тоо баримтыг гарган ирэх боломжтой болж байна. Тухайлбал, 2019 оны 11 дүгээр сард Цинхуа их сургуульд тавьсан илтгэлийнхээ үеэр Ерөнхий шүүгч Жоу Чيانг Хятадад гэр бүл салах өргөдөл гаргаж буй хүн амын 74 хувь нь эмэгтэйчүүд байх бөгөөд ихэнх нь 3 жил орчмын дараа гэр бүл цуцлуулах хүсэлт гаргаж байгаа тухай сонирхолтой мэдээллийг хуваалцсан. Энэ мэдээлэл нь олны анхаарлыг ихээр татсан бөгөөд гэр бүл цуцлуулах өргөдлийг эрчүүд ихэвчлэн гаргадаг ба энэ нь 7 дахь жилийн мөчлөгтэй мөн холбоотой гэсэн ойлголтыг үгүйсгэсэн.²⁷ 2017 онд Хятадад 1.4 сая гаруй гэр бүл цуцлуулах өргөдлийг судлан гаргасан тайланд үндэслэн дээрх мэдээллийг Ерөнхий шүүгч Жоу гаргасан²⁸ бөгөөд хэргийн материалыг дижитал хэлбэрт шилжүүлээгүй бол энэ төрлийн эмпирик судалгааг гаргахад хүндрэлтэй байх байсан. Шүүхийн их өгөгдлийн ачаар Ардын дээд шүүх иргэний хэрэг, эрүүгийн хэрэг болон бусад өргөн хүрээний сэдвүүдийг хамарсан 25 судалгааны тайланг аль хэдийн нийтэлсэн байна.²⁹

²⁷ Headline news, Weibo, 2019, <https://m.weibo.cn/detail/4438254574996042>.

²⁸ National Business Daily, Weibo (2019), <https://www.weibo.com/ttarticle/p/show?id=2309404440828968828985>.

²⁹ Их өгөгдлийн судалгааны сэдвүүд, <http://www.>



Цахим платформуудыг бий болгох. 2018 оны эхээр Ардын дээд шүүхээс олон үйлдэл бүхий, шүүхийн дотоод цахим платформыг бүтээсэн бөгөөд энэхүү платформ нь Хятад даяарх бүх шүүх танхим – 3520 шүүх, 9238 шүүх танхимыг холбосон.³⁰ Уг шүүхийн дотоод сүлжээ нь Хятад улсын бүх шүүгчид нэг цахим платформ дээр хэрэг хянан шийдвэрлэх, ажиллах, суралцах, харилцах төдийгүй дээд шатны шүүхээс анхан шатны шүүхүүдэд хяналт тавих боломжийг олгодог. Ардын дээд шүүхээс өрөөндөө сууж байгаад л тухайн улсын аль ч шүүхийн танхимын үйл ажиллагааг шууд харах боломжтой.³¹

Шүүхийн дотоод системээс гадна Ардын дээд шүүхээс олон нийтэд зориулсан хэд хэдэн цахим хуудсыг хөгжүүлсэн. Үүнд: хэргийн оролцогч талууд, өмгөөлөгчдөд зориулсан шүүх хурлын үйл явц (хурлын тэмдэглэл, дүрс бичлэг, хэргийн материал, эрх зүйн баримт бичиг г.м)-д хамаарах мэдээлэлд нэвтрэх боломжтой “China Judicial Process Information Online” систем, олон нийт чөлөөтэй хандах эрхтэй шүүх хуралдаан шууд дамжуулалтын “China Trials Online” систем, шийдвэр гүйцэтгэх журам болон шүүхийн шийдвэр биелүүлээгүй хүмүүсийн жагсаалтыг нийтлэх “China Enforcement Information Online” гэх 3 системийг ашиглалтад оруулсан бөгөөд эдгээр цахим системүүдийг шүүхийн ил

тод байдлыг хангах чухал хэрэгсэл, шүүх тогтолцоонд олон нийтийг оролцуулах чухал алхам болсон гэж үзэж байгаа.

Эрх зүйн чиглэлээрх хиймэл оюун ухааныг хөгжүүлэх. Эрх зүйн чиглэлээрх хиймэл оюун ухааныг хөгжүүлэх асуудал сүүлийн жилүүдэд Хятадад ихээхэн дэлгэрч байна. Томсон Ройтерсийн мэдээлсэн статистикаас үзвэл хууль, эрх зүйд хамаарах технологи хөгжүүлэхээр мэдүүлсэн олон улсын патентын мэдүүлгийн тоо 2013-2018 оны хооронд 4 дахин буюу 202-933 болж нэмэгдсэн байна. 2018 онд л гэхэд тэдгээр патентын мэдүүлгийн талыг нь буюу 51% нь Хятадад, 23% нь АНУ-д, 11% нь Солонгос улсад мэдүүлсэн.³² Хиймэл оюун ухааны технологид хүлээлгэж буй найдлага өндөр байгаа хэдий ч удахгүй шүүгчдийг орлоно гэж зарим тайлан, нийтлэлд дурдаж байгаа нь арай хэтрүүлэг болох төдийгүй бодит байдалд нийцэхгүй, ойрын ирээдүйд түүнд хүрэхгүй гэж бодож байна.³³ Харин хиймэл оюун ухааныг Хятадын шүүгчдийн өдөр тутмын ажил, хэрэг шийдвэрлэх явцад нь туслуулахаар ашиглах нь зүйтэй³⁴ бөгөөд шүүх хуралдааны тэмдэглэлийг буулгах зорилготой дуу хоолой таних технологи болон ижил төрлийн хэргүүдийг шүүж гаргаж ирэх автомат мэдэгдлийн систем хамгийн тохиромжтой байна.

court.gov.cn/fabu-gengduo-662.html (Сүүлд үзсэн 2020.01.27)

³⁰ Тиан Тиан, “Ухаалаг шүүхийг байгуулах чиглэлээр ямар ололт амжилтад хүрсэн бэ?” Синьхуа мэдээ, 2018, http://www.xinhuanet.com/comments/2018-03/10/c_1122517633.htm.

³¹ Жианфэн Сюү, “Ухаалаг шүүхийг байгуулах нь,” Хятадын Ардын дээд шүүхийн ажлын тайлангийн Тайлбар №3, Econ. Daily, 2018, <http://www.ce.cn/ztpd/xwzt/xzbzt/zgfjd3/index.shtml>.

³² Барни Томпсон, Ниан Лю, “Хууль зүйн технологийн чиглэлээрх патентын тоог Хятад тэргүүлж байна,” Fin. Times, 2019, <https://www.ft.com/content/13ec27bc-304c-11e9-ba00-0251022932c8>.

³³ Мониша Пиллай, “Хятад AI-аар хүч нэмэгдүүлсэн шүүгчидтэй боллоо,” RADII, 2019, <https://radiichina.com/china-now-has-ai-powered-robot-judges/>.

³⁴ Маша Борак, “Хятад шүүх танхимдаа технологийн дэвшлийг хүлээн авч байна,” TechNode, 2018, <https://technode.com/2018/10/24/china-court-technology/>.



Дуу хоолой таних технологи (automatic speech recognition) нь Хятадын шүүхүүд шүүх хуралдааны тэмдэглэл бэлтгэхдээ зарцуулах хүний нөөц болон бусад нөөцийг хэмнэх асар их боломжийг агуулдаг. Жэжян мужийн Ардын шүүх 2014 оны 8 дугаар сараас эхлэн дуу хоолой таних технологийг ашиглан шүүх хуралдааны тэмдэглэлийг бодит цагт гаргаж эхэлсэн³⁵ бөгөөд энэ үйл явдал Хятадад тэр даруй алдаршжээ. Хятадын тэргүүлэгч дуу хоолой таних технологийн компани болох iFlytek-ийн боловсруулсан туршилтын дуу хоолойг автоматаар таних системийг 2016 оны 12 дугаар сард Ардын дээд шүүхийн Шинжээчдийн Үнэлгээний Хорооноос баталж, улмаар орон даяар шүүхийн танхимд нэвтрүүлэхээр дэмжсэн.³⁶ iFlytek-ийн өгч байгаа мэдээллээр дээрх технологийн тусламжтайгаар нэг минутад боловсруулах тэмдэглэлийн хурдыг 120-150 байсныг 250-350 үг болгож нэмэгдүүлэх чадвартай.³⁷ Зарим шүүгч, хуульчид энэ технологид итгэх итгэл сул байгаагаа илэрхийлж байгаа бөгөөд тухайлбал, технологийг гаргасан үндсэн зорилго нь ашиг олох байгаа нь эргэлзээ төрүүлж байгаа бөгөөд ялангуяа нутгийн аялга зэргийг бүрэн таньж, буулгах чадвартай эсэхэд нь эргэлзэж байгаа

юм. Өнөөдрийн байдлаар энэ технологи Хятадын 34 засаг захиргааны нэгжийн 31-ийх нь 4200 шүүх хурлын танхимд суурилагдсан.

Ижил төстэй хэргүүдийн мэдээллийг автоматаар илрүүлэгч системийг ижил төстэй хэргүүд өөр өөрөөр шийдвэрлэгдэж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор анх 2018 оны 1 дүгээр сард ашиглалтад оруулсан. Хэдий өмнө шийдэгдсэн хэргийн жишгийг ирээдүйд шийдвэрлэх хэрэгт ашигладаггүй ч тодорхой стандартыг бий болгох нь зүйтэй гэж Ардын дээд шүүхээс үзэж байгаа юм.³⁸ “Ижил төрлийн хэргийг хянан шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох, шүүгчийн удирдамжийг сайжруулах үндсэн дээр ижил төстэй хэргийг нэг жишгээр шүүж, хуулийн нэгдмэл хэрэглээг хангах зорилгоор бүх шатны Ардын шүүхүүд ижил төстэй хэргийг хайж үзэх боломжтой хайлтын системийг заавал бий болгох нь зүйтэй” гэсэн саналыг 2017 онд гаргасан байдаг.³⁹

Энэхүү мэдэгдлийн систем нь ижил төстэй хэргийг гараар хайх, автоматаар мэдэгдэх боломжийг олгодог. Ардын дээд шүүх Хятадын шүүгчид шийдвэр гаргах, шийдвэрээ нэг мөр болгох, хуулийг нэг мөр хэрэглэх, шүүх хуралдааны чанарыг цаашид сайжруулахад тусална гэж найдаж байгаа бөгөөд Хятадын ардын дээд шүүхийн эх сурвалжийн мэдээлснээр

³⁵ “Жэжяны шүүхүүд шүүх хуралдааны бичлэгийг бий болгоход дуу хоолой таних технологийг улсын хэмжээнд анхлан ашиглаж эхэллээ,” Xinhua News, (2016), http://www.xinhuanet.com/politics/2016-06/07/c_129046151.htm.

³⁶ Essence Securities, “iFlytek хууль эрх зүйн салбарт үргэлжлүүлэн тэргүүлэх болно,” CitNews (2019), <http://www.citnews.com.cn/citnews/roll/201906/99066.html>; мөн Хятадын Ардын Дээд шүүхийн Ардын шүүхийн шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийн тухай дүрмийн 2, 6 дугаар зүйл, Шүүхийн тайлбар №5 (2017), <http://gongbao.court.gov.cn/Details/d3d8ee60121d1dfc471f235008870a.html>.

³⁷ Supra note 37.

³⁸ Мэн Ю, Гуодун Ду, “Ижил төстэй хэргийн ижил төстэй шийдвэрүүд: Хятадын шүүхүүдэд хиймэл оюун ухааныг дэмжихэд нөлөөлж буй хүчин зүйлүүд,” China Just.Oberserver, 2019, <https://www.chinajustobserver.com/a/similar-judgements-for-similar-cases-forces-driving-chinese-courts-to-promote-ai>; Мөн Шүүхийн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх талаар БНХАУ-ын Ардын дээд шүүхийн санал, Judicial Issuance No.11, 2017, <http://www.court.gov.cn/zixun-xiangqing-40582.html>.

³⁹ Supra note 39.



энэхүү систем нь Хятадын бүх төрлийн иргэний болон эрүүгийн хэргийг дөрвөн чиглэлээр адилтган хайж болдог. Үүнд: а) хэргийн шинж чанар, б) баримтын онцлог, в) гомдлын шаардлага, г) холбогдох хууль тогтоомж гэсэн чиглэл хамаарна. Ижил төстэй хэргийн автомат мэдэгдлийн нийт нарийвчлалын хувь 63.7 хувь байгаа бол иргэний болон эрүүгийн эхний арван төрлийн хэрэг дээрх ижил төстэй хэргийн мэдэгдэл 85.5 хувьд хүрчээ.⁴⁰ Гэсэн хэдий ч, дуу хоолой таних технологийн нэгэн адил энэ мэдэгдлийн систем нь Хятадын шүүгчид болон оролцогч талуудын дунд хүлээн зөвшөөрөгдөж чадаагүй байна. Учир нь одоогийн технологи нь боловсронгуй бус тул үр ашигтай ажиллахад хүндрэлтэй байдаг ч технологи хурдацтайгаар сайжран удахгүй өөрчлөгдөнө гэсэн хүлээлттэй байна..⁴¹

Шүүхийн баримт бичгийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх. 2012 оноос эхлэн Ардын дээд шүүх, Хятадын засгийн газрын зарим байгууллагуудтай хамтран Хятадын шүүхийн системд шүүхийн баримт бичгийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх томоохон алхам хийсэн. Хятадад баримт бичгийг хүргэх, гардуулах нь эртнээс асуудал болсоор ирсэн бөгөөд энэ ажил нь зарим нутаг дэвсгэрт шүүгчийн туслах, хуульчийн туслах нарын ажлын ачааллын 80 хүртэлх хувийг эзэлдэг. Баримт бичгийг хүргэх, зарлан мэдээлэхэд хэд хоногоос 3 сар

хүртэлх хугацаа зарцуулдаг.⁴² БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр шүүх хуралдааны зарим баримт бичгийг (шүүхийн шийдвэр, эвлэрүүлэн зуучлалын үр дүн г.м) факс, цахим шуудангаар илгээхийг зөвшөөрсөн.⁴³ Гурван жилийн дараа Ардын дээд шүүх нь "мобайл холбоо"-ыг хууль ёсны үйлчилгээний арга болгон нэмж, цахим үйлчилгээг ашиглах талаар тодорхой дүрмийг тогтоосон.⁴⁴ Эдгээр өөрчлөлтүүд нь шүүхийн баримт бичгийг илүү хүртээмжтэй болгох, ялангуяа гар утас, и-мэйл хаяг ашиглах боломжтой хүн амын бүлэгт нэвтрэх, мэдээлэл авах боломжийг олгож байгаа хэдий ч Хятад улс 2017 онд бүх гар утас хэрэглэгчийг өөрийн жинхэнэ нэрээр бүртгүүлэх шаардлагыг тогтоосонтой холбогдуулан тагнах, хяналт тавих боломжийг нэмэгдүүлсэн гэж үзэж буй бүлэг ч байгаа юм.⁴⁵ Хятадын шүүхүүд орон нутгийн цагдаагийн хэлтэс, харилцаа холбооны компаниудтай мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллаж эхэлсэн. Түүнчлэн Хятадын зарим орон нутгийн шүүхүүд нь гар утсаар хүргэж

⁴² Үши хотын Давж заалдах шатны шүүхийн судалгааны газар, "Гар утасны SMS дээр суурилсан цахим үйлчилгээний талаарх судалгаа," Wuxi Ct.Online, 2019, <http://wxzy.chinacourt.gov.cn/article/detail/2019/07/id/4153421.shtml>.

⁴³ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2012)-ийн 87 дугаар зүйл.

⁴⁴ БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн <БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг> хэрэглэх тухай шүүхийн тайлбар (2015)-ын 135 дугаар зүйл, Шүүхийн тайлбар №5, <http://gongbao.court.gov.cn/Details/63ff48da6a9792f8ad1cb65a8b99d1.html>.

⁴⁵ Синьхуа агентлаг, "БНХАУ-ын Аж үйлдвэр, мэдээллийн технологийн яам: Бүх утасны хэрэглэгчдийн жинхэнэ нэрийн бүртгэлийг хэрэгжүүлж эхлэв," Tencent Tech. 2017, <https://tech.qq.com/a/20170118/031020.htm>.

⁴⁰ Вэймин Зуо, "Хиймэл оюун ухааныг ашиглан ижил төстэй шүүлтүүдтэй ижил төстэй хэргийг хэрхэн олох вэ," 5 China L.Rev 26, 2018; Мөн Бээжин хотын Оюуны Өмчийн Үйлчилгээний Нийгэмлэг, "Шүүх хуралдааны чанарыг үр дүнтэй сайжруулж, Ухаалаг шүүхийн бүтээн байгуулалтыг дэмжих нь," 2018, http://www.capitalip.org/news_detail_13415.html.

⁴¹ Supra note 41.



буй зарим цахим үйлчилгээндээ зориулж “албадан гарч ирэх мэдэгдлийн функц” гэх тохиргоог хүртэл хэрэгжүүлж эхэлсэн байна.⁴⁶ Энэ функц нь хүлээн авагч цахим баримтыг хүлээн авснаа баталгаажуулах хүртэл гар утсыг түгжинэ. Хэдийгээр үр дүнтэй боловч энэ функц нь өмчлөх эрхийг зөрчиж, компьютерын вирус шиг ажиллаж байна гэсэн шүүмжлэл дагуулаад байгаа.⁴⁷

Ухаалаг шүүх төслийн хүрээнд өндөр хүлээлт бий болж, шинэ тутам шийдлүүдийг нь олон нийт, оролцогч талууд таатайгаар хүлээн авч байгаа хэдий ч төсөл бүрэн гүйцэт дуусах болоогүй байна. Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль эрх зүйн салбар дахь хиймэл оюун ухааны талаар таатайгаар ярьж, хүлээлт үүсгэж байгаа хэдий ч технологийн хөгжил өнөөдрийн байдлаар хагас дутуу, практикт төдийлөн хэрэглэгдэхгүй байгаа нь үнэн. Хуулийн хиймэл оюун ухааны технологид хамаарах алгоритмыг сайжруулж, илүү нарийвчилсан боловсронгуй технологид хөрөнгө мөнгө зарах шаардлагатай байна. Ухаалаг шүүх төслийн ар тал дахь “оюун ухаан” нь хэн нэгэн программ хөгжүүлэгч, техникч, компани байхаас илүү Хятадын шүүгчдийн оюун ухааны тусгал байх ёстой буюу Хятадын шүүгч нар өөрсдөө энэ технологи, программыг хөгжүүлэхэд анхнаас нь идэвх санаачилгатай оролцож, нягт хамтран ажиллах шаардлагатай.

⁴⁶ Шианчин Лю, Минжун Лю, “БНХАУ-д иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал ба цахим үйлчилгээг сайжруулах тухай,” 396, J. of L. Application 33, 2018.

⁴⁷ Computer News, “Ардын шүүх, Харилцаа холбооны гурван том оператортой хамтран “Snap Screen SMS”-ийг нэвтрүүлнэ,” Sina 2018, <https://t.cj.sina.com.cn/articles/view/6497132632/18342605800100bbz7>.

Бодит ертөнц мөнхийн хөдөлгөөнд оршиж, тогтмол өөрчлөгдөж байна. Үүнтэй ижил хувь хүн бүр өөр өөр. Ийм ухаалаг шүүхийн төсөл ирээдүйд хэчнээн сайн боловсронгуй, дэвшилттэй болсон ч түүний цаад технологи, алгоритмууд нь шатар, го даам гэх мэт хаалттай системд ажилладаг шиг нарийн төвөгтэй шүүх хуралдааны системд ажиллахгүй байх магадлалтай. Хууль эрх зүйн салбар дахь хиймэл оюун ухаан нь шүүх ажиллагаанд туслах үүрэг гүйцэтгэн оролцох боломжтой хэдий ч шүүгч хүнийг орлох ямар ч боломжгүй төдийгүй орлож ажиллах боломжтой мэт төсөөлөх нь өөрөө аюултай. Мөн Ардын дээд шүүхийн хадгалж буй “их өгөгдөл” нь харьцангуй эмзэг мэдээлэл тул буруу гарт орсон тохиолдолд иргэдийн хувийн нууцыг зөрчих боломжийг олгодог. Иймд ухаалаг шүүхийн тогтолцооны амжилт нь кибер хакерууд болон сүлжээний вирусийн халдлагаас сэргийлж чадах аюулгүй кибер орон зайгаас хамаарна. Ухаалаг шүүхийн системийн кибер аюулгүй байдлыг хангах нь Ардын дээд шүүхийн хамгийн чухал ажил байх болно.

ХЯТАДЫН ИНТЕРНЭТ ШҮҮХҮҮД

Хятадын цахим шүүх рүү чиглэсэн сүүлийн үеийн алхмын хамгийн амжилттай бөгөөд ирээдүйтэй хэсэг нь шүүх хуралдаанаа цахимаар явуулж, цахимаар ирүүлсэн иргэний маргаанд анхаарлаа хандуулдаг интернэт шүүхүүд юм. Эдгээр шүүхүүд нь анх 2017 онд Ардын дээд шүүхийн ухаалаг шүүх төслийн нэг бүтээгдэхүүн болж үүссэн бөгөөд өндөр технологи, уламжлалыг хослуулсан. Ардын дээд шүүх нь



Алибаба группийн өлгий нутаг бөгөөд Хятадын цахим худалдааны салбарын хамгийн цэцэглэн хөгжиж буй хот болох Ханжоу хотод анхны интернэт шүүхийг байгуулжээ.⁴⁸ Хэдийн Ардын дээд шүүхийн зүгээс Ханжоу хотын интернэт шүүхийг бүх үйл ажиллагаагаа цахимаар явуулахыг уриалдаг бөгөөд Ханжоу хотын интернэт шүүх нь олон үйлдэлт цахим хуудсыг ажиллуулдаг ч гэлээ мөн хотод өөрийн байр, албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Ханжоу хотод харьяалах хэргийг хянан хэлэлцэж байна. Уг шүүх нь хуучин зочид буудлын⁴⁹ зориулалтаар ашиглагдаж байсан барилгыг засварлан том дэлгэц, компьютер зэргээр тоногдсон шүүх хурлын танхим болгон өөрчилсөн. Бүтэн цагаар ажилладаг 20 шүүгчтэй бөгөөд энэ нь орон нутгийн хэмжээний шүүхийн шүүгчдийн тоотой бараг тэнцүү гэсэн үг. Тус шүүхээс нийтэлсэн албан ёсны статистик мэдээгээр 2018 оны 8 дугаар сарын 17-ны байдлаар буюу байгуулагдсанаасаа хойш нэг жилийн хугацаанд Ханжоугийн интернэт шүүх интернэттэй холбоотой 12,074 хэрэг (ихэвчлэн иргэний хэрэг, цөөн хэдэн захиргааны маргаан) авч, үүнээс 10,391 хэрэг, үүний дотор үндэстэн дамнасан 80 маргааныг шийдвэрлэсэн байна. Нийтлэгдсэн бүртгэлийн мэдээллээс харахад эдгээр онлайн шүүх хуралдааны үргэлжлэх дундаж хугацаа нь 28 минут байсан бөгөөд онлайнар гомдол гаргахаас эхлээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуусах

⁴⁸ Синьхуа агентлаг, "Ханжоу хотод Хятадын анхны интернэт шүүх нээгдлээ", 2017, http://www.xinhuanet.com//2017-08/18/c_1121506307.htm.

⁴⁹ Мэн Ху, "Интернэт технологийн шүүх засаглалд үзүүлэх нөлөө-Ханжоугийн интернэт шүүхийг жишээ болгон шинжилсэн нь," 394, J. Application 52, 2018.

хүртэлх хугацаа 38 хоног байсан (иргэний хэргийн уламжлалт шүүх хурал ойролцоогоор 2 цаг үргэлжилж, гомдол гаргахаас шийдвэрлэх хүртэл ойролцоогоор 76 өдөр зарцуулдаг).⁵⁰

Ардын дээд шүүхийн зүгээс Ханжоугийн интернэт шүүхийг туршилтын журмаар байгуулсан нь амжилттай хэрэгжсэн тул 2018 оны 9 дүгээр сард дахин Бээжин, Гуанжоу хотуудад интернэт шүүх байгуулсан. Энэ хоёр хот нь Хятадын интернэт салбарт томоохон байр суурь эзэлдэг бөгөөд Бээжин хотод гэхэд Baidu, JD.com, Гуанжоу хотод дэлхийн хамгийн том видео тоглоом үйлдвэрлэгч, Хятадын хүн амын 2/3 нь ашиглаж буй зурвас солилцох аппликейшн болох Wechat, QQ-г эзэмшигч Tencent компани үйл ажиллагаа явуулж байна. Тухайн жилдээ Ардын дээд шүүхээс интернэт шүүхээр хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой хэд хэдэн асуудлын тухай заалтуудыг нийтэлж, эдгээр шүүхийн харьяаллыг тодорхой болгож, интернэт шүүхтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлыг зохицуулсан.

Уг заалтын дагуу интернэт шүүх нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн зээлтэй холбоотой цахим гэрээний маргаан, цахим зохиогчийн эрхийн маргаан; интернэтийн домэйн нэрийн талаарх маргаан; бусдын хувийн болон эд хөрөнгийн эрхэд халдах зорилгоор интернэт ашигласантай холбоотой маргаан; онлайн худалдаагаар авсан бүтээгдэхүүний хариуцлагын маргаан; прокуророос гаргасан интернэттэй

⁵⁰ Гуодун Ду, Мэн Ю, "Хятад улс интернэттэй холбоотой хэргүүдийг онлайнар шүүдэг гурван интернэт шүүх байгууллаа," China Just. Observer, 2018, <https://www.chinajusticeobserver.com/a/china-establishes-three-internet-courts-to-try-in-internet-related-cases-online>.



холбоотой нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл; засгийн газрын интернэтийн менежментээс үүдэлтэй захиргааны маргаан зэрэгт хамаарах хэргүүдийг харьяалан шийдвэрлэх үүрэгтэй.⁵¹ Одоогийн байдлаар дээрх гурван шүүх бүгд өөрсдийн хотын харьяанд байдаг анхан шатны шүүхүүд юм. Ихэнх давж заалдах гомдлыг өөрийн харьяаллын дагуу (онлайн бус) дунд шатны шүүхүүд хэлэлцдэг.⁵²

Холбогдох дүрэм журмын дагуу интернэт шүүх дэх шүүхийн бүх үйл явц, түүний дотор хууль эрх зүйн баримт бичгийн үйлчилгээ, нотлох баримтыг танилцуулах, бодит шүүх хуралдаан нь онлайнар явагддаг. Эдгээр хэргийн ихэнх нотлох баримт нь цахим мэдээлэл бөгөөд интернэтэд хадгалагдаж байдаг. Цахим гарын үсэг, цагийн тэмдэг, хэш утгын баталгаажуулалт, блокчэйн болон бусад хөндлөнгийн баталгаажуулалтын аргаар баталгаажуулах боломжтой бол цахим нотлох баримт хүчинтэй болохыг баталгаажуулсан Ардын дээд шүүхийн анхны хэвлэл нь интернэт шүүхэд хамаарах өмнө дурдсан заалтууд байсан юм.⁵³ Ханжоугийн интернэт шүүх нь олон нийтийн блокчэйн технологиор нотлогдсон нотлох баримтыг хүлээн зөвшөөрсөн Хятад дахь анхны шүүх юм.

Хятадын интернэт шүүхүүд ашигтай эсэх талаар одоогоор тодорхой хэлэх боломжгүй байна. Интернэт шүүхийн үйл ажиллагааг нэвтрүүлэх гэж багагүй

хэмжээний зардал гаргасан.⁵⁴ Хэдийгээр интернэт шүүхийн шүүгч онлайн шүүх хурлын дэг журмыг танилцуулсан ч (жишээ нь, утсаар ярихгүй) хэн нэгэн холбоо тасарч, хүрээлэн буй орчны чимээ шуугиан, Wi-Fi чанар нь доогуур түвшинд хүрч болзошгүй. Хүмүүс цахим орчинд үнэн байх хандлага багатай байж болох бөгөөд харилцан мэдүүлэг өгөх нь цахимаар хэрүүл маргаан хийж байгаа мэт санагддаг бөгөөд шүүгчийн нүүрний хувирал болон бусад биеийн хэлэмжийг ажиглахад саад болдог.⁵⁵ Дэлгэцийн цаана байгаа шүүх хурлын шүүгчид уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих нь хамаагүй бага байдаг. Мэдээжийн хэрэг, дэлхийн олон шүүхүүд, тэр дундаа Хятад улс COVID-19 тахлын улмаас шүүх хуралдааныг онлайнар явуулах томоохон туршлагатай болсон; энэ нь цар тахал арилсан ч гэсэн интернэт шүүхүүдийн "хүлээн авах чадварыг" сайжруулж магадгүй юм.

Цаашилбал, илүү асуудалтай зүйл бол Хятадын гурван интернэт шүүх бүгд технологийн аварга компаниудтай хотуудад байрладаг бөгөөд тэдгээр технологийн компаниуд тодорхой хэмжээгээр, технологийн хувьд дэмжин ажилладаг. Тухайлбал, Ханжоугийн интернэт шүүхийг Алибаба группийн охин компани болох Gongdao Network Technology⁵⁶ дэмждэг болохыг олон нийтийн бүртгэл харуулж байна.⁵⁷

⁵¹ Supra note 14, 2-р зүйл.

⁵² Сара Шиа, "Хятадын интернэт шүүхүүд тархаж байна; Маргаан шийдвэрлэх ажиллагаа онлайнар хийгдэж байна," China L. Blog, 2018, <https://www.chinalawblog.com/2018/12/chinas-internet-courts-are-spreading-online-dispute-resolution-is-working.html>.

⁵³ Supra note 14, 11 дүгээр зүйлийг харна уу.

⁵⁴ Шин Ван, "Шүүх хурал нь албан ёсны болон зан үйлийн мэдрэмжтэй байх ёстой," Xinjiang Ct. Net, 2016, <http://oldwww.xjcourt.org/public/detail.php?id=25153>.

⁵⁵ Шанган Жан & И Ван, "Интернэт шүүхийн онлайн шүүх хуралдааны механизмыг эргэн судлах нь," 492 Jiangnan F. 115, 2019.

⁵⁶ Gongdao Network Technology Co., Ltd., <https://www.gongdao.com> (Сүүлд үзсэн 2020.01.27).

⁵⁷ Supra note 51.



Ханжоугийн интернэт шүүхээр шийдэгдсэн ихэнх онлайн маргааны нэг тал болох Алибаба интернэт шүүхэд өөрийн хууль ёсны хувь заяаг тодорхойлох технологийг мөн нийлүүлдэг. Эдгээр интернэт шүүхүүд үйл ажиллагаагаа явуулахад нь тусалдаг технологийн аварга компаниудтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэхдээ шударга байж чадах эсэхэд олон нийтийн эргэлзээ нэмэгдэж байна.

Үүнтэй зэрэгцээд тодорхой ашиг тус байгааг тэмдэглэх нь зүйтэй. Интернэт шүүхийн үйл ажиллагаа ямар ч эргэлзээгүйгээр холбогдогч талуудын цаг, мөнгийг хэмнэж чадаж байна.⁵⁸ Зарим сурталчилгаанд “интернэт шүүхэд хандах нь онлайнар худалдаа хийхтэй ижил хялбар”⁵⁹ гэсэн агуулгыг хүргэж байгаа нь бодит нөхцөл байдал, түүний дагуулж буй олон асуудлаас зөрүүтэй байгаа хэдий ч онлайн шүүх хурлууд хийгдэж эхэлсэн нь тоглоомын дүрмийг өөрчилж байна гэсэн тодорхой мессежийг өгч чадаж байна. Маргаанаа интернэт шүүхээр хэлэлцүүлэх хүсэлтэй талууд танхимд зохион байгуулагдах шүүх хуралд тохиолддог олон тааламжгүй, тухгүй нөхцөлүүдийг мэдрэхгүй байх боломжтой болж байна. Үүний оронд цахимаар нотлох баримтыг шүүх хуралдааны өмнө ирүүлж, интернэт шүүхийн мэдээллийн санд (түүний нэг сонголт бол шүүхийн блокчейн) хадгалах боломжтой бөгөөд үүнийг шүүх хуралдааны оролцогчид болон шүүхийн шүүгчид хялбархан олж авч, үзүүлж, шалгаж болно. Хятад улс интернэт шүүхийг хөгжүүлэхэд зоримог алхам хийж, асар их хөрөнгө оруулалт

⁵⁸ Supra note 56.

⁵⁹ Legal Daily, “Интернэт шүүхэд зарга мэдүүлэх нь онлайн худалдаа хийхтэй адил хялбар болжээ,” Синхуа ньюс, 2017, http://www.xinhuanet.com/legal/2017-08/19/c_1121508764.htm.

хийснээр Хятад улс хууль зүйн энэ салбарт тэргүүлэгч болсон.⁶⁰

Эцэст нь хэлэхэд, интернэт шүүх байгуулах нь Ардын дээд шүүхийн ухаалаг шүүх төслийн нэр хүндийг өргөж буй нэг бүрэлдэхүүн. Интернэт шүүх нь уламжлалт шүүхээс илүү шинэлэг зүйл хийдэг тул одоо байгаа гурван интернэт шүүх нь Ардын дээд шүүхийн лаборатори шиг ажилладаг бөгөөд хамгийн сүүлийн үеийн хууль эрх зүйн технологи, шинэ дүрмийг турших эсвэл бий болгох боломжтой. Туршсан туршлагаууд дараа нь улсын хэмжээнд бүх шүүхэд тархах боломжтой.

Шүүх бол Хятад дахь хууль зүйн практикийг өөрчилж буй цахим технологийн нэг зангилаа юм. Бидний амьдарч буй цаг үеийн шаардлагаар Хятадын шүүх тогтолцоо энэ чиглэлд шахалтаар орохоос өөр аргагүй байдалд хүрсэн. Магадгүй бүх шүүх хуралдаан удахгүй цахимаар явагдаж ч мэдэх цаг үед бид амьдарч байгаа. Хэдий Хятад улс шүүхийг цахимжуулах уралдаанд ялалт байгуулсан эсэх талаар хэлэхэд эрт байгаа хэдий ч ямар ч гэсэн өөрийн арга барилаар хөгжлийг авчрахаар ажиллаж, бусад улс орныг өөрийн алдаа, онооноос суралцаж дижитал эринд өөрийн шүүх тогтолцоог хөгжүүлээсэй гэж хүсэж байгаа юм.

⁶⁰ Supra note 53.

III ДУРДГАТАЛ

ӨДӨР БОЛГОН ОД ХАРВАДАГГҮЙ

(Ц.Амарсайхан андаа дурсахуй)



ӨДӨР БОЛГОН ОД ХАРВАДАГҮЙ

(Ц.Амарсайхан андаа дурсахуй)

1.

Хүний хайлан, сайхан анд минь 57 насандаа тэнгэрт дэвшлээ. Гурван хүү нь “Зөндөө олон ээжийн дундаас зөвхөн миний ээж л алга уу даа” хэмээн сэтгэлээ өмрүүлж, амар амгалан сайхан амьдралын өмөг түшиг гэргийгээ алдсан хайртай эр нөхөр нь гашуудалд хүлэгдэн хоцорч, мэргэжил нэгтэй андууд нь сайн сайхны дурсамжаас өөр холбогдох шижимгүй болон үлдлээ.

1960-аад оны Улаанбаатар хотод хүн ам харьцангуй цөөн, 400-аад мянгаар тоологдож байсан ч зөв яриа, зөв үйл, зөв бодолтой хүмүүс нь харьцангуй олон байв. Тэдгээр олны хоёр нь болох Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны орлогч дарга “жижиг” Цэнд, гэргий Нийгмийн ухааны институтийн ажилтан Дулам нарт хамгийн отгон хүүхэд, ганц охин нь болж замбуулин хорвоод нэгэн хүмүүн ирсэн нь Ц.Амарсайхан минь бөлгөө.

Дуудах нэрийг нь эцэг эх нь өгдөг, дуурьсах нэрийг өөрөө бүтээдэг гэдэг. Тэрбээр, нийслэлийнхний дунд “орос гурав” гэж алдаршсан, өнгөрсөн ХХ зууны дундуур байгуулсан гадаад хэлээр сургалтаа явуулдаг Ерөнхий боловсролын дунд сургуулийн аравдугаар ангийг 1981 онд бүх хичээлдээ онц дүнтэй, “Алтан медаль”-тай төгссөн сурагч охин байлаа. Сурагчийн ширээн дээр ийнхүү бүтээсэн сайнаар дуурьсах нэрээ Ц.Амарсайхан нь оюутан ахуйдаа бас цааш үргэлжлүүлсэн. Түүнийх нь батламж болсон үзүүлэлтээр манай хойд хөршийн Эрхүү хотын Улсын их сургуулийн хуулийн ангид 1981-1986

онд суралцахдаа Сүхбаатарын цалинтай оюутан (жирийн оюутны тэтгэлэг стипенд дээр нэмж Монгол Улсын Засгийн газраас онц суралцагчдад сар бүр өгдөг мөнгөн урамшуулал), түүнчлэн их сургуулиа дүүргэхдээ онц дүнтэй, Улаан дипломтой төгссөнийг нь энд дурдаж болно.

1980-аад оны дундуур гадаад, дотоодод хуулийн их, дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн олон зуун боловсон хүчин манай улсын хуулийн салбарт ажлын гараагаа эхэлсэн. Тэдний нэг Ц.Амарсайханы ажил байдлын тодорхойлолт бусдын адил даруухан эхэлдэг. Үүнд:

- 1986-1987 он. Улсын дээд шүүхэд дадлагажигч ажилтан
- 1987 он. Улаанбаатар хот болон Районы шүүхэд нарийн бичгийн дарга
- 1987-1989 он. Найрамдлын районы шүүхэд шүүгч
- 1989-1990 он. Улаанбаатар хотын шүүхийн шүүгч гэх мэт.

Харин 26-хан насандаа тэр үеийн хатуу болзол, шалгуурыг давж, шүүхийн удирдлага, хамт олны итгэлийг хүлээж 1990 онд Улаанбаатар хотын шүүхийн Орлогч даргаар томилогдсоноос тэнгэрт дэвших хүртэлх 31 жил нь Монголын хуулийн салбарт түүчээлсэн он жилүүд байлаа. Ц.Амарсайхан нь,

- 1990-1993 он. Улаанбаатар хотын шүүхийн орлогч дарга
- 1993-1999 он. Нийслэлийн шүүхийн шүүгч
- 1999-2005 он. Улсын дээд шүүхийн шүүгч
- 2005-2011 он. Улсын дээд шүүхийн



Иргэний хэргийн танхимын тэргүүн

- 2011 оноос Улсын дээд шүүхийн шүүгчээр ажиллажээ.

2.

Олон зуун мянган үгтэй монгол хэлэнд хуулийн хэллэг, нэр томъёо нь үгийн тусгай сан бүрдүүлж буй. Монголчуудын олонх нь монгол хэлний зөв бичих дүрмийг сайтар эзэмшсэн. Гэхдээ хуульч, эрх зүйчид Хүндэтгэл илэрхийлэх, Үг хувилгах, холбох, Үгийн сан, орчуулгын, Орос бичгийн үсгээр зөв бичих зүйн, Босоо монгол бичгийн, Мэдээллийн техникийн латин үсгийн зэрэг нийт 10 төрлийн дүрмээс Цэг, тэмдгийн дүрмийг бусад салбарынхан, зохиолч сэтгүүлчдээс ч илүү төгс эзэмшин хэрэглэдэг. Ц.Амарсайхан хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахдаа үг, өгүүлбэрийн хаана нь цэг, цэгтэй таслал, таслалтай зураас, хаалт, давхар цэг, штрих тавивал хуулийн зүйл заалт нь хоёрдмол утгагүйгээр Монголын нийт хуульч, эрх зүйчдэд ойлгогдох вэ гэдгийг маш сайн мэддэг, мэдэрдэг нэгэн байсан.

Түүний дээр дурдсан ур чадвараа шингээсэн олон бүтээл, товхимол, зөвлөмж, гарын авлагаас заримыг нь нэрлэвэл,

- Шүүгчийн сургалтын гарын авлага
- Өвлөх эрх ба Иргэний хууль хэрэглэх
- Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал
- Иргэний процессын толь бичгийн тайлбар.

Түүнчлэн Ц.Амарсайхан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгчидтэй хамтран “Монгол Улсын Иргэний хуулийн гэрээний болон гэрээний бус үүрэг”-ийн талаар дэлгэрэнгүй тайлбар номыг цувралаар гаргасан юм. Бас дээр нь мэргэжил нэгт нөхөдтэйгөө хамтран,

- Монголын төр, эрх зүйн үндэс
- Гэрээний эрх зүй
- Шүүгчийн ном гэсэн эрдэм шинжилгээний гурван томоохон бүтээл туурвисан.

Мөн “Нотлох баримтын үнэлгээ”, “Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгийг тогтоож буй шүүхийн практикт анхаарах зарим асуудал”, “Давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх”, “Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа” зэрэг шүүхийн практикт үндэслэн боловсруулсан арга зүйн олон арван Зөвлөмж гаргасны зэрэгцээ Улсын дээд шүүхийн 90 жилийн ойд зориулсан “Монгол шүүх” дэлгэрэнгүй ботийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн түүхэн хөгжил” бүлгийг бичсэн.

3.

Ц.Амарсайхан нийгмийн зүтгэлтэн эмэгтэй байлаа. Нийгмийн зүтгэлтэн гэсэн тодотгол нь зөвхөн улс төрчидтэй холбогддог ойлголт биш л дээ. Төрийн зүтгэлтэн гэвэл зарим улс төрчийг, нийгмийн зүтгэлтэн гэвэл Ц.Амарсайхан шиг хуульчдыг нэрлэхэд зохимжтой буй заа. Тэрбээр эрх, эрх чөлөө, иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах болон нийгмийн сайн сайхны төлөө хоёргүй



сэтгэлээр зүтгэж байсан тул түүнийг нийгмийн зүтгэлтэн байсан гэдэгтэй ам зөрөх хүн байхгүй болов уу.

Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд 5 багц үүрэг ногдуулсан, харин 18 багц эрх олгосон. Манай улс эрхэм зорилгоо “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” хэмээн даяар олноо зарлан тунхагласан. Энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлж, иргэдийн эрхийн төлөө хуулийн хүрээнд ажиллахад Ц.Амарсайханы эзэмшсэн Эрх зүйч мэргэжил нь, сурч мэдсэн Эрдэм боловсрол нь, байгалиас заяагдмал оюунлаг Бүтээлч сэтгэлгээ нь гурвалсан морин тэрэг хөлөглөсөн мэт зохицолтой байв.

Тэрээр 34 жил шүүгчээр ажиллахдаа шүүн таслах ажиллагааг алдаа зөрчилгүй явуулахад онцгойлон анхаарч, олон арван мянган иргэний хэргийг эрх зүйн онолд үндэслэн хууль хэрэглээний өндөр түвшинд мэргэжлийн хосгүй ур чадвар гарган хянан шийдвэрлэж, олон мянган хүн, хуулийн этгээдийн зөрчигдсэн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг сэргээн тогтоосон түүний эрхэлсэн албандаа хэрхэн хандаж байсны тод жишээ юм.

Үндсэн хуульд Улсын дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан. Эрх гэж эерэг сонсогдож байгаа ч бодит байдалдаа Дээд шүүхийн шүүгчдэд ногдуулсан үүрэг болж хувирдаг. УИХ-аас баталсан хууль нь цаг үеийн шалгуурыг даахгүй бол эрхэм гишүүд нь шинэчлэн найруулж нэмж, өөрчилсөн заалт оруулж уг хуулиа засан сайжруулаад дахин батлан гаргах нь нээлттэй, ийм

тохиолдол олонтоо гардаг. Харин Дээд шүүхийн шүүгчдээс хуулийн зүйл заалтыг иргэд, эрх зүйч, хуульчдад нэгэн мөр болгон тайлбарлаж гаргасан Тогтоол бол дараа нь засварлаж болдоггүй эцсийнх учраас ямар ч алдаагүй байдгаараа онцгой. Энэхүү алдаагүй “мөнх”-ийн Тогтоол боловсруулахад Ц.Амарсайхан түүчээлж явлаа. Тэрбээр хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан Улсын дээд шүүхийн олон арван тогтоолыг дагнаж болон бусад шүүгчтэй хамтран боловсруулж батлуулсан нь хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэхэд “Алтан гадас” од мэт зүг чигийг заасаар байна.

Үүнд, Гэр бүлийн тухай, Шүүхийн тухай, Прокурорын тухай, Өмгөөллийн тухай, Хуульчдаас сонгон шалгаруулах тухай, Төрийн албаны тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай, Автотээврийн тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хариуцлагын тухай, УИХ-ын сонгуулийн тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх



тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай, Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны харьяаллаас зааглан ялгах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай гэх мэтээр жагсаалт хөвөрнө.

Хүний өөрийгөө нээж хөгжүүлсэн боловсрол, хувь хүний зан суртахууны төлөвшил, ёс зүйн өгөгдлийг эзэмшсэн байдал-хандлагыг мэргэжлийн мэдлэг, мэргэшлийн түвшинтэй нь харгалзуулан үнэлэх буюу хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулах явдал нь нэн ээдрээтэй, амаргүй ажил гэдэг нь ойлгомжтой.

Тэгвэл Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүн, даргаар ажиллахдаа Ц.Амарсайханы маань мэргэн хараа, холч ухаанаар шилж сонгосон шилдэг шүүгч нарын нуруун дээр өнөөдрийн шүүх оршиж байна. Түүний маань дэг сургуулиар бэлтгэгдсэн шилдэг шүүгч-мэргэжилтнүүд урьд хожид байгаагүй эрх зүйн нэгдсэн шийдлийн арга зүйг хамтдаа бүтээлцэж, хүний эрх, эрх чөлөөний зааг хязгаараар төрийн үйл ажиллагаа өрнөх ёстой гэдэг хатуу номлол, "алтан зарчим"-аар замнаж, шүүхээр зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж буйг дурдахгүй өнгөрөхийн аргагүй.

4.

Дэлхийн хүн амын наян хувь нь англи хэлийг цахим сүлжээ, компьютер, ухаалаг гар утсаараа дамжуулан харилцааны

хэрэглүүр болгон тодорхой түвшинд ашигладаг гэсэн судалгаа бий. Бидний монголчууд ч үүнд багтаж байгаа. Харин Эх газрын хуультай манайд герман хэлтэй эрх зүйч харьцангуй цөөн байдаг нь учир дутагдалтай. Нэгэнт Англи-Саксоны хэмээх Далайн орнуудын хуулийг жишиг болгон авч хэрэглэлгүй, Грек-Ромын гэгддэг Германы бичмэл хуулийг сонгож Монгол Улсын хууль эрх зүйн салбарт нутагшуулсан болохоор герман хэлтэй боловсон хүчин урьд өмнө нь ч ус агаар шиг хэрэгтэй байсан, одоо ч хэрэгтэй байна. Унаган орос, англи хэлтэй Ц.Амарсайхан сайх зохилдлогыг анзаарсан учраас оюутан байхаасаа герман хэлийг шамдан суралцжээ.

Ц.Амарсайхан Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс манай улсад "Монголын хуульчдын сургалт ба давтан сургалт", "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах" төсөл хэрэгжүүлэхэд гол зуучлагч байсан бөгөөд улмаар төслийн хүрээнд шүүгчдэд хичээл заахдаа герман хэлний мэдлэгээ өөрийн давуу тал болгож байлаа. Тэрбээр тус төслийн сургалтын анхны "шүүгч-багш" болсноос хойш тасралтгүй хорь гаруй жил багшилжээ. ХБНГУ-ын мэргэжил нэгтнүүдтэй хамтран "Монгол Улсын Иргэний хуулийн дэлгэрэнгүй тайлбар"-ыг зохиосны зэрэгцээ өөрийн орны эрдэмтэн судлаачидтай хамтран ОХУ-ын эрдэмтэн Н.Богуславскийн алдартай бүтээл "Олон улсын иргэний эрх зүй" номыг монгол хэлнээ хөрвүүлэн хэвлүүлэн гаргасан. Ц.Амарсайхан нь ХБНГУ-д шүүн таслах ажиллагааны чиглэлээр анхан болон давж заалдах шатны шүүхүүдэд



мэргэжил дээшлүүлэх урт хугацааны дадлага хийсэн анхны монгол шүүгч юм.

5.

Ц.Амарсайхан сайн багш, нэртэй сурган хүмүүжүүлэгч байлаа. Түүний “номын дуу” сонссон хэн боловч хичээл заалгасан үргэлжлэх хугацаанаас буюу хэдхэн цаг, хэдэн өдөр, олон сараас үл хамаарч Ц.Амарсайханаас олж авсан мэдлэгээрээ бахархаж “Шавийн эрдэм багшаасаа” гэдэг нэгэн гайхамшигт үнэнтэй нүүр тулсан байдаг. Тэрбээр,

- Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн Шүүгчдийн сургалтын дэд хорооны даргын албыг 2005-2010 онд хашиж байхдаа Шүүгчдийн анхан, дунд, дээд шатны сургалтыг зохион байгуулж өөрийнхөө боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу “Иргэний болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” гэсэн хичээлийг Нийслэл, дүүрэг, орон нутгийн шүүхийн шүүгчдэд зааж байв.
- МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд багшилж Олон улсын нийтийн болон Иргэний эрх зүй, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, Гэр бүлийн

эрх зүй, Гэрээний болон гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх гэсэн хичээлийг тус сургуулийн Үндсэн, Эчнээ, Түргэвчилсэн ангийн төгсөх курсийн оюутнуудад зааж байжээ.

Энд Монголын хууль зүйн салбарт сурган хүмүүжүүлэгчийн хувьд Ц.Амарсайханы оруулсан оюуны хөрөнгө оруулалтын багахан хэсгийг дурдлаа.

6.

Өдөр болгон од харвадаггүй гэдэг. Ц.Амарсайхан маань Монголын Иргэний эрх зүйн салбарт мэргэжил, мэргэшлээрээ гялалзагч од байлаа. Өдөр болгон харваад байхаар тийм элбэг бус, дэндүү цөөхөн оддын нэг явсан анд минь тэнгэрт дэвшлээ. Юутай харамсалтай, юутай эмгэнэлтэй. Гэхдээ амьдадаа домог болсон түүний маань эгэл даруу, элэгсэг дотно дүр төрх, олноос онцгойрсон энгүй их хөдөлмөрч, оюунлаг, ухаалаг, бүтээлч, шударга зан чанар, хэвшмэл бус сэтгэлгээ, хүний төлөө гэсэн сайхан сэтгэл нь шүүгч, хуульчдын дунд үлгэр дуурайлал болон үлдэж буйд нь жаахан ч гэсэн сэтгэл уужирнам.

АНД НӨХӨД НЬ